МОНГОЛ УЛСЫН ТЕХНИК, МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТЫН САЛБАРЫГ ДЭМЖИХ ТӨСӨЛ-1



# МБС-ын Англи - Монгол тайлбар толь

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ

МОНГОЛ УЛСЫН ТЕХНИК, МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТЫН САЛБАРЫГ ДЭМЖИХ ТӨСӨЛ-1

VETP МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТ ТҮНШЛЭЛ

# МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТЫН САЛБАРЫН НЭР ТОМЬЁОНЫ МОНГОЛ-АНГЛИ ТАЙЛБАР ТОЛЬ

## MONGOLIAN-ENGLISH GLOSSARY OF TERMINOLOGIES TECHNICAL, VOCATIONAL EDUCATION AND TRAINING

*Европын холбооны санхүүжилтээр*
*ГОПА олон улсын зөвлөх компани, Германы хамтын ажиллагааны*
*нийгэмлэгийн хамтарсан консорциум хэрэгжүүлж буй*
*Монгол Улсын техник, мэргэжлийн боловсрол,*
*сургалтын салбарыг дэмжих төсөл-1*

GOPA WORLDWIDE CONSULTANTS

giz IS International Services

*Улаанбаатар хот*
*2018 он*

**ДАА-370**
**ННА-74**
**О-634**

# МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТЫН САЛБАРЫН НЭР ТОМЬЁОНЫ МОНГОЛ-АНГЛИ ТАЙЛБАР ТОЛЬ

# MONGOLIAN-ENGLISH GLOSSARY OF TERMINOLOGIES TECHNICAL, VOCATIONAL EDUCATION AND TRAINING

**Эмхэтгэн боловсруулсан:**

| | |
|---|---|
| А.Оюун | *Мэргэжлийн боловсрол сургалтын салбарын бие даасан зөвлөх* |
| Ч.Тунгалаг | *Мэргэжлийн боловсрол сургалт түншлэл ТББ-ын гүйцэтгэх захирал* |
| Жорж Колат | *ЕХ-ны Монгол Улсын техник, мэргэжлийн боловсрол сургалтын салбарыг дэмжих төсөл-1-ийн үндсэн мэргэжилтэн* |

**Хэвлэлд бэлтгэсэн:**

| | |
|---|---|
| Р.Болормаа | *ЕХ-ны Монгол Улсын техник, мэргэжлийн боловсрол сургалтын салбарыг дэмжих төсөл-1-ийн ажилтан* |

MGL DESIGN Хэвлэлийн компанид хэвлэв

© *Энэхүү нэр томьёоны тайлбар толийг зөвшөөрөлгүйгээр хуулбарлан олшруулахыг хориглоно.*

*ISBN: 978-99 978-2-177-5*

*Улаанбаатар хот, 2018 он*

# ӨМНӨХ ҮГ

Мэргэжлийн боловсрол, сургалтын салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хамтын ажиллагааг өргөжүүлэх, удирдлага, багш ажилтныг чадавхжуулах, нийгмийн түншлэлийг хөгжүүлэхэд хувь нэмэрээ оруулан ажиллаж байгаа эрхэм хамтрагч танд МБС-ын салбарт түгээмэл хэрэглэгддэг үгсийг нэгтгэсэн тайлбар толийг хүргэж буйдаа баяртай байна.

Монгол Улсын техник, мэргэжлийн боловсрол, сургалтын салбарын шинэчлэл, хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн чадварлаг, тогтвортой ажиллах хүчнийг бэлтгэх, мэргэшлийн үндэсний хүрээ, чанарын баталгаажуулалтын тогтолцоог бүрдүүлэх, түншлэгчдийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, мэргэжлийн боловсрол, сургалтын талаар нэгдсэн ойлголттой болохын хамт зарим шинэ нэр, томьёог зөв хэрэглэх боломжийг олгох зорилгоор тус салбарт түгээмэл хэрэглэгддэг 270 гаруй үгийг тодорхой тайлбарын хамт монгол-англи хэл дээр бэлтгэн гаргалаа.

Тайлбар тольд түгээмэл хэрэглэгддэг баримт бичгийн нэр томьёо, үндсэн ойлголт, тодорхойлолтуудыг эх сурвалжийн хамт монгол-англи хэл дээр нэгтгэхийн зэрэгцээ хөдөлмөрийн салбарт түгээмэл ашиглагддаг нэр томьёог багтаасанаараа онцлог. Тиймээс бидний бэлтгэсэн энэхүү тайлбар толь нь МБС-ын салбарын шинэчлэл, хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийг хангах, мэргэшлийн түвшний үндэсний тогтолцоог төлөвшүүлэх, чадамжид суурилсан сургалтын тогтолцоог хэрэгжүүлэгч оролцогч талууд, төр, хувийн хэвшлийн холбогдох байгууллага, ажил олгогч, МБС-ын багш, суралцагч, судлаач хэн бүхний хэрэгцээнд нийцнэ гэдэгт итгэлтэй байна.

Салбарын нэр томьёоны тайлбар толийг санаачлахаас эхлээд нэгтгэн боловсруулах, орчуулах зэрэг бүхий л үе шатанд хамтран мэдлэг оюун, сэтгэл зүрхээрээ дэмжиж ажилласан Ажлын хэсгийн гишүүддээ болон санхүүгийн дэмжлэг үзүүлсэн "Монгол Улсын техник, мэргэжлийн боловсрол, сургалтын салбарыг дэмжих-1" төслийн хамт олонд чин сэтгэлийн талархал илэрхийлье.

Та бидний хамтдаа бүтээсэн энэхүү тайлбар толь нь олон улсын жишигт нийцсэн шинэ ойлголтуудыг танин мэдэх, бэрхшээлтэй асуудлуудыг шийдвэрлэх, бодлогын баримт бичгүүд, гарын авлага, сургалтын материалуудыг боловсруулах, төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх зэргээр өдөр тутмын ажилд минь үнэтэй туслагч байх нь дамжиггүй.

Энэхүү толь бичгийг цаашид улам боловсронгуй баялаг болгохын тулд та бүхний санал, зөвлөмжийг хүлээн авахдаа таатай байх болно. Та бүхэн санал хүсэлтээ МБС-ын түншлэл ТББ-ын info@vetp.mn хаягаар ирүүлээрэй.

Эрдэм номын хишиг арвин байх болтугай!

ХНХЯ-ны Мэргэжлийн боловсрол,
сургалтын хэлтсийн дарга,
Ажлын хэсгийн ахлагч А. ХАЛИУНАА

# FOREWORD

I am delighted to present this Mongolian-English TVET Glossary of Terminologies to our partners who contribute to the development of social partnership, capacity building for teachers and managers, expanding cooperation among the stakeholders, and the improvement of legal framework on vocational education and training.

We are publishing this bilingual glossary which contains approximately 270 popular terms used in vocational education and training in order to provide support for modernization of technical and vocational education training, preparation of sustainable and highly skilled workforce demanded by the Mongolian labor market, establishment of a fit-for-purpose quality assurance system and a national qualification framework for vocational training, introduce integrated and consistent understanding of VET and ensure the accurate usage of new terminologies.

This glossary has been developed based on international best practices and the state-of-the-art innovations in the sector including very specific terminologies, main concepts, and widely accepted phrases frequently used in vocational education and training with appropriate reference to the main sources.

This Mongolian-English glossary would be a useful tool that mostly addresses the needs of individuals, public-private partners, employers, researchers, teachers, trainees, vocational education institutions and competence based training (CBT) stakeholders, in order to meet the labor market demand and for the advancement of vocational education and training sector as well as the establishment of national system of qualification.

My sincere appreciation goes to all the members of the Quality Assurance Working Group for their sustained efforts and continued support during all the stages of design and multiple reviews and to the EU STVET-1 Project team for their generous financial support.

I strongly believe that this glossary would be an excellent source of reference for further implementation of programs and projects in the sector, development of handbooks, policy documents and training materials, and serves as a recognition of international new concepts.

We would be glad to receive your suggestions to make improvements in this glossary in the future. Please send your comments and suggestions to info@vetp.mn.

May all wishes returns to you.

A. KHALIUNAA

Chair, Quality Assurance Working Group
MoLSP, Head of VET Division
Ulaanbaatar, Mongolia

## АЖЛЫН ХЭСГИЙН ГИШҮҮД:

**Ахлагч:**

| | |
|---|---|
| А.Халиунаа | *Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Мэргэжлийн боловсрол, сургалтын хэлтсийн дарга* |

**Гишүүд:**

| | |
|---|---|
| Д.Бэхбат | *Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газрын Мэргэжлийн боловсролын бодлогын хэрэгжилтийн газрын дарга* |
| Ц.Батдорж | *Мэргэжлийн боловсрол, сургалтын Үнэлгээний төвийн дарга* |
| Билл Фейрбэйн | *ЕХ-ны Монгол Улсын техник, мэргэжлийн боловсрол сургалтын салбарыг дэмжих төсөл-1-ийн удирдагч* |
| Ц.Цэрэндэжид | *ЕХ-ны Монгол Улсын техник, мэргэжлийн боловсрол сургалтын салбарыг дэмжих төсөл-1-ийн орчуулагч* |
| Б.Алтанчимэг | *Боловсролын магадлан итгэмжлэх Үндэсний зөвлөлийн ахлах мэргэжилтэн* |
| С.Болормаа | *ЕХ-ны Монгол Улсын техник, мэргэжлийн боловсрол сургалтын салбарыг дэмжих төсөл-2-ийн зохицуулагч* |
| С.Лувсанвандан | *Мэргэжлийн боловсрол, сургалтын Үнэлгээний төвийн мэргэжилтэн* |
| Т.Гриета | *ЕХ-ны Монгол Улсад ажлын байрыг нэмэгдүүлэх, хөдөлмөр эрхлэлтийн бодлогод дэмжлэг үзүүлэх төслийн Үндсэн мэргэжилтэн* |
| Ч.Долгорсүрэн | *ЕХ-ны Монгол Улсад ажлын байрыг нэмэгдүүлэх, хөдөлмөр эрхлэлтийн бодлогод дэмжлэг үзүүлэх төслийн ажилтан* |
| М.Галсансар | *Швейцарийн хөгжлийн агентлагийн Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төслийн мэргэжилтэн* |
| Ц.Ганчимэг | *Азийн Хөгжлийн Банкны Хөдөлмөр эрхлэлтийн ур чадварыг дэмжих төслийн мэргэжилтэн* |
| Д.Чулуунцэцэг | *Биологийн олон янз байдал ба Уур амьсгалын өөрчлөлтөнд ойн гол экосистемүүдийн дасан зохицох нь II хөтөлбөрийн дэд захирал* |
| Д.Оюунаа | *Түншлэлд суурилсан мэргэжлийн боловсрол, сургалт төслийн ахлах мэргэжилтэн* |
| М.Энхжаргал | *Улаанбаатар бүсийн арга зүйн төвийн менежер* |
| Ч.Мөнгөнсор | *Мэргэжлийн боловсрол сургалт түншлэл ТББ-ын мэргэжилтэн* |
| С.Цэнд-Аюуш | *Мэргэжлийн боловсрол сургалт түншлэл ТББ-ын мэргэжилтэн* |

# A

1 **Авьяас чадварын сорил**

Тодорхой ур чадварт суралцах хувь хүний авьяас чадварыг үнэлэх стандартчилсан сорил

Тус сорилыг аливаа үйл ажиллагааг гүйцэтгэх хувь хүний авьяас, чадварыг тодорхойлох зорилгоор ашигладаг. Авьяас, чадварын сорил нь хүн бүр төрөлхийн сул болон давуу талуудтай бөгөөд хувь хүний онцлог зан чанараас хамааран тодорхой үйл хэрэгт амжилт гаргах эсвэл бүтэлгүйтэх хандлагатай байдаг гэсэн таамаглалыг дэвшүүлдэг. Энэхүү сорилоор хувь хүний мэдлэгийг шалгадаггүй тул тус сорилд бэлтгэн суралцах боломжгүй юм.

***Эх сурвалж:*** https://www.merriam-webster.com/dictionary

**Aptitude test**

A standardized test designed to predict an individual's ability to learn certain skills.

It is a test used to determine an individual's inclination to succeed in a given activity. Aptitude tests assume that individuals have inherent strengths and weaknesses, and are naturally inclined toward success or failure in certain areas based on their innate characteristics.

An aptitude test does not test knowledge and it is not a test for which one can study.

***Source:*** https://www.merriam-webster.com/dictionary

2 **Аж ахуйн нэгж**

Улсын бүртгэлд бүртгэгдэж, аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж байгаа компани, нөхөрлөл, хоршоо, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар, тэдгээртэй адилтгах орлогын албан татвар төлөх үүрэг бүхий хуулийн этгээд.

Аж ахуй нэгж нь корпорац, корпорацын шинжтэй, ашгийн бус, эсвэл хувь нийлүүлээгүй аж ахуй байж болно.

***Эх сурвалж:*** Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай МУ-ын хууль, 2006
ОУ –ын статистикийн нэр томьёоны тайлбар толь, ЭЗХХАБ, 2001

**Enterprise or Company**

A state- registered legal entity obliged to pay income tax, such as an industry owned by the local government and state, cooperative, partnership and company engaged in business activities.

An enterprise may be a corporation, a quasi-corporation, a non-profit institution, or an unincorporated enterprise.

***Source:*** Law of Mongolia on Corporate Income Tax , 2006
Glossary of Statistical Terms, OECD, 2001

3 **Аж ахуйн нэгжид суурилсан хөтөлбөр**

Аж ахуй нэгж/компаний хүрээнд хэрэгжүүлдэг сургалтын хөтөлбөр.

Тус хөтөлбөр нь дараах хэлбэрүүдтэй байж болно:

1. Дагалдуулан сургах хөтөлбөр;
2. Ажиллангаа суралцах хөтөлбөр;
3. Хосмог сургалтын хөтөлбөр.

***Эх сурвалж:*** ТМБС-ын тайлбар толь, ТБУЧХА, Филиппин, 2010

**Enterprise-based program**

Training program being implemented within companies/firms. These programs can be any of the following:

1. Apprenticeship Program;
2. Learnership Program; and,
3. Dual Training Program.

***Source***: The TVET Glossary of Terms, TESDA Philippines, 2010

**4 Аж ахуйн нэгжийн оролцоо**

Аж ахуй нэгжийн оролцоо гэдэг нь үндэсний болон орон нутгийн түвшинд үйлдвэр, аж ахуйн нэгжүүд ТМБС-ын хөтөлбөрийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх болон хяналт тавих оролцоог хэлнэ.

Үүнд дараах стратеги хамаарах хэдий ч үүгээр хязгаарлагдахгүй.

- Үндэсний болон орон нутгийн ажил олгогч бизнесийн байгууллага, үйлдвэр, аж ахуй нэгжүүдтэй түншлэх;
- Ажил олгогчдын төлөөллийг аж үйлдвэрийн зөвлөх хороо болон холбогдох ажлын хэсгүүдэд татан оролцуулах
- Аж ахуйн нэгжийн ажилтнуудыг нэг баг болгон нягтруулах;
- Үйлдвэр, аж ахуйн нэгж, мэргэжлийн байгууллага, ажил олгогч нартай тогтмол харилцаа холбоо тогтоох;
- Үнэлгээний баталгаажуулалтад оролцох ажил олгогч, үйлдвэр, аж ахуйн нэгжийн төлөөлөлтэй холбоо тогтоох, хамтрах;
- Ажил олгогч, үйлдвэр аж ахуйн нэгж болон бусад сүлжээг ашиглан мэдлэг мэдээлэл, хүний нөөц болон бусад нөөц боломжоо солилцох.

***Эх сурвалж:*** Тусгай зөвшөөрөлтэй сургалтын байгууллагын стандарт Австрали, 2015

**Industry engagement**

Industry engagement is the act of involving various industry stakeholders to support the implementation and monitoring of TVET programmes nationally and locally.

This may include, but is not limited to, strategies such as:

a) partnering with local employers, regional/national businesses, relevant industry bodies and/or enterprises;
b) involving employer nominees (representatives) in industry advisory committees and/or reference groups;
c) embedding VET staff within enterprises;
d) networking in an on-going way with industry networks, professional bodies and/or employers;
e) developing networks of relevant employers and industry

representatives to participate in assessment validation; and,
f) exchanging knowledge, staff, and/or resources with employers, networks and industry bodies.

***Source**:* Standards for Registered Training Organisations (RTOs) Australia, 2015

**5 Аж үйлдвэр**

Сургалтын байгууллагаас үзүүлдэг үйлчилгээг дэмжигч оролцогч талуудыг аж үйлдвэр гэнэ. Үүнд дараах байгууллагууд орно:
a) аж ахуйн нэгж/ үйлдвэрийн харилцагч, тухайлбал ажил олгогч;
b) сургалтын байгууллагын холбоо;
c) аж үйлдвэрийн байгууллага;
d) аж үйлдвэрийн салбарын зохицуулагч байгууллага;
e) аж үйлдвэрийн мэргэжлийн зөвлөл, эсвэл ижил төстэй байгууллага;
f) Аж үйлдвэрийн сургалтын зөвлөл;
g) Мэргэжлийн холбоод.

***Эх сурвалж:*** Тусгай зөвшөөрөлтэй сургалтын байгууллагын стандарт, Австрали, 2015

**Industry**

Industry means the bodies that have a stake in the services provided by training providers.

These can include, but are not limited to:
a) enterprise/industry clients, e.g. employers;
b) group training organisations;
c) industry organisations;
d) industry regulators;
e) industry skills councils or similar bodies;
f) industry training advisory bodies; and
g) unions.

***Source**:* Standards for Registered Training Organisations (RTOs), Australia, 2015

**6 Ажил**

Ажил гэдэг нь хувиараа хөдөлмөр эрхлэгч, эсвэл ажил олгогчид зориулан гүйцэтгэдэг эсвэл гүйцэтгэх шаардлагатай багц үүрэг, ажилбарыг хэлнэ.

Гүйцэтгэдэг эсвэл гүйцэтгэх шаардлагатай ажил, үүргийн төрлөөс хамааран ажил мэргэжлүүдийг ангилна.

***Эх сурвалж:*** ОУХБ-ын /ОУ-ын Ажил мэргэжлийн ангилал (ISCO 88)

**Job**

A job is a set of tasks and duties performed, or meant to be performed, by one person, including for an employer or in self employment.

Jobs are classified by occupations with respect to the type of work performed, or to be performed.

***Source***: ILO/International Standard Classification of Occupations (ISCO 88)

| | | |
|---|---|---|
| 7 | **Ажил мэргэжлийн танилцуулга** | Ерөнхий боловсролын сургуулийн сурагч, иргэдэд зориулсан ажил, мэргэжлийн төрөл, хэв шинж, ажил эрхлэлтийн байдал, ажлын байрны талаарх танилцуулга.<br><br>Үүнд тухайн мэргэжлээр суралцах боломжит арга зам болон мэргэжлийн боловсрол, сургалтын төрөл, хэлбэрийн талаарх мэдээлэл багтана.<br><br>***Эх сурвалж:*** Мэргэжлийн боловсрол, сургалт, мэргэшлийн түвшний тогтолцооны нэр томьёоны тайлбар толь, (МСС), УБ,2011 |
| | **Job guide** | A catalogue for citizens and general education school students to introduce the type, feature, employment and workplace relating to occupations.<br><br>This includes information on types and possible methods to learn the occupation and vocational education and training.<br><br>***Source***: Glossary of Terms for Vocational Education, Training and National Qualifications System, (MCA), UB, 2011 |
| 8 | **Ажил мэргэжлээ өөрчлөх** | Шинэ ажилтай болох зорилт тавьж ажил мэргэжлээ өөрчлөх.<br><br>Амьдралынхаа хугацаанд хүн дунджаар 3-5 удаа ажил мэргэжлээ сольдог гэсэн таамаглалыг экспертүүд дэвшүүлсэн.<br><br>Ийнхүү ажил мэргэжлээ өөрчлөх шалтгаан нь хувь хүн ажилдаа сэтгэл хангалуун бус эсвэл тухайн мэргэжлээрээ мэргэжил дээшлүүлэх, дэвших боломжгүй болсонтой холбоотой байдаг.<br><br>***Эх сурвалж:*** https://www.livecareer.com/quintessential/glossary |
| | **Career change** | Changing one’s occupation (from one group of jobs to another) by devising a strategy to find new career choices.<br><br>Most experts now predict that the average person will change careers three to five times over the course of his or her work life. Change may occur because you don’t enjoy the work as much as you used to. Or maybe you can’t progress further in your career.<br><br>***Source***: https://www.livecareer.com/quintessential/glossary |
| 9 | **Ажил, мэргэжлийн дүн шинжилгээ** | Ажиглалт, ярилцлага, судалгаа хийх замаар аливаа ажил мэргэжлийн техникийн болон орчны хүчин зүйл, ажилтанд тавигдах шаардлага, гүйцэтгэх үйл ажиллагаар тодорхойлох нарийвчилсан дүн шинжилгээ хийх арга хэлбэр.<br>Тухайн ажил, мэргэжлийн хүрээнд гүйцэтгэх үүрэг, ажилбарыг тодорхойлохын зэрэгцээ ажил, үүргийг гүйцэтгэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар, хандлага, хариуцлагыг тодорхойлох үйл ажиллагааг хэлнэ.<br><br>***Эх сурвалж:*** ТМБС-ын тайлбар толь, ТБУЧХА, Филиппин, 2010 |

**Occupational analysis**

A specialised analysis method for identifying the activities and requirements of workers (related to a job) and the technical and environmental factors of the occupation through observation, interview and study.

It comprises identifying the tasks involved in the occupation together with the skills, knowledge, aptitudes and responsibilities that are required from the worker for the correct performance of the occupation, which facilitates its differentiation among the rest.

***Source***: The TVET Glossary of Terms, TESDA, Philippines, 2010

10 **Ажил, мэргэжлийн ангилал**

Ажил, мэргэжлүүдийг бүлэглэх, ангилах, эрэмбэлэхийг хэлнэ. Ажил, мэргэжлийн ангиллын хамгийн жижиг нэгж болох ажил нь тодорхой албан тушаалын хүрээ буюу хувь хүний хийж гүйцэтгэх багц ажилбаруудаар тодорхойлогдоно.

Ажил, мэргэжлүүд нь гүйцэтгэх үүрэг, ажилбараас гадна ур чадвар, хариуцлага, орлого, ажилд ороход тавигдах шаардлага, нэр хүнд зэрэг холбогдох шинж чанараар тодорхойлогддог.
Олон улсын хөдөлмөрийн байгууллагын гаргасан Олон улсын Ажил, мэргэжлийн стандарт ангилал нь хамгийн түгээмэл хэрэглэгддэг.

***Эх сурвалж:*** Социологийн толь бичиг, Оксфорд, 2009

**Occupational Classification**

This is grouping and ranking of jobs and occupations into categories. Occupation is often synonymous with job but may refer to a group of similar jobs identified with a common occupational title.

The smallest unit of an occupational classification is the concept of a job, defined as a set of tasks to be performed by an individual, and commonly identified by a job title. Jobs and occupations can be described not only in terms of tasks, but also in terms of associated characteristics such as skill, responsibility, earnings, entry qualifications, and prestige.
The most common occupational classification is the International Standard Classification of Occupations (ISCO) developed by the International Labour Organization.

***Source:*** A Dictionary of Sociology, Oxford, 2009

11 **Ажил мэргэжлийн лавлах**

Тодорхой ажил, мэргэжилд хамаарах үүрэг ажилбарын цогц ба тэдгээрийг гүйцэтгэхэд шаардлагатай мэдлэг, чадвар, хандлагыг тодорхойлно.

Монгол улсын “Үндэсний ажил мэргэжлийн ангилал ба тодорхойлолт”-д (ISCO-08 буюу YAMAT–08) ижил мэргэжлүүдийг ерөнхий болон дэд бүлэг болгож мэргэжлийн чиглэлээр харуулсан байна.

***Тайлбар***:
Мэргэжлийн чиг үүргийг тодорхойлох бодит шаардлага, хэрэгцээ нь ажил олгогчдын оролцооноос ихээхэн хамаарах ёстой.

Ялангуяа энэ нь оновчтой төлөвлөлт хийх, мэргэжлийн ажилтнаа сонгож авах, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөхөд нэн чухал юм.
Тухайн ажлын байранд гүйцэтгэх ажил, үүргүүд, ажлын орчин нөхцөл, ажилтны биеэ авч явах байдал, зан төлөв, боловсрол болон гэрчилгээ, хөдөлмөр эрхлэх болон өсөн дэвших боломж, цалин хөлсний талаарх бүрэн мэдээллийг агуулдаг.

***Эх сурвалж:*** Үндэсний Ажил Мэргэжлийн Ангилал, тодорхойлолт, 2010
Мэргэжлийн ба Боловсролын нэр томьёо, Европын сан

**Occupational profile**

Set of duties and tasks and type of skills and knowledge attitude form vital for perfroming responsibilities related to specific occupation and qualification.

The Mongolian National Occupational Classification and Definition (YAMAT 08 and ISCO08) reflects occupational profile of same occupations in general and sub chapters.

***Note:***
Real need and requirements to define occupational profile should largely depend on involvement of employers. It is most important for proper planning and selection of vocational workers, provide career guidance and counseling.

It is a full description of a job’s related duties, working conditions, required personal characteristics, education and certifications, employment and advancement opportunities, and wage and salary information.

***Source***: Mongolian National Occupational Classification, 2010
Occupational and Educational Terms, European Foundation

**12 Ажил, мэргэжилд бэлтгэх сургалт**

Суралцагчдыг хөдөлмөр эрхлэлт, ажил мэргэжилд бэлтгэх ажил, мэргэжлийн хүрээнд гүйцэтгэх үйл ажиллагаатай танилцуулахад чиглэсэн боловсрол, сургалтын үйл ажиллагаа.

***Тайлбар***:
Ажил, мэргэжилд бэлтгэх боловсрол, сургалтын зорилго нь өргөн утгаараа хүмүүсийг ажлын талбарт гарах, хөдөлмөр эрхлэхэд шаардлагатай болон ажил олгогчдоос тавьдаг үндсэн чадвар, дадлыг олгоход оршино.

Олон улс оронд ажил, мэргэжилд бэлтгэх боловсрол, сургалт нь дунд боловсролын хөтөлбөрт багтсан байдаг.

Ажил, мэргэжилд бэлтгэх сургалт гэдэгт мэргэжлийн боловсрол, сургалт эсвэл ажил хөдөлмөрт хүмүүсийг бэлдэх зорилгоор англи хэл, тоо, хэл бичиг, компьютерийн болон ажил эрхлэх ур чадвар олгох сургалтууд багтана.

Ажил, мэргэжилд бэлтгэх сургалтыг анхан шатны мэргэжлийн боловсрол, сургалт буюу техникийн боловсролтой хольж хутгаж үл болно. Ажил, мэргэжилд бэлтгэх сургалт нь цагаач иргэд,

гадаадын оюутнууд болон ажиллах хүчний эгнээнд эргэн орохыг эрмэлзэж буй насанд хүрэгчдэд зориулсан ажил, мэргэжлийн удирдамж, чиглэлээр хангах сургалт юм. Залуусыг янз бүрийн ажил, мэргэжилд ашиглагддаг материал, багаж хэрэгсэл, стандартуудтай танилцуулах замаар тэднийг ажил, мэргэжлийн эсвэл цаашдын сургалтын чиглэлээ сонгоход нь бэлтгэхэд чиглэгдсэн сургалт.

***Эх сурвалж:*** МБС мэргэшлийн түвшний тогтолцооны нэр томьёоны тайлбар толь, (МСС), УБ, 2011

**Pre-vocational course**

Education and training activity aiming to familiarize learners with profession, qualification, employment and labor activities.

***Note***:
In a broder context, the purpose of pre-vocational education and training is to provide people with main skills and practice necessary for employment world, employers and essence of labor.

It's a component of secondary education program in many countries *Pre-vocational course* is designed to prepare people for vocational education and training or work, including bridging courses, English, Literacy and Numeracy, or training in job skills.

Pre-vocational course should not be understood equal to initial vocational education and training or technical education. It's a pre-vocational course and training to prepare for further learning, which provides adults eager to return to work and foreign students and immigrants with professional direction and guide.

First of all it's a training to prepare youth for the selection of further training or occupation by familiarizing them with standards, tools and material related to different types of occupations.

***Source***: Glossary of Terms for Vocational Education, Training and National Qualifications System, (MCA), UB, 2011

13 **Ажил, үүргийн дүн шинжилгээ**

Ажил мэргэжлийн тодорхойлолт, ялангуяа ажил, мэргэжлийг амжилттай гүйцэтгэхэд шаардлагатай чадамжуудыг тодорхойлох арга техник.
Жишээ нь: Нийтлэг ажил, мэргэжил (зочлох үйлчилгээ), тодорхой салбар (зочид буудал) эсвэл тодорхой мэргэжилд (тогооч) хамааралтай ажил төрлүүд багтана.

***Эх сурвалж:*** ТМБС-ын тайлбар толь, ТБУЧХА, Филиппин, 2010

**Functional analysis**

A methodology or technique for developing occupational specifications, particularly the competencies required in a productive function which may be a broad function (hospitality), an occupation (hotel), or a specific job (Chef).

Ideally, this is carried out by a group of workers who are familiar with the function or object of the analysis (of the sector/occupation).

***Source***: The TVET Glossary of Terms, TESDA, Philippines, 2010

**14 Ажил эрхэлдэг хүн буюу ажилтан**

Ажилтай, бизнес эрхэлдэг, фермд ажилладаг ажилтан, ажил олгогч, хувиараа хөдөлмөр эрхлэгч, өрхийн аж ахуй эрхэлдэг зэрэг хүмүүсийг хэлнэ.
Цалин хөлс, орлого олох зорилгоор эдийн засгийн үйл ажиллагаанд оролцож, хөдөлмөр эрхлэлтийн аль нэг хэв шинжид хамрагдаж буй иргэн. Цалин хөлс, орлого олох зорилгоор эдийн засгийн үйл ажиллагаанд сүүлийн 7 хоногт нэгээс дээш цагаар оролцсон бол ажилтан гэж үзнэ.

***Эх сурвалж:*** НҮБТМБСТ/ТМБС-ын толь бичиг
МУ-ын статистикийн эмхэтгэл, 2010

**Employed person/ Employee**

A person who works in a job or business or on a farm, either as an employee, employer, own account worker, or contributing family worker.

Citizen involved in labour relation and type, by being involved in economic activity for wage and income generation. If a person was involved in economic activity for wage and income generation for more than one hour during the past week he/she is considered as an employee.

***Source***: UNEVOC/TVETipedia Glossary
Mongolian National Statistical Yearbook, 2010

**15 Ажил хайгчийн үнэлгээ**

Ажил хайгчийн үнэлгээ буюу сегментчлэл гэдэг нь ажил хайгчдыг хөдөлмөрийн зах зээлд нэвтрэх боломжоор нь ялгаж тодорхой бүлгүүдэд хуваах арга техник юм.

***Эх сурвалж:*** Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, түүнтэй холбогдох нэр томъёоны тайлбар толь 2016

**Jobseeker profiling**

“Jobseeker profiling” or “segmenting” is a technique to divide jobseekers into specific groups by classifying according to their availability to enter the labour market.

***Source***: Terms of Glossary for Employment services, 2016

**16 Ажилбар**

Тодорхой хугацаанд бүтээгдэхүүн, үйлчилгээ эсвэл шийдвэр гаргалтад хүргэх, ажиглагдахуйц, тодорхой үйл ажиллагааг хэлнэ.

Түүнчлэн ажилбарыг ажлыг амжилттай гүйцэтгэхэд суралцагчийн эзэмшсэн байх шаардлагатай чадамж гэж ойлгоно.

***Эх сурвалж:*** ДАКУМ-ын гарын авлага, Нортон Роберт Е., 1997

**Task**

A work activity that is discrete, observable, performed within a limited period of time, and that leads to a product, service, or decision.

Tasks are also frequently referred to as the competencies that learners or trainees must obtain in order to be successful workers.

***Source:*** DACUM Handbook, Norton Robert E., 1997

**17 Ажилбарын дүн шинжилгээ**

Тухайн ажилбарыг гүйцэтгэхэд ажилтанд тавигдах гүйцэтгэлийн стандарт, үйл ажиллагааны алхмууд, шаардагдах багаж, тоног төхөөрөмж болон холбогдох мэдлэг, чадвар, аюулгүй ажиллагаа, хандлага, шийдвэр зэргийг тодорхойлох зорилгоор ажилбар тус бүрд дүн шинжилгээ хийх үйл явц.

***Эх сурвалж:*** ДАКУМ-ын гарын авлага, Нортон Роберт Е., 1997

**Task analysis**

The process of analyzing each task to determine the steps involved, performance standards, tools, and equipment needed, related knowledge, skills, safety, attitudes, and decision expected of workers performing it.

***Source:*** DACUM Handbook, Norton Robert E., 1997

**18 Ажилгүйдлийн ангилал**

Нас, хүйс, ажилгүй болохын өмнөх ажил эрхлэлтийн байдал, мэргэжил, иргэншил, оршин суугаа улс орон, бүс нутгийн ялгаа зэргийг үндэслэн гаргасан ажилгүйдлийн ангилал.

***Эх сурвалж:*** Монгол– Англи хөдөлмөрийн нэр томьёоны тайлбар, товч толь, УБ, 2015

**Unemployment classification**

Classification of unemployment based on age, sex, pre – unemployment condition, profession, citizenship and permanent settlement in a region or country.

***Source***: Mongolian – English Glossary of Labour Terminology, UB, 2015

**19 Ажилгүйдлийн түвшин**

Тодорхой бүлэг хүмүүсийн дундах ажиллах хүчний хувиар илэрхийлэгдсэн ажилгүй иргэдийн тоо.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэст бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоог эдийн засгийн идэвхтэй хүн амд харьцуулсан харьцаа.

***Эх сурвалж:*** НҮБТМБСТ/ТМБС-ын толь бичиг; МУ-ын статистикийн эмхэтгэл, 2010

**Unemployment rate**

The number of unemployed persons expressed as a percentage of the labour force in the same group.

In other words, it is a ratio between economically active population and a number of unemployed citizens registered at Division of Labour and Welfare Services.

***Source***: UNEVOC/TVETipedia Glossary Mongolian Statistical Yearbook, 2010

**20 Ажилгүйдэл**

Хөдөлмөрийн чадвартай хүн ажил хөдөлмөр эрхлэхийг хүсч идэвхтэй эрж байгаа ч ажил олдохгүй байдал.

***Эх сурвалж:*** Монгол – Англи хөдөлмөрийн нэр томьёоны тайлбар, товч толь, УБ, 2015

**Unemployment**

Unemployment is a phenomenon when a person who is actively searching for employment and unable to find work so far.

***Source***: Mongolian – English Glossary of Labour Terminology, UB, 2015

21 **Ажилд орох, зуучлах, сургах**

Хувь хүний ур чадварт тохирсон ажил олоход нь туслах үйл явц, түүнтэй холбоотой сургалтууд.

- Ажлын байрны зуучлалыг төрийн болон төрийн бус байгууллага, (төрийн болон хувийн) хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний болон сургалтын байгууллагууд зохион байгуулж болно.
- Ажлын байрны зуучлалд анкет (CV) бичих, ярилцлага болон ур чадварын үнэлгээнд бэлтгэх, ажил, мэргэжлийн удирдамж, чиг баримжаа олгох зэрэг олон нийтийн мэдлэг, мэдээллийг дээшлүүлэх үйл ажиллагаа орно.

***Эх сурвалж:*** Европын боловсрол, сургалтын бодлогын толь бичиг, (Cedefop), 2011

**Job placement (services)**

Process of supporting individuals to find jobs (employment) matching their skills and related trainings.

- job placement can be carried out by (public or private) employment services or educational institutions or government or non-governmental organizations;
- job placement encompasses activities such as drafting a Curriculum Vitae (CV), preparation for interviews, skills audit, guidance and counselling to support public awareness.

***Source***: Terminology of European Education and Training Policy, Cedefop, 2011

22 **Ажилтны сэлгээ**

Ажилтныг нэг ажлаас нөгөөд эсвэл хэд хэдэн өөр ажилд шилжүүлэх ажлыг төлөвлөн зохион байгуулах арга барил.
Энэ нь ажилтны ур чадвар, туршлагын хүрээг өргөжүүлэх замаар ажлын сэтгэл ханамжийг дээшлүүлж, тэднийг олон талын чадварт сургах, зорилготой

***Эх сурвалж:*** МБС мэргэшлийн түвшний тогтолцооны нэр томьёоны тайлбар толь, (МСС), УБ, 2011

**Job rotation**

A job design technique in which employees are moved between two or several jobs in a planned manner.

The objective is to expose the employees to different experiences and wider variety of skills to enhance job satisfaction and to cross-train them.

***Source***: Glossary of Terms for Vocational Education, Training and National Qualifications System, (MCA), UB, 2011

23 **Ажиллах хүч**

Ажил эрхэлж буй, ажилгүй болон ажил идэвхтэй хайж буй насанд хүрсэн (15 ба түүнээс дээш насны) нийт хүмүүсийн тоо.

***Эх сурвалж:*** ТМБС-ын тайлбар толь, ТБУЧХА, Филиппин,2010

**Labor force** — The number of adult population (15 years and above), whether employed or unemployed, actively searching for a job.

***Source***: The TVET Glossary of Terms, TESDA, Philippines, 2010

24 **Ажиллах хүчний оролцооны түвшин** — Эдийн засгийн идэвхтэй хүн амыг хөдөлмөрийн насны хүн амд харьцуулсан харьцаа.

15 ба түүнээс дээш насны нийт хүн амд идэвхтэй хөдөлмөр эрхэлж байгаа хүн амын эзлэх хувь хэмжээ.
Тодорхой бүлэг хүмүүсийн нийт ажиллах хүчинд эзлэх хэмжээ.

***Эх сурвалж***: МУ-ын статистикийн эмхэтгэл, УБ , 2016
ТМБС-ын тайлбар толь, ТБУЧХА, Филиппин, 2010

**Labor force participation rate** — Ratio between economically active population and working age population.

The proportion (in percent) of the total number of persons actively involved in the labor force to the total population of 15 year olds and over.

***Source***: Mongolian Statistics Yearbook, 2016
The TVET Glossary of Terms, TESDA, Philippines, 2010

25 **Ажиллах хүчний илүүдэл** — Ажил олгогчийн эрэлтээс давсан ажиллах хүчний нийлүүлэлт.

***Эх сурвалж:*** Хөдөлмөрийн зах зээл, сургалтын агуулгын стандарт, төлөвлөгөө, хөтөлбөрийн холбогдолтой нэр томьёоны толь, УБ, 2002

**Surplus labour force** — Workforce supply exceeding employers' demand.

***Source***: Glossary of Labour Market, Training Content Standard, Plan, Curriculum Related Terminologies, UB, 2002

26 **Ажиллах хүчний нийлүүлэлт** — Бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ эрхлэхэд шаардагдах ажиллах хүчний нийлүүлэлт, ажлын цаг болон бусад хүчин чармайлт.

Ажиллах хүчний нийлүүлэлтийг хүн амын тоо, ажиллах боломж, хүсэл зорилготой хүмүүсийн хувь хэмжээ болон хүн тус бүрийн ажилласан цагийн харьцаагаар тодорхойлно.

***Эх сурвалж:*** ТМБС-ын тайлбар толь, ТБУЧХА Филиппин, 2010

**Labor supply** — Refers to the supply of workers, hours or effort for the production of goods and services, and is determined by the size of the population, the proportion able and willing to work and the number of hours worked by each individual.

***Source***: The TVET Glossary of Terms, TESDA, Philippines, 2010

**27 Ажиллах хүчний эрэлт**

Ажиллах хүчний эрэлт гэдэг нь эдийн засаг эсвэл аж ахуйн нэгж тодорхой цаг хугацаанд ажиллуулах хүсэлтэй байгаа ажиллах хүчний эрэлтийн тоо хэмжээг хэлнэ.

Энэхүү эрэлт нь урт хугацаанд тогтвортой байх шаардлагагүй бөгөөд аж ахуйн нэгжүүдийн төлөх хүсэлтэй байгаа цалингийн хэмжээ болон тухайн цалин хөлсөөр ажиллах хүсэлтэй байгаа ажиллах хүчний тоогоор тодорхойлогдоно.

***Эх сурвалж:*** http://www.investopedia.com

**Labor demand**

It is a concept that describes the amount of demand for labor that an economy or firm is willing to employ at a given point in time.

This demand may not necessarily be in long-run equilibrium, and is determined by the real wage, firms are willing to pay for this labor, and the amount of labor workers are willing to supply at that wage.

***Source:*** http://www.investopedia.com

**28 Ажлын байран дахь мэдлэг ур чадварын үнэлгээ**

Ажлын хэвийн үйл ажиллагааны үед ажилтны чадамж, мэдлэг, ур чадвар нь стандарт шаардлага хангаж байгаа эсэхийг тодорхойлох зорилгоор баримт нотолгоо цуглуулж, дүгнэх үйл ажиллагаа.

Ажлын байран дахь үнэлгээнд ажлын явцыг ажиглах, гаргасан бүтээгдэхүүнийг шалгах, ажлын явцад тавьсан асуултад хариулах зэрэг аргуудыг хэрэглэдэг.

***Эх сурвалж:*** МБС-ын тайлбар толь, МБСҮТ Австрали, 2013

**Workplace based assessment**

The gathering and judging of evidence during normal work activities in order to determine whether a required standard of competence, knowledge or skill has been achieved.

Workplace assessment usually involves observation of work in progress, checking the product(s) of a work activity, and receiving oral responses to questions posed while work is in progress.

***Source***: Glossary of VET, NCVER, Australia, 2013

**29 Ажлын байран дахь сургалт / Үйлдвэр дээрх сургалт**

МБС–ын байгууллагын суралцагч, оюутнуудын дадлагын сургалт, бүтээлч ажил болон мэргэжил дээшлүүлэх үйл ажиллагааны хүрээнд үйлдвэр, аж ахуй нэгж, байгууллагын сургагч багш, холбогдох багш, зааварлагч, үйлдвэрийн ажилтны зааварчилгаан дор ажлын байр эсвэл ажлын талбарт явуулдаг сургалт.

***Эх сурвалж:*** НҮБТМБСТ/ТМБС-ын толь бичиг

**On–the- Job Training *also* (Supervised industry training)**

It is defined as the training undertaken at work place or on site as part of the practical training, productive work and professional development of either the trainees and students enrolled in TVET institutions (institutes, centres and schools) and conducted by the relevant instructors and teachers or the workers employed by industrial organizations / enterprises and conducted by the relevant trainers and first line supervisors.

***Source***: UNEVOC/TVETipedia Glossary

| | |
|---|---|
| **30 Ажлын байрнаас гадуурх сургалт** | Тухайн үйлдвэр, аж ахуйн газар ажилтнуудаа ажлын ердийн нөхцөлөөс нь хөндийрүүлэн мэргэжлийн сургалтад хамруулах үйл ажиллагаа. Энэхүү сургалтын хөтөлбөрийн тодорхой хэсэг нь ажлын байранд хийгдэж болно.<br><br>***Эх сурвалж:*** Мэргэжлийн боловсрол, сургалт, мэргэшлийн түвшний тогтолцооны нэр томьёоны тайлбар толь, (МСС), УБ, 2011 |
| **Off- the- Job Training** | Training undertaken away from the actual work condition that are organized by the industry for its employees.<br><br>***Source***: Glossary of Terms for Vocational Education, Training and National Qualifications System, UB, 2011 |
| **31 Ажлын байранд дадлагажуулах сургалт** | Ажил хөдөлмөр эрхлэхэд шаардлагатай чадвар дадал, чадамж эзэмшүүлэх зорилготой тусгайлан боловсруулсан агуулга, урьдчилан тодорхойлсон төлөвлөгөөний дагуу бүхий ажлын байранд явагдах сургалтын үйл ажиллагаа.<br><br>***Эх сурвалж:*** МБС-ын тайлбар толь, МБСҮТ Австрали, 2013 |
| **Structured workplace learning** | It provides students with the opportunity to integrate practical on-the-job experience and learnings in industry. This training is with a pre-defined plan and specially designed content to provide with employment related skills and competency.<br><br>***Source***: Glossary of VET, NCVER, Australia, 2013 |
| **32 Ажлын байрны дүн шинжилгээ** | Ажлын байрны ажил, үүргүүдийг тодорхойлох зорилгоор хийгддэг ажлын байрны нарийвчилсан дүн шинжилгээ.<br><br>Ажлын байранд дүн шинжилгээ хийх зорилгоос хамааран сургалт, тоног төхөөрөмж, ажлын байрны зураглал зэрэг арга хандлага өөр өөр байж болно.<br><br>***Эх сурвалж:*** ТМБС-ын тайлбар толь, ТБУЧХА, Филиппин, 2010 |
| **Job analysis** | The process of examining a job in detail to identify its component tasks. The detail and approach may vary according to the purpose for which the job is being analyzed, e.g., training, equipment design, work layout.<br>***Source***: The TVET Glossary of Terms, TESDA, Philippines, 2010 |
| **33 Ажлын газраас зохион байгуулах сургалт** | Ажлын байранд эсвэл МБС-ын байгууллага дээр сургалтад хамрагдах замаар мэргэжлийн ажил гүйцэтгэхэд шаардлагатай мэдлэг, ур чадварыг эзэмших явц.<br><br>Энэ төрлийн сургалтыг ихэнх тохиолдолд танхимын эсвэл бусад хэлбэрийн сургалттай хослуулж ажлын байранд зуучлах, ажлын туршлага олгох, ажлын байранд дагалдуулан сургах, ажил хийхэд шаардагдах ерөнхий чадамж эзэмшүүлэх ба үйлдвэрлэлийн талаар зааварчилгаа өгөх хэлбэрээр явуулдаг. |

***Эх сурвалж:*** Төв Европын МБС –ын толь бичиг, (Cedefop) 2011
МБС-ын тайлбар толь, МБСҮТ Австрали, 2013

**Work-based learning**

Acquisition of knowledge and skills through carrying out and reflecting on tasks in a vocational context, either at the workplace (such as alternance training) or in a VET institution.

Work-based learning is often undertaken in conjunction with classroom or related learning, and may take the form of work placements, work experience, workplace mentoring, instruction in general workplace competencies, and broad instruction in all aspects of industry.

***Source***: Terminology of European education and training policy, Cedefop, 2011
Glossary of VET, NCVER, Australia, 2013

34 **Албан боловсрол, сургалт**

Их сургууль, коллеж, МБСБ, ерөнхий боловсролын сургууль зэрэг боловсролын байгууллага эсвэл үйлдвэр, аж ахуй нэгжийн дэргэдэх сургалтын төв, ажлын байранд гол төлөв багш, зааварлагчийн удирдамж, зааварчилгаан дор олгодог, албан ёсоор диплом, үнэмлэх, гэрчилгээгээр баталгаажуулдаг зохион байгуулалттай боловсрол, сургалтын үйл ажиллагааг хэлнэ.

***Эх сурвалж:*** НҮБТМБСТ/ТМБС-ын толь бичиг

**Formal education and training**

Formal Education and Training is learning that occurs within an organized and structured context and which is provided in Educational Institutions such as Universities, Colleges, Schools, VET institutions or this is provided as off-the-job education and training in enterprise training centres (In-company Training Centres) and workplaces and usually involving direction from a trainer or instructor or teacher and may lead to a formal recognition (diploma, certificate).

***Source***: UNEVOC/TVETipedia Glossary

35 **Албан бус боловсрол, сургалт**

Боловсрол, сургалтын албан ёсны тогтолцооноос гадуур иргэнд үйлчилгээ үзүүлэх зохион байгуулалттай үйл ажиллагаа.

Албан бус боловсрол, сургалт нь тусгайлан сургалт хэлбэрээр зохион байгуулагдаагүй ч тодорхой үйл ажиллагааны хүрээнд багтсан сургалтын чухал элемент бүхий сургалтын үйл ажиллагаа юм.

***Эх сурвалж:*** Боловсролын тухай МУ-ын хууль, 2002

МБС-ын тайлбар толь, МБСҮТ Австрали, 2013

**Non-formal education and training**

Organized activity to provide services to citizen outside the official education and training system.

Non-formal Education and Training is learning embedded in planned activities that are not explicitly designated as learning, but which contain an important learning element.

***Source***: Law of Mongolia on Education, 2002
Glossary of VET, NCVER, Australia, 2013

36 **Амьдрах орчноос суралцах**

Амьдрах, аж төрөх, ажиллах явцдаа эсвэл чөлөөт цагаараа өдөр тутам хийдэг үйл ажиллагаанаас суралцахыг хэлнэ.

Энэ нь тусгай бүтэц, зохион байгуулалтад ороогүй зорилго, хугацаа, дэмжлэг байдаггүй сургалтын үйл ажиллагаа юм. Гол төлөв энэ сургалтыг суралцагч зорьж төлөвлөөгүй байдаг.

Үүнийг ихэнх тохиолдолд ном зохиол унших, нийгмийн харилцаанд орох болон бусад амьдралын туршлагаас олж авсан мэдлэг, ойлголт ур чадвар олгох туршилтын сургалт гэж үздэг. Зарим утгаар нь санамсаргүйгээр суралцах гэж ойлгож болно. Ямар нэгэн гэрчилгээ олгогддоггүй.

***Эх сурвалж:*** Төв Европын МБС-ын толь бичиг (Cedefop) 2011

**Informal learning**

Learning resulting from daily activities related to work, family or leisure.

It is not organized or structured in terms of objectives, time or learning support. Informal learning is in most cases unintentional from the learner's perspective.

It is often referred to as experiential learning, i.e., learning in the form of awareness, knowledge or skills derived from experience, reading, social contact, etc., and can, to a certain degree, be understood as accidental learning. Typically, it does not lead to certification.

***Source***: Terminology of European Education and Training Policy, Cedefop, 2011

37 **Анхан шатны мэргэжлийн боловсрол, сургалт**

Анхан шатны боловсролын тогтолцооны хүрээнд ихэнхдээ ажил мэргэжлийн гараагаа эхлэхээс өмнө олгодог ерөнхий эсвэл мэргэжлийн боловсрол, сургалт.

- Ажлын гараагаа эхэлмэгц олгодог зарим сургалт (дахин сургалт)-ыг анхан шатны сургалтад тооцож болно.
- Анхан шатны боловсрол, сургалтыг ерөнхий эсвэл мэргэжлийн боловсрол (дан сургуульд суурилсан буюу бусад хэлбэрийн сургалт), эсвэл дагалдан сургалтын аль ч шатанд зохион байгуулах боломжтой.

***Эх сурвалж***: Төв Европын МБС-ын толь бичиг, (Cedefop) 2011

**Initial vocational education and training**

General or vocational education and training carried out in the initial education system, usually before entering working life.

- some training undertaken after entry into working life may be considered as initial training (such as retraining);
- initial education and training can be carried out at any level in general or vocational education (full-time school-based or alternance training) or apprenticeship pathways.

***Source***: Terminology of European Education and Training Policy, Cedefop, 2011

**38 Анхан шатны сургалт**

Ажиллах хүчний эгнээнд эсвэл дараагийн шатны мэргэжлийн боловсрол, сургалтад дэвшин ороход бэлтгэх сургалт.

***Эх сурвалж:*** МБС-ын тайлбар толь, МБСҮТ Австрали, 2013

**Entry Level Training (ELT)**

Training undertaken to gain entry into the workforce or further vocational education and training.

***Source***: Glossary of VET, NCVER, Australia, 2013

**39 Аудит (Чанарын)**

МБС-ын тогтолцооны хувьд Чанарын аудит гэдэг нь МБСБ-ын үйл ажиллагаа, үр дүн нь Чанарын удирдлагын тогтолцооны стандартад нийцэж байгаа эсэхийг тодорхойлох зорилгоор баримт, нотолгоо цуглуулах бие даасан, зохион байгуулалттай баримтжуулах үйл явц.

***Эх сурвалж:*** НҮБТМБСТ/МБС, үнэлгээ баталгаажуулалтын тайлбар толь

**Audit (Quality)**

In the VET context, Quality Audit means a systematic, independent and documented process for obtaining evidence to determine whether the activities and related outcomes of a TVET Institution comply with the Quality Training Framework Standards.

***Source***: UNEVOC/Glossary of Terms for TVET, Assessment and Verification

**40 Ахисан түвшний сургалт**

Мэргэшлийн тодорхой түвшин бүхий ажилтны мэргэшлийн түвшинг ахиулах зорилгоор тусгай хөтөлбөрт хамруулан сургах үйл ажиллагаа.

***Эх сурвалж:*** МБС мэргэшлийн түвшний тогтолцооны нэр томьёоны тайлбар толь, (МСС), УБ, 2011

**Advanced level training**

Activity to involve worker with specific qualifications level in special training program to upgrade qualifications level.

***Source***: Glossary of Terms for Vocational Education, Training and National Qualifications System, (MCA), UB, 2011

# Б

**41 Багаар ажиллах**

Тодорхой зорилгод хүрэхийн тулд бүлэг хүмүүстэй хамтран ажиллах үйл явц.

Хувь хүн хоорондын аливаа зөрчлөөс үл хамааран, хүн бүр ур чадвараа ашиглан бүтээлч санал, санаачилга гарган ажиллах хүмүүсийн хамтын ажиллагаа.

***Эх сурвалж:*** http://www.businessdictionary.com;

**Team work** The process of working collaboratively with a group of people in order to achieve a goal.

Teamwork means that people will try to cooperate, using their individual skills and providing constructive feedback, despite any personal conflict between individuals.

***Source***: http://www.businessdictionary.com

42 **Багц цаг/ Кредит** Мэргэшлийг бүрэн эсвэл хэсэгчлэн эзэмшиж, зохих сургалтын үр дүнд хүрэхэд шаардлагатай сургалтын цагийг тоон утгад шилжүүлсэн хэмжүүр. Нэг багц цаг нь сургалтын 10 цагтай тэнцэнэ.

Мэргэшил эзэмших зорилгоор хувь хүний хуримтлуулж, үнэлүүлсэн сургалтын үр дүнгийн цогц бөгөөд өөр мэргэжлээр эсвэл дараагийн шатны сургалтад шилжин суралцах боломжийг олгоно.

***Эх сурвалж:*** Боловсролын тухай МУ-ын хууль, 2007
UNEVOC/ SAQA, Өмнөд Африк, 2013

**Credit** A set of learning outcomes of an individual which have been assessed and which can be accumulated towards a qualification or transferred to other learning programmes or qualifications.

It is a measure of the volume of learning required for a qualification or part qualification, quantified as the number of notional study hours required for achieving the learning outcomes specified for the qualification or part qualification. One credit is equated to 10 notional hours of learning.

***Source*** : Law of Mongolia on Education, 2007
UNEVOC/SAQA, South Africa, 2013

43 **Багц цагийн тогтолцоо** Албан, албан бус тогтолцоо болон амьдралын туршлагаас олж авсан сургалтын үр дүнг хуримтлуулсан мэргэшлийг баталгаажуулах зорилгоор нэгээс нөгөө тогтолцоонд шилжин суралцах боломжийг олгоно.

Багц цагийн тогтолцоо нь дараах асуудлуудыг тодорхойлно:
- Боловсрол эсвэл сургалтын хөтөлбөр, түүний бүрэлдэхүүн хэсгүүдэд (модуль, курс, шилжилт, эрдмийн зэрэг горилсон бүтээл г.м) хамаарах оноо (багц цаг), эсвэл
- Сургалтын нэгжийн үр дүн ба нэгж тус бүрд хамаарах багц цагийн хэмжээ.

***Эх сурвалж:*** Төв Европын МБС –ын толь бичиг, (Cedefop) 2008

**Credit system** An instrument designed to enable accumulation of learning outcomes gained in formal, non-formal and/or informal settings, and ease their transfer from one setting to another for validation.

A credit system can be designed by describing:

- an education or training programme and attaching points (credits) to its components (modules, courses, placements, dissertation work, etc.); or,
- a qualification using units of learning outcomes and attaching credit points to every unit.

***Source***: Terminology of European Education and Training Policy, Cedefop, 2008

**44 Багц цагт шилжүүлэх**

Нэг сургалтын байгууллага эсвэл тогтолцооны хүрээнд хуримтлуулсан багц цагийг нөгөө сургалтын байгууллага эсвэл тогтолцоонд хүлээн зөвшөөрөх үйл явц.

***Эх сурвалж:*** НҮБТМБСТ/ОУХБ (SED), 2007

**Credit transfer**

The process by which credits gained in one institution or system may be recognised in another institution or system.

***Source***: UNEVOC/ ILO (SED), 2007

**45 Багшийн мэргэжил дээшлүүлэх сургалт**

Ажил олгогчдын зүгээс ажилтнуудынхаа мэргэжлийг дээшлүүлдэг тасралтгүй үйл ажиллагааны нэг хэсэг.

Ажиллаж байх хугацаанд нь МБС-ын байгууллагын багш, сургагч нарт олгодог сургалт нь багшийн мэргэжил дээшлүүлэх нийтлэг үйл ажиллагаа юм.

***Эх сурвалж:*** Европын Холбооны Хороо, 2010

**In-service training**

Training provided to employees (by employers) as part of their continuing professional development.

***Comment***: Teacher training provided to VET Schoool teachers/ trainers, while they are still employed, is a common practice of in-service training.

***Source***: EU Commission AL 2010, Europe

**46 Байгууллагын хөгжлийн төлөвлөгөө**

Тодорхой хугацаанд хөгжилд хүргэх байгууллагын төлөвлөлтийн баримт бичиг.

Тус баримт бичиг байгууллагын боловсролын хөтөлбөр, элсэлт, маркетинг, санхүүгийн хөгжилд хүрэх зөвлөмж, стратеги дүн шинжилгээг агуулна.

Тус баримт бичиг нь байгууллагын чиг хандлага, өнгөрсөн болон өнөөгийн байдлын судалгаа шинжилгээнд суурилж, зорилго, зорилт, үнэт зүйл, зарчим, удирдлага, зохион байгуулалт, хүний нөөцийн хөгжил, хэрэгжүүлэх үйл ажиллагаа, санхүүжилт, хүрэх үр дүн, эрсдэлийн үнэлгээг тодорхойлсон, товлосон хугацаанд хэрэгжүүлэх агуулгатай байна.

***Эх сурвалж:*** ТМБС-ын тайлбар толь, ТБУЧХА, Филиппин, 2010

**Institutional development plan**

A document which serves as an institutional roadmap to development within a specific period of time which provides strategic analysis and recommendations for organizations to grow in their educational programs, enrolment, marketing and financial development.

This document includes the concept to implement within secified period, defined risk assessment, expected outcomes, funding, activities to be carried, human resource development, organization, management, principal, value, goals, objective, based on research and study works on attitude, current past of organization.

***Source***: The TVET Glossary of Terms, TESDA, Philippines, 2010

**47 Баталгаажуулалт / батлах**

Шинээр гарсан буюу шинэчлэгдэн өөрчлөгдсөн мэргэжлийн боловсрол, сургалтууд зорилгодоо нийцэж, үндэсний хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөхүйц болохыг батлан баримтжуулах.

***Эх сурвалж:*** Мэргэшлийг баталгаажуулах бодлогын баримт бичгийн төсөл, ХНХЯ, 2016

**Validation**

Validation is the procedure through which it is assured that all new or revised qualifications for vocational qualification are fit for purpose and can be nationally recognised.

***Source***: (Draft) Policy on Validation of Qualificaitons, MoLSP, 2016

**48 Баталгаажуулах үйл явц**

Аливаа зүйлийн чанарыг батлах, эсвэл шалгах үйл явц.

Инженерчлэл, чанарын удирдлагын тогтолцоонд, бүтээгдэхүүн, үйлчилгээ эсвэл, тогтолцоо нь холбогдох хууль, дүрэм, техникийн стандартуудад нийцэж байгаа эсэхийг тодорхойлох, баримтжуулах зорилгоор хийгдэх хяналт, шалгалт.

Үнэлгээний баталгаажуулалт гэдгийг тодорхой мэргэшлийг бүхлээр нь эсвэл хэсэгчлэн эзэмших суралцагчийн сургалтын үр дүн нь эзэмшсэн байх шаардлагатай сургалтын түвшинд хүрсэн гэдгийг хүлээн зөвшөөрч баталгаажуулах үйл явц.

***Эх сурвалж:*** Оксфордын тайлбар толь https://en.oxforddictionaries.com/definition/verification;

**Verification**

The act or process of confirming or checking the accuracy of something.

In engineering or quality management systems, verification is the act of reviewing, inspecting or testing, in order to establish and document that a product, service or system meets regulatory or technical standards.

In the assessment context, ***Verificaiton*** is about confirming that certain assessed learning outcomes achieved by the learner correspond to specific learning outcomes that may be required for a qualification or part thereof. It usually includes determining the specific grades that learners will receive for their performance.

***Source***: Oxford Dictionaries
https://en.oxforddictionaries.com/definition/verification

**49 Баталгаажуулагч /Дотоодын/**

Сургалтын байгууллагаас томилсон үнэлгээний ажилтны хийсэн үнэлгээ нь үнэлгээний стандарт, журмын дагуу нэгэн жигд, тогтвортой зохион байгуулагдсан эсэхийг хянах, баталгаажуулах үүрэг бүхий ажилтан юм.

***Эх сурвалж:*** Үнэлгээ, баталгаажуулалтын бодлогын төсөл, ХНХЯ, УБ, 2017

**Internal verifier**

A person appointed by the training center who ensures that assessors apply standards of assessment uniformly and consistently, also known as system or process verification.

***Source***: (Draft) Policy on Competence of Assessment, MoLSP, UB, 2017

**50 Баталгаажуулагч /Хөндлөнгийн/**

МБС-ын Үнэлгээний төвөөс сургалтын байгууллага, төвүүдэд зохион байгуулагдсан үнэлгээ нь үнэлгээний стандарт, журмын дагуу жигд, тогтвортой явагдсан эсэхийг хянах, батлах үүрэг бүхий томилогдсон ажилтан юм.

***Эх сурвалж:*** (Draft) Policy on Competence of Assessment, MoLSP, UB, 2017

**External verifier**

An external verifier is a person appointed by the VET Assessment Centre who is responsible for ensuring that standards of assessment are applied uniformly and consistently across centers, for specific sector based groups of qualifications.

***Source***: Draft Policy on Verification of Assessment, MoLSP, UB, 2017

**51 Баталгаажуулах эрх бүхий байгууллага**

Дагалдан болон дадлагажих сургалтуудыг баталгаажуулж, зохих цаг хугацаанд сургалтын үр дүн, нөлөөллийг тодорхойлдог байгууллага.

Монгол Улсад МБС-ыг баталгаажуулагч байгууллага нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам.

***Тайлбар***:
Монгол улсын "Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай" хуульд (2009 оны) (§14) төрийн, төрийн бус өмчийн мэргэжлийн болон техникийн боловсрол эзэмшүүлэхтэй холбогдсон баталгаажуулагч байгууллагын тухай заалт бий. Тухайлбал, Оюу-толгой мэт стратегийн орд газарт мэргэжилтэй ажилтан бэлтгэх, сургалт зохион байгуулах тухай Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2010 оны 409/123 тоот хамтарсан тушаалаар (§ 4.1) тодорхой заалтууд гаргасан.

***Эх сурвалж:*** Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай МУ-ын хууль тогтоомж, эрх зүйн актын эмхэтгэл, 2010

**Approving authority** The authority that endorses VET, apprenticeship and practical training and define the affect of training during the due period.

In Mongolia today, the approving authority of VET is the Ministry of Labour and Social Protection.

***Note***:
The Mongolian law on Vocational Educatuion and Training of 2009 includes an article 14 on approving authority with regards to public and private institutions providing vocational and technical education. Also Decree 409/123 of 2010 issued by Minister of Labour and Social Protection reflects on organizing trainings and preparing professional workers for strategic mines such as Oyu Tolgoi.

***Source***: Compilation of Law of Mongolia and legal Acts on Labor Support, UB, 2010

52 **Бенчмарк /харьцуулсан судалгаа/** Тогтмол сайжруулж хөгжүүлэх зорилгоор МБС-ын болон бусад салбарт үйл ажиллагаа явуулдаг, жишиж болохуйц байгууллага эсвэл тогтолцоо хоорондын бүтээгдэхүүн үйлчилгээг харьцуулж үнэлэх тасралтгүй үйл явц.

***Эх сурвалж:*** http://www.ivet.com.au/a/44.html#B

**Benchmarking** The continuous process of measuring and comparing products, services and practices with comparable systems or organisations both inside and outside the VET sector for the purpose of continuous improvement.

***Source***: http://www.ivet.com.au/a/44.html#B

53 **Бизнес инкубатор** Төрөл бүрийн үйлчилгээ, сургалт явуулах замаар эрдэм шинжилгээний байгууллага болон бизнесийн холбоо, Засгийн газраас олгох хөтөлбөрүүдийн цогцыг Бизнес инкубатор гэж ойлгож болно.

Үүний зорилго нь дөнгөж үйл ажиллагаа эхлүүлсэн аж ахуй нэгжүүдэд тогтмол үйл ажиллагааны дэмжлэг үзүүлж, шалгарч үлдэх боломжийг олгоход оршино.

Үүнд  дараах төрлийн үйлчилгээнүүд орно:

- Оффис байр. Ихэнхдээ бууруулсан төлбөртэйгөөр олгоно
- Оффис үйлчилгээ: угтах үйлчилгээ, хурлын өрөө, ажлын өрөө, компьютер, оффисын бусад тоног төхөөрөмж г.м
- Аж ахуй эрхлэх зөвлөмж, удирдлагаар хангах: Аж ахуй эрхлэх зөвлөмж үйлчилгээ нь вэб үүсгэх, оюуны өмчийн эрхийг тодорхойлохоос эхлээд хөрөнгө босгох хүртэл өргөн хүрээтэй байна.
- Бизнес төлөвлөгөө, зах зээлд нэвтрэх зөвлөгөө: бизнес төлөвлөгөө нь маш динамик байдаг тул зах зээлийн дагуу тогтмол өөрчлөлт оруулах шаардлагатай.Холбоо барих, харилцаа үүсгэх: бизнес инкубаторын хамгийн гол давуу тал бол туршлагатай бизнес эрхлэгчид, шинийг санаачлагчид, мэргэжлийн хүмүүстэй харилцаж асуулт асуух, зөвлөмж

авах, нөөц бололцоог ашиглах боломжтой байдаг.

***Эх сурвалж***: Аж ахуй эрхлэлт, бизнес инкубаторын нэр томьёоны тайлбар толь, УБ, 2013

**Business incubator**

A Business Incubator can be described as a set of programs set up by government, business alliance or academic group through a variety of services/training.

The purose is to help small companies to have a better chance of survival through the start-up phase.
Services may include but not limited to:

- Office space: Usually at a reduced rate.
- Office services: Receptionist, conference rooms, computers. Office equipment etc.
- Entrepreneurial advice and mentoring: Entrepreneur advisor services can range from establishing a web presence to identifying IP licensing opportunities to raising capital.Business planning and market adjustment consulting: Business plans are dynamic and constantly need to be adjusted to fit the market.
- Contacts and Networking: The biggest advantage of a business incubator is its access to experienced entrepreneurs, innovators and professionals who can answer questions, provide guidance and resources.

***Source***: Glossary of Terms on Entrepreneurship and Business Incubator, UB, 2013

54 **Богино хугацааны /Мэргэжлийн сургалт/**

"Мэргэжлийн сургалт" гэж тодорхой ажил, хөдөлмөр эрхлэхэд шаардагдах мэргэжлийн ур чадвар олгох, дээшлүүлэх, давтан сургах, дадлагажуулах, хөдөлмөрийн болон харилцааны соёл төлөвшүүлэх, аж ахуй эрхлэх мэдлэг олгох үйл ажиллагааг хэлнэ.

***Тайлбар***:
Мэргэжлийн боловсрол, сургалтын харьцангуй богино хугацаанд хэрэгжих нийтлэг хэлбэр. Ийм сургалтаар мэргэжлийн үнэмлэх, диплом олгохгүй харин сургалтыг амжилттай дүүргэсэн тохиолдолд тодорхойлолт, гэрчилгээ олгоно.

***Эх сурвалж:*** МБС, мэргэшлийн түвшний тогтолцооны нэр томьёоны тайлбар толь, (МСС), УБ, 2011

**Vocational training/ Short-term training**

A course of vocational education and training (VET) which stands alone and does not usually lead to a full qualification. A statement of attainment may be issued on successful completion.

***Note***:
Common types of vocational education and training conducted are relatively short term training programmes. Usually at completion of such training, diploma or professional is not granted, but in case of successful completion, certificate of completion is issued.

***Source***: Glossary of Terms for Vocational Education, Training and National Qualifications System, (MCA), UB, 2011

**55 Богино хугацааны хөтөлбөр**

Сургууль эсвэл сургалтын төв дээр зохион байгуулагдах чадамжийн нэгжийн эсвэл багц чадамжийн сургалтад хамруулж чадамжийн гэрчилгээ олгох сургалт.

Тухайн хөтөлбөр нь мэргэжлийн нийтлэг, ерөнхий чадамж болон чадамжийн нэгж, эсвэл чадамжийн багцаас бүрдэнэ.

***Эх сурвалж:*** ТМБС-ын тайлбар толь, ТБУЧХА, Филиппин, 2010

**Short-term program**

Learning/training programs offered in campus, be it in school or in center, by unit of competency or cluster of competencies leading to a qualification eligible for a Certificate of Competency.

Comprises the basic, common and a unit/cluster of units of core competencies.

***Source:*** The TVET Glossary of Terms, TESDA, Philippines, 2010

**56 Бодит цалин**

Тухайн жилд олгох тогтмол үнээр илэрхийлсэн хөдөлмөрийн хөлс буюу тодорхой хугацааны цалин.

“Бодит цалин” бол инфляцын үр нөлөөг тооцож олгох нөхвөр, төлбөрийн хэмжээ.

***Эх сурвалж:*** Хөдөлмөрийн зах зээл, сургалтын агуулгын стандарт, төлөвлөгөө, хөтөлбөрийн холбогдолтой нэр томьёоны толь, УБ, 2002

**Real wage**

Salary pertaining to specific period i.e., wage expressed at fixed price of that year.

Real wage is stated as ‘compensation rate adjusted for the effects of inflation’.

***Source:*** Glossary of Labour Market, Training Content Standard, Plan and Curricula Related Terminologies, UB, 2002

**57 Боловсрол сургалтад оруулсан хөрөнгө оруулалтын өгөөж**

Боловсролд хөрөнгө оруулснаар хувь хүн, аж ахуйн нэгж, байгууллага, нийгмийн бүлэг хүмүүст үзүүлэх үр өгөөж, бүтээмж, үр ашиг.

Технологийн дэвшилд хөрөнгө оруулж, зөв менежментийг хослуулснаар сургалтад оруулах хөрөнгө оруулалтын үр өгөөж дээшилдэг.

Өөрөөр хэлбэл сургалтад хөрөнгө оруулснаар хувь хүн, аж ахуй нэгж, байгууллага, Засгийн газар, нийгэмд бий болох үр өгөөж, бүтээмж, үр ашиг юм.

***Эх сурвалж:*** МБС-ын тайлбар толь, МБСҮТ Австрали, 2013

**Return on Investment in**

Results of profitability, productivity and value added for social part and group, enterprises, individuals based on investment in education.

**Training (ROIT)** Investment in training brings high return when it's aligned with investments in technological advancement and right management.

In other words, gains derived by individuals, enterprises, governments or society from investing in training in terms of value adding, productivity and profitability.

***Source:*** Glossary of VET, NCVER, Australia, 2013

**58 Боловсролын агуулга** Боловсролын тухайн түвшинд эзэмшвэл зохих мэдлэг, чадвар, чадамж, төлөвшлийн цогц.

***Эх сурвалж:*** Боловсролын тухай МУ-ын хууль, 2007

**Educational content** A set of knowledge, skills, competence and formation necessary to be obtained at specific level of education.

***Source***: Law of Mongolia on Education, 2007

**59 Боловсролын баримт бичиг** Урьдчилан тогтоосон стандартын дагуу эрх бүхий байгууллага үнэлгээ баталгаажуулалт хийж, хувь хүн сургалтын зохих үр дүнд (мэдлэг, ур чадвар, туршлага, чадамжууд) хүрсэн гэдгийг тодорхойлох гэрчилгээ, диплом зэрэг боловсролын баримт бичиг.

***Эх сурвалж:*** Европын боловсрол, сургалтын бодлогын баримт бичиг, (Cedefop), 2008

**Certification of learning outcomes** The process of issuing a certificate, diploma or title formally attesting that a set of learning outcomes (knowledge, know-how, skills and/or competences) acquired by an individual have been assessed and verified by a competent body against a predefined standard.

***Source:*** Terminology of European Education and Training Policy, Cedefop, 2008

**60 Боловсролын нийгмийн ажилтан** "Боловсролын нийгмийн ажилтан" гэж суралцагч, эцэг эх болон багшийн харилцаа, тэдний нийгмийн асуудалд үнэлгээ өгөх, ганцаарчилсан болон бүлэгт чиглэсэн мэргэжлийн зөвлөгөө өгөх замаар нийгмийн сөрөг үзэгдлээс хүүхдийг урьдчилан сэргийлэх, тэдний төлөвшил, харилцаанд дэмжлэг үзүүлдэг мэргэжилтнийг хэлнэ.

***Эх сурвалж:*** Боловсролын тухай МУ-ын хууль, 2007

**Educational social worker** Specialist supporting the collaboration, formation and prevent negative affects of society on children by providing group and individual professional counceling services, and evaluating social issues and relations between teachers, parents and students.

***Source:*** Law of Mongolia on Education, 2007

**61 Боловсрол, сургалтын орчин** Боловсролын стандартыг хэрэгжүүлэхэд шаардагдах материаллаг нөхцөл болон сурах, сургах харилцааг хэлнэ.

***Эх сурвалж:*** МУ- ын Боловсролын тухай хууль, 2007

**Education and training environment**

The materialistic condition for implementation of education standards, and interdependence of learning and teaching characteristics.

***Source***: Law of Mongolia on Education, 2007

**62 Боловсролын түвшин**

Тухайн шатанд эзэмшвэл зохих сургуулийн өмнөх, бага, дунд, техник мэргэжлийн болон дээд боловсролын, стандартаар тогтоосон мэдлэгийн хэмжээг хэлнэ.

***Тайлбар***:
Хувь хүний дүүргэх боломжтой боловсролын түвшин:
1. Ерөнхий суурь боловсрол /сургуулийн өмнөх, бага боловсрол багтах/;
2. бүрэн дунд /ерөнхий боловсрол/;
3. анхан шатны мэргэжлийн сургалт;
4. дунд шатны мэргэжлийн боловсрол;
5. дээд мэргэжлийн боловсрол;
6. дипломын дараах сургалт.

***Эх сурвалж:*** Хөдөлмөрийн нэр томьёоны Монгол-Англи тайлбар, УБ, 2015

**Educational level**

Scope of knowledge to be obtained at certain level of education set by the educational standards of primary, secondary and higher education.

***Note:***
The following six categories are used generally to state the level of educational attainment a person has completed:
1. basic general education;
2. secondary (full) general education;
3. initial vocational training;
4. vocational secondary education;
5. higher vocational education;
6. Post-graduate education.

***Source***: Mongolian-English Glossary of Labour Terminology, UB, 2015

**63 Бүсийн арга зүйн төв (БАЗТ)**

Мэргэжлийн боловсрол, сургалтын бүсийн арга зүйн төв нь мэргэжлийн боловсрол, сургалтын агуулгын хэрэгжилтийг хангах, чадамжийн сан бүрдүүлэх, багшийг чадваржуулах, хөгжүүлэх, сургалт, судалгаа эрхлэх чиг үүрэгтэй. Мэргэжлийн боловсролын бодлогын хэрэгжилтийн газрын орон нутаг дахь нэгж.

***Эх сурвалж:*** МБС-ын тухай МУ-ын хууль, 2009

**Regional Methodological Center(RMC)**

VET Regional Methodological Center is a regional department of the VET Agency/Ministry of Labour and Social Protection, which is responsible for ensuring the implementation of vocational education and training content, establishing resource of competency, developing and improving the skills of teachers and conducting training and research.

***Source:*** Law of Mongolia onVocational Education and Training, 2012

# Г

**64 Ганцаарчилсан сургалт**

Ганцаарчилсан сургалт буюу ганцаарчилсан зааварчилгаа гэдэг нь сургалтын агуулга, заах арга зүй болон хурд нь сурагч бүрийн сонирхол, чадварт суурилсан байх сургалтын арга зүй.

***Эх сурвалж:*** http://www.dreambox.com/ individualized-learning;

**Individualized learning**

Individualized learning, or individualized instruction, is a method of teaching in which content, instructional technology, and pace of learning are based upon the abilities and interest of each learner.

***Source:*** http://www.dreambox.com/ individualized-learning

**65 Гарааны бизнес**

Тогтвортой байдлаар зарлагаасаа давсан орлого олох хараахан болоогүй, эсвэл хязгаарлагдмал хугацаанд үйл ажиллагаа эрхэлж буй шинэ бизнес гэж тодорхойлно.

***Эх сурвалж:*** Аж ахуй эрхлэлт, бизнес инкубаторын нэр томьёоны тайлбар толь, УБ, 2013

**Start up Business**

A Start Up is defined as a new business that has yet to achieve a sustainable positive cash flow or has been in operation for a limited period of time.

***Source:*** Glossary of Terms on Entrepreneurship and Business Incubator, UB, 2013

**66 Гүйцэтгэл**

МБС-ын байгууллагын тодорхой шалгуур/ стандарт/ удирдамжийн дагуу явуулж буй үйл ажиллагааны эсвэл зорилго, төлөвлөгөөний хэрэгжилтийн үр дүнгийн хэм хэмжээ.

***Эх сурвалж:*** Үр дүнд суурилсан хяналт, үнэлгээний тогтолцооны арван алхам, Kusek, J.Z. and Rist, R. C. Дэлхийн банк, Вашингтон, 2004

**Performance**

The degree to which a VET intervention or a VET provider operates according to specific criteria/standards/ or guidelines or achieves results in accordance with stated goals or plans.

***Source***: Ten steps to a results- based monitoring and evaluation system, Kusek, J.Z. and Rist, R. C. The World Bank, Washington, 2004

**67 Гүйцэтгэлийн үндсэн үзүүлэлт**

Аливаа тогтолцооны үр өгөөж, үр ашгийг үнэлж хянах зорилгоор ашиглах хэмжүүрүүдийн нэг. Үүнийг тайлагах, хариуцлагажуулах болон сайжруулах үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлох зорилгоор ашиглаж болно.

***Эх сурвалж:*** НҮБТМБСТ/МБС, үнэлгээ баталгаажуулалтын тайлбар толь

**Key performance indicator**

One of a set of measures used to monitor or evaluate the efficiency or effectiveness of a system, which may be used to demonstrate

accountability and to identify areas for improvement.

***Source***: UNEVOC/Glossary of Terms for TVET, Assessment and Verification

**68 Гүйцэтгэлийн шалгуур**

Чадамжийн нэгжийн нэг хэсэг бөгөөд суралцагч эзэмших шаардлагатай гүйцэтгэлийн түвшинд чадамжтай болсон эсэхийг үнэлж тодорхойлдог үнэлгээний хэрэгсэл.

***Эх сурвалж:*** МБС-ын тайлбар толь, МБСҮТ Австрали, 2013

**Performance criteria**

The part of a unit of competency specifies the required level of performance to be demonstrated by learners to be deemed competent.

***Source***: Glossary of VET, NCVER, 2013, Australia

**69 Гэрчилгээ-жүүлэгч байгууллага**

Үнэлгээний дүрэм, журмын дагуу хувь хүний сургалтын үр дүн (мэдлэг, ур чадвар, чадамж)-г албан ёсоор хүлээн зөвшөөрч, төгсөлтийн баримт бичиг (гэрчилгээ, диплом, зэрэг) олгох эрх бүхий байгууллага.

Гэрчилгээжүүлэгч байгууллагаас төгсөлтийн баримт бичиг олгодог. Үүнд Боловсролын яам, Хөдөлмөрийн яам, Их сургууль зэрэг Засгийн газрын байгууллагууд орж болно.

***Эх сурвалж:*** НҮБТМБСТ/МБС, Үнэлгээ баталгаажуулалтын тайлбар толь

**Awarding body for certification**

A body issuing qualifications (certificates, diplomas or titles) formally recognisingthe learning outcomes (knowledge, skills and/or competences) of an individual, following an assessment procedure.

Awarding bodies issue qualifications. This could include government agency such as the Ministry of Education, Ministry of Labour or a University.

***Source***: UNEVOC/Glossary of Terms for TVET, Assessment and Verification

**70 Гэрчилгээ**

Урьдчилан тогтоосон стандартын дагуу хувь хүний амжилтыг үнэлж, баталгаажуулан, бүртгэх замаар гэрчилгээжүүлэгч байгууллагаас олгодог албан ёсны баримт бичиг.

***Тайлбар***:
Мөн гэрчилгээжүүлэх гэдэг нь амжилттай суралцагчид мэргэшлийг бүтнээр нь эсвэл тодорхой чадамж эзэмшсэн болохыг албан ёсоор хүлээн зөвшөөрч, баталгаажуулахыг хэлнэ. Албан, албан бус болон амьдралын туршлагаас суралцсан сургалтын үр дүнг баталгаажуулж, гэрчилгээжүүлэх боломжтой.

***Эх сурвалж:*** МБС-ын тайлбар толь, МБСҮТ Австрали, 2013

**Certificate**

An official document, issued by an awarding body, which records the achievements of an individual following an assessment and verification against a predefined standard.

*Note*:
Also referred to as 'Certification', which is formal recognition of a qualification or part qualification awarded to a successful learner. Certification may validate the outcome of learning acquired in formal, non-formal or informal settings.

***Source***: Glossary of VET, NCVER, Australia, 2013

71 **Гүйцэтгэлд тулгуурласан үнэлгээ, эсвэл Чадамжид суурилсан үнэлгээ**

Суралцагчид мэдлэг, ур чадвараа нотлон харуулахын тулд асуултад хариулах, бүтээгдэхүүн гаргах, даалгавар гүйцэтгэх зэрэг үнэлгээний үйл явц.

***Эх сурвалж:*** МБС мэргэшлийн түвшний тогтолцооны нэр томьёоны тайлбар толь, (МСС), УБ, 2011

**Performance-based assessment (also competence based assessment )**

General term for an assessment activity in which students construct responses, create products, or perform demonstrations to provide evidence of their knowledge and skills.

***Source:*** Glossary of Terms for Vocational Education, Training and National Qualifications System, (MCA), UB, 2011

72 **Гүйцэтгэлийн стандарт**

Гүйцэтгэлийн стандарт гэдэг нь суралцагч чадамжтай гэдгээ нотлох эзэмшсэн байх шаардлагатай гүйцэтгэлийн түвшинг тодорхойлсон чадамжийн нэгжийн бүрэлдэхүүн

***Эх сурвалж***: МБС-ын тайлбар толь, МБСҮТ Австрали, 2013

**Performance standard**

The part of a unit of competency specifies the required level of performance to be demonstrated by learners to be deemed competent.

***Source***: Glossary of VET, NCVER 2013, Australia

# Д

73 **Давтан сургалт**

Шинэ ажил, мэргэжил эзэмшихийн тулд шинэ мэдлэг, ур чадвар олж авах эсвэл эзэмшсэн мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилго бүхий сургалт.

Давтан сургалтаар хувь хүн одоогийн ажилдаа эсвэл шинэ ажилд бэлтгэн өөрийн мэдлэг ур чадвараа сайжруулах, эсвэл шинэ мэдлэг чадвар эзэмших боломжтой.

***Эх сурвалж:*** Европын боловсрол, сургалтын бодлогын баримт бичиг, (Cedefop), 2008 Хөдөлмөрийн яам, 2005, Йордан

**Retraining**

Training enabling individuals to acquire new skills giving access either to a new occupation or to new professional activities.

Retraining enables individuals to improve their existing knowledge and skills or to acquire new ones, whether for their current jobs or occupations, or for new ones.

***Source***: Terminology of European education and training policy, Cedefop, 2008 Ministry of Labour 2005, Jordan

**74 Дагалдан сургалт**

Боловсролын байгууллага, сургалтын төв болон ажлын байран дээрх хосолсон урт хугацааны, зохион байгуулалттай сургалт.

Дадлагажигч суралцагч ажил олгогчтой гэрээ байгуулж, урамшуулал /цалин, хөлс/ авч болно.
Ажил олгогч нь суралцагчийг сургалтад хамруулж сургалтын дараа тодорхой ажил, мэргэжлээр хангах үүрэг хүлээж болно.
Дагалдан (дагалдан, дадлагажигч г.м) сургалт бүтэн цагийн, хагас цагийн эсвэл сургууль дээр суурилсан хэлбэртэй байж болно.

***Эх сурвалж:*** Европын боловсрол, сургалтын бодлогын баримт бичиг, (Cedefop), 2008

**Apprenticeship**

Systematic, long-term training alternating periods at the workplace and in an educational institution or training centre.

The apprentice is contractually linked to the employer and receives remuneration (wage or allowance). The employer assumes responsibility for providing the trainee with training leading to a specific occupation.

Apprenticeships (including *traineeships* and *internships*) may be full time, part time or school based.

***Source:*** Terminology of European Education and Training Policy, Cedefop, 2008

**75 Давхар хүлээн зөвшөөрөх**

Аливаа хэлбэрийн сургалтыг академик (сургалтын байгууллага, төв, коллеж, сургуулиас) болон мэргэжлийн (ажил олгогч болон үйлдвэрээс) талаас нь албан ёсоор давхар хүлээн зөвшөөрөх үйл явц.

***Эх сурвалж:*** МБС-ын тайлбар толь, МБСҮТ Австрали, 2013

**Dual recognition**

Dual recognition of a course academically (by an Institute, College, Centre or School) and vocationally (by Employers or Industry).

***Source:*** Glossary of VET, NCVER, 2013, Australia

**76 Дагалдан суралцагч**

Дагалдан суралцагч гэдэг бол аж ахуй нэгжтэй байгуулсан сургалтын гэрээнд заасан хугацааны дагуу аж ахуй нэгжид суурилсан сургалтад хамрагдах хүн.

***Эх сурвалж:*** ТМБС-ын тайлбар толь, ТБУЧХА, Филиппин, 2010

**Apprentice**

Apprentice is a person undergoing training for an approved enterprise-based training occupation within an established period covered by an enterprise-based training agreement.

***Source:*** The TVET Glossary of Terms, TESDA, Philippines, 2010

**77 Дагалдан сургалт**

Зохих түвшинд мэдлэг, чадвар эзэмшихийн тулд дагалдан сургалт шаардлагатай болохыг албан ёсоор буюу холбогдох хууль тогтоомжийн дагуу тогтоосон ажил мэргэжил.

**шаардлагатай мэргэжил**

Гурван талт этгээдийн (гэрээний талууд) албан ёсоор баталгаажуулсан, дагалдан сургалт хийх шаардлагатай мэргэжил.

***Эх сурвалж:*** ТМБС-ын тайлбар толь, ТБУЧХА, Филиппин, 2010

**Apprenticeable occupation**

An occupation officially endorsed for apprenticeship, consistent with existing laws and rules to acquire specific level.

This is officially endorsed by a tripartite body and approved for apprenticeship.

***Source:*** The TVET Glossary of Terms, TESDA, Philippines, 2010

78 **Дадлагажуулах сургалт**

Шинээр сургууль төгсөгчдөд болон шинэ ажилтанд ажлын туршлага олгох зорилгоор зохион байгуулагддаг сургалт юм.

***Эх сурвалж***: Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, түүнтэй холбогдох нэр томъёоны тайлбар толь 2016

**Internship**

Training which is organized to provide work experience for new graduates and new workers.

***Source***: Terms of Glossary for Employment Services, 2016

79 **ДАКУМ аргачлал**

DACUM (Developing a curriculum) буюу хөтөлбөр боловсруулах гэсэн үгийн товчлол.

Аливаа мэргэжлийн сургалтын хөтөлбөрийг боловсруулахын тулд тухайн ажил, мэргэжлийн хүрээнд гүйцэтгэх үндсэн үүрэг, ажилбарууд төдийгүй тэдгээрт шаардлагатай мэдлэг, ур чадвар, төлөв хандлагыг тодорхойлох зорилгоор зорилтот бүлгийг чиглүүлэн ажиллах үйл явц юм.

***Эх сурвалж:*** https://www.iab.com/wp-content/uploads/2016/04/Glossary-Formatted.pdf

**DACUM**

DACUM is an acronym for **D**eveloping **a** **C**urriculum.

Developing a Curriculum (DACUM) is a process that incorporates the use of a focus group in a facilitated storyboarding process to capture the major duties and related tasks included in an occupation, as well as, the necessary knowledge, skills, and traits.

***Source***: https://www.iab.com/wp-content/uploads/2016/04/Glossary-Formatted.pdf

80 **Дасан зохицох**

Хувь хүн болон байгууллагын шинэ технологи, зах зээлийн шинэ нөхцөл байдал, шинэ ажлын орчин нөхцөлд дасан зохицох чадвар.

***Эх сурвалж:*** Мэргэжлийн боловсрол, сургалт, мэргэшлийн түвшний тогтолцооны нэр томьёоны тайлбар толь, (МСС), УБ, 2011

**Adaptability** Capacity of an organisation or of an individual to adapt to new technologies, new market conditions and new work patterns.

***Source:*** Glossary of Terms for Vocational Education, Training and National Qualifications System, (MCA), UB, 2011

81 **Диплом** ТМБС болон дээд боловсролын салбарт боловсрол, мэргэжил эзэмшсэн болохыг баталгаажуулах баримт бичиг.

Урьдчилан тодорхойлсон стандартын дагуу хувь хүний амжилтыг үнэлж, баталгаажуулсан эрх бүхий этгээдийн олгох албан ёсны баримт бичиг.

***Эх сурвалж:*** Төв Европын МБС –ын толь бичиг, (Cedefop), 2014 НҮБТМБСТ/ТМБС-ын толь бичиг

**Diploma** A qualification in the TVET and Higher Education (HE) sectors.

(Diploma/certificate) An official document, issued by an awarding body, which records the achievements of an individual following an assessment and validation against a predefined standard.

***Source:*** Terminology of European education and training policy, Cedefop, 2014 UNEVOC/TVETipedia Glossary

82 **Дэвших, дэвшүүлэх** Суралцагч сургалтын нэг хөтөлбөрөөс нөгөөд, тухайлбал өмнөх сурсан хөтөлбөртэй нь харьцуулахад ахисан түвшний хөтөлбөртэй сургалтад дэвшин шилжих үйл явц.

***Эх сурвалж:*** Мэргэжлийн боловсрол, сургалт, мэргэшлийн түвшний тогтолцооны нэр томьёоны тайлбар толь, (МСС), УБ, 2011

**Advancement** Process of leaners to transferring from one training program to another especially to a higher level program, compared to the previously learnt program.

***Source:*** Glossary of Terms for Vocational Education, Training and National Qualifications System, (MCA), UB, 2011

83 **Дэмжих санхүүжилт** Сургалтын өгөөж, үр шимийг дээшлүүлэхэд чиглэсэн ажил олгогчоос өгөх хууль ёсны хандив (ихэнхдээ цалингийн тодорхой хувь байдаг). Ажил олгогч нь эргээд “ажилчин-сургалт” хөтөлбөр хэрэгжүүлэх аж ахуйн газар болдог.

***Эх сурвалж:*** ТМБС-ын тайлбар толь, ТБУЧХА, Филиппин, 2010

**Levy grant scheme** A legal contribution from participating employers who would be beneficiaries of the program (often as a percentage of the payroll), which is subsequently turned over or rebated to enterprises offering employee-training programs.

***Source:*** The TVET Glossary of Terms, TESDA, Philippines, 2010

| | | |
|---|---|---|
| 84 | **Дэлхийн ур чадварын тэмцээн** | Дэлхийн ур чадвар тэмцээн 2 жил тутамд зохион байгуулагддаг, дэлхийн түвшний аж үйлдвэрийн хөгжлийн тусгал болсон мэргэжлийн боловсрол, чадварын хамгийн том хэмжээний уралдаан юм. Тэмцээнд оролцогчид нь гишүүн орон, эсвэл бүс нутгийн тэмцээнээс шалгарсан шилдэг өрсөлдөгчид байдаг. Тэд ганцаарчлан болон багийн бүрэлдэхүүнээр өөрийн сурч байгаа, эсвэл ажиллаж байгаа мэргэжлийн хүрээнд даалгавруудыг гүйцэтгэж, техник ур чадвараа танилцуулдаг.<br><br>***Эх сурвалж:*** https://www.worldskills.org/what/competitions/worldskills-competitions/ |
| | **World Skills Competition** | The WorldSkills Competition occurs every two years and is the biggest vocational education and skills excellence event in the world that truly reflects global industry. The Competitors represent the best of their peers and are selected from skills competitions in WorldSkills Member countries and regions. They demonstrate technical abilities both individually and collectively to execute specific tasks for which they study and/or perform in their workplace.<br><br>***Source:*** https://www.worldskills.org/what/competitions/worldskills-competitions/ |
| 85 | **Дэлхийн ур чадварын тэмцээний талбай** | Мэргэжлийн ур чадварын тэмцээнд оролцогчийн ажлаа гүйцэтгэх байр, талбай.<br><br>***Эх сурвалж:*** Дэлхийн ур чадварын тэмцээний тайлбар толь, 2013 |
| | **World Skills Competition Workstation** | The area or station where a Competitor works within the workshop.<br><br>***Source***: https://glossary.worldskills.org |
| 86 | **Дэлхийн ур чадварын тэмцээний албан ёсны ажиглагч (АЁА)** | Гишүүн орнуудаас хүрэлцэн ирсэн албаны хүмүүс бөгөөд эдгээр нь ДУЧОУБ-ын уулзалт хурал болон тэмцээн зохион байгуулагчийн явуулж буй тусгай үйл ажиллагаануудад оролцох эрхтэй байна.<br><br>***Эх сурвалж:*** Дэлхийн ур чадварын тэмцээний тайлбар толь, 2013 |
| | **World Skills Competition Official Observer (OO)** | Official Observers are important people from the Member's country/region and have access to World Skills International meetings and special events of the Competition Organizer.<br><br>***Source***: https://glossary.worldskills.org |
| 87 | **Дэлхийн ур чадварын тэмцээний албан ёсны төлөөлөгч (АЁТ)** | Гишүүн орныг тухайн орны Албан ёсны төлөөлөгч болон Техникийн төлөөлөгч төлөөлнө. Стратегийн хороо нь Албан ёсны төлөөлөгчдөөс бүрдэнэ.<br><br>Дэлхийн ур чадварын байгууллагын Ерөнхий чуулга уулзалт нь гишүүд орнуудыг төлөөлөх Албан ёсны төлөөлөгч, Техникийн төлөөлөгч нараас бүрдэнэ. |

***Эх сурвалж:*** Дэлхийн ур чадварын тэмцээний тайлбар толь, 2013

| | |
|---|---|
| **World Skills Competition Official Delegate (OD)** | A Member is represented by an Official and a Technical Delegate. The Strategy Committee consists of the Official Delegates.<br><br>The General Assembly consists of the Official Delegates and the Technical Delegates, representing the Members of the Organization.<br><br>***Source***: https://glossary.worldskills.org/ |
| **88 Дэлхийн ур чадварын тэмцээний багийн ахлагч (БА)** | Багийн ахлагч нарыг гишүүн орнууд сонгох бөгөөд тэмцээний үеэр өөрийн орны оролцогчидтой харилцах үүргийг гүйцэтгэнэ.<br><br>***Эх сурвалж:*** Англи-Монгол Дэлхийн ур чадварын тэмцээний тайлбар толь, 2013 |
| **World Skills Competition Team Leader (TL)** | Team Leaders are people selected by the Members to liaise with the Competitors during the WorldSkills Competition.<br><br>***Source***: https://glossary.worldskills.org |
| **89 Дэлхийн ур чадварын тэмцээний гишүүн** | Худалдаа, үйлчилгээ, аж үйлдвэрийн салбараас улс орон эсвэл бүс нутгийн мэргэжлийн боловсрол, сургалтын тогтолцоог төлөөлж буй, ДУЧОУ байгууллагаар хүлээн зөвшөөрөгдсөн байгууллага.<br><br>ДУЧОУБ-д элсэж, гишүүн хэмээн хүлээн зөвшөөрөгдсөн аливаа улс орон эсвэл бүс нутгийн байгууллага.<br><br>***Эх сурвалж:*** Дэлхийн ур чадварын тэмцээний тайлбар толь, 2013 |
| **World Skills Competition Member** | A body representing a vocational education and training system in a country or region in the area of commerce, services, and industry, and recognized as such by the Organization.<br><br>It is the body that joins WorldSkills International and gets recognized as the Member (organization) for that country/region.<br><br>***Source***: https://glossary.worldskills.org |
| **90 Дэлхийн ур чадварын тэмцээний дэд бүтцийн жагсаалт (ДБЖ)** | Дэд бүтцийн суурилуулалтын жагсаалт гэдэг нь мэргэжлийн ур чадварын тэмцээнийг хэрэгжүүлэх зорилгоор Тэмцээн зохион байгуулагчийн зүгээс олгох материал, тоног төхөөрөмжийн жагсаалт юм.<br>***Эх сурвалж:*** Дэлхийн ур чадварын тэмцээний тайлбар толь, 2013 |
| **World Skills Competition Infrastructure List (IL)** | The Infrastructure List is a list of materials and equipment to be provided by the Competition Organizer for the conduct of a skill competition.<br>***Source***: https://glossary.worldskills.org |
| **91 Дэлхийн ур чадварын** | Ерөнхий чуулга уулзалт бол Дэлхийн ур чадварын олон улсын байгууллагын дээд удирдлага. ЕЧУ нь байгууллагын гишүүдийг |

| | |
|---|---|
| **байгууллагын Ерөнхий чуулга уулзалт (ЕЧУ)** | төлөөлөх Албан ёсны төлөөлөгч, Техникийн төлөөлөгч нараас бүрдэнэ.<br><br>***Эх сурвалж:*** Дэлхийн ур чадварын тэмцээний тайлбар толь, 2013 |
| **World Skills Competition General Assembly (GA)** | The General Assembly is the highest authority in WorldSkills International. The General Assembly comprises the Official Delegates and the Technical Delegates, representing the Members of the Organization.<br>***Source***: https://glossary.worldskills.org |
| **92 Дэлхийн ур чадварын тэмцээний техникийн тодорхойлолт (ТТ)** | Дэлхийн ур чадварын тэмцээн нь мэргэжлийн тэмцээн тус бүрт техникийн тайлбартай байх бөгөөд энэ нь тухайн мэргэжлийн нэр, ажил мэргэжлийн чиг үүрэг, ДУЧОУБ-ын стандарт нөхцөлүүд, үнэлгээний нөхцөлүүд, тэмдэглэгээний систем, тэмцээний даалгаврыг боловсруулах, сонгох, хүчин төгөлдөрт тооцох, өөрчлөх, мэргэжлийн тэмцээнийг хэрэгжүүлэх журам, тодорхой мэргэжилд хамаарах эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, хүрээлэн буй орчны шаардлагууд зэргийг тодорхойлно.<br><br>Техникийн тайлбарт тэмцээнд оролцогч, экспертүүдийн ажлын талбарт авчрахыг хориглосон мөн авчирч болох материал, тоног төхөөрөмжүүдийг тусгана.<br>Түүнчлэн ТТ-д өмнөх тэмцээний талбайн зураглалын жишээг оруулж болно. Гэвч энэ нь тэмцээнийг зохион байгуулагчаас нийлүүлэх материал, тоног төхөөрөмжийг тодорхойлохгүй бөгөөд тэдгээрийг дэд бүтцийн суурилуулалтын жагсаалтад тодорхойлсон байна.<br><br>***Эх сурвалж:*** Дэлхийн ур чадварын тэмцээний тайлбар толь,2013 |
| **World Skills Competition Technical Description (TD)** | In the context of WSC, each skill competition has a Technical Description that defines the name of the skill, the World Skills Standards Specification and scope of work, the development, selection, validation, change (if appropriate), and circulation of the Test Project, the conduct of the competition, skill-specific rules, and any skill-specific safety requirements. It defines those materials and equipment to be supplied by Competitors and Experts, and defines those that are prohibited in the workshop. The Technical Description may also give examples of workshop layout, typically from previous skill competitions.<br><br>It does not define materials and equipment provided by the Competition Organizer - these are defined in the Infrastructure List.<br><br>***Source:*** https://glossary.worldskills.org |
| **93 Дэлхийн ур чадварын тэмцээний техникийн төлөөлөгч (ТТ)** | Гишүүн орныг Албан ёсны төлөөлөгч, Техникийн төлөөлөгч төлөөлнө.<br>Мэргэжлийн хороо нь техникийн төлөөлөгчдөөс бүрдэнэ. Ерөнхий чуулга уулзалт нь Байгууллагын Гишүүдийг төлөөлөх Албан ёсны төлөөлөгч, Техникийн төлөөлөгч нараас бүрдэнэ.<br><br>***Эх сурвалж:*** Дэлхийн ур чадварын тэмцээний тайлбар толь |

**World Skills Competition Technical Delegate (TD)**

A Member is represented by an Official and a Technical Delegate.

The Competitions Committee consists of the Technical Delegates. The General Assembly consists of the Official Delegates and the Technical Delegates, representing the Members of the Organization.

***Source:*** https://glossary.worldskills.org

94 **Дэлхийн ур чадварын тэмцээний даалгавар (ТД)**

Мэргэжлийн тэмцээн тус бүр Тэмцээний даалгавартай байх ба үүний тусламжтайгаар Тэмцээнд оролцогчид мэргэжлийн өндөр ур чадвараа танилцуулах боломжтой. Техникийн тайлбар нь Тэмцээний даалгаврын үлгэрлэх стандарт, ажил үүргийг тодорхойлдог.

Үүнд тэмцээний даалгаврын хэлбэр, бүтэц, боловсруулалт, хүчин төгөлдөр болгох, сонгох, танилцуулах, өөрчлөлтийг (шаардлагатай тохиолдолд) тусгана. Тэмцээний даалгавар 15-22 цагийн хугацаанд 4 өдрийн дотор гүйцэтгэх бүтэцтэй байна. Техникийн тодорхойлолтод тусгасан стандартуудын дагуу Тэмцээнд оролцогчдын гүйцэтгэлийг үнэлэх, ялгах боломжтой байдлаар Тэмцээний даалгаврыг боловсруулсан байна. Түүнчлэн Тэмцээний даалгаврыг талбай, дэд бүтэц, нөөцийн нөхцөлүүдийг аль болох хэмнэлттэй байдлаар боловсруулна.

***Эх сурвалж:*** Дэлхийн ур чадварын тэмцээний тайлбар толь, 2013

**World Skills Competition Test Project (TP)**

Each skill competition has a Test Project to be attempted by the Competitors to demonstrate excellence in their skill. The Technical Description specifies the WorldSkills Standards Specification, scope of work, format/structure, development, validation, selection, circulation, and change (if appropriate) of the Test Project.

Test Projects shall be designed to take between 15 and 22 hours working time, within a period not exceeding four days. The Test Project shall be designed to enable Competitors to demonstrate the standards documented in the Technical Description. It should enable discrimination between Competitors by ensuring a good range of marks and should minimize space, infrastructure, and resource requirements.

***Source:*** https://glossary.worldskills.org

95 **Дэлхийн ур чадварын стандарт нөхцлүүд (ДУЧСН)**

Дэлхийн ур чадварын олон улсын байгууллагын стандарт нөхцөлүүд нь тухайн ажил мэргэжил, эсвэл ажил үүргийн гүйцэтгэлийн олон улсын шилдэг туршлагыг тусгасан тодорхой ур чадвар, ойлголт, мэдлэгийн бүрдлийг агуулна.

***Эх сурвалж:*** Дэлхийн ур чадварын тэмцээний тайлбар толь, 2013

**World Skills Standards Specification (WSSS)**

WorldSkills Standards Specifications are statements of the knowledge, understanding and specific skills that reflect and underpin international best practice in the performance of an occupation or role.

***Source:*** https://glossary.worldskills.org

96 **Дэлхийн ур чадварын тэмцээний ур чадвар/ мэргэжлийн чиглэл**

Энэхүү үг хэллэгийг ерөнхий болон техник, мэргэжлийн боловсрол, сургалт (ТМБС)-ын аль алинд өргөн хэрэглэдэг. ДУЧОУБ-ын хувьд энэхүү үгийг хоёр утгаар хэрэглэдэг. ДУЧОУБ нь Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (ЭЗХАХБ)-ын дүрэм журмыг мөрддөг. Иймээс ур чадвар гэдэг нь боловсрол, сургалт, дадлагажилтын тусламжтайгаар олж авсан дадал туршлага.

Үүний нэг тод жишээ нь компьютер програмчлалын ур чадвар. Хувийн зохион байгуулалт, асуудлыг шийдвэрлэх, сэтгэн бодох чадвар гэх мэт өндөрт түвшний ур чадваруудыг эзэмшсэн байх шаардлагатай. ДУЧОУБ-ын Стандарт нөхцөлүүдийн дагуу мэргэжлийн тэмцээн тус бүр дэлхийн түвшний аж үйлдвэр, бизнесийн шилдэг туршлагыг тусгасан харилцан уялдаатай ур чадваруудын хослолыг илэрхийлнэ. Албан бус байдлаар тэмцээнд оролцох “ур чадвар/тэмцээн” гэж нэрлэж болно. Албан ёсны баримт бичгүүдэд тэмцээнийг бүтэн нэршлээр “Мэргэжлийн тэмцээн” гэж нэрлэнэ. Өдөр тутмын хэрэглээнд “ур чадвар” гэсэн нэр томъёог ажил эсвэл мэргэжил гэсэн утгаар “орлуулан” хэрэглэж болно. Үүнтэй холбоотойгоор төөрөгдөл үүсэх магадлалтай. ДУЧОУБ нь ЭЗХАХБ-ын дүрэм журмыг мөрддөг тул “ур чадвар” болон “ажил мэргэжил” гэсэн нэр томьёог ялгаж салгахыг эрхэмлэнэ. ЭЗХАХБ-аас иш татвал: Оновчтой ур чадварыг бий болгон түүнийгээ амьдрал, ажил мэргэжил болгон хөгжүүлэх явдал гэсэн байна.

***Эх сурвалж:*** Дэлхийн ур чадварын тэмцээний тайлбар толь, 2013

**World Skills Competitions Skill**

This word is used in different ways both generally and in technical and vocational education and training (TVET). Within WorldSkills International (WSI), skill is used in two ways. WSI follows the OECD in using skill to refer to a particular expertise, which is normally gained by education, training and practice. Examples of this are computer programming skills; high level skills such as self-management and problem solving; and thinking skills.

Through the WorldSkills Standards Specification (WSSS), each WSC represents a coherent mix of skills, which together reflect best practice in industry and business across the world. Informally, these competitions may be referred to as skills. In formal documents a skill competition should normally be referred to by its full title, which is skill competition. In everyday use, skill is often used interchangeably with occupation or job. This can create confusion. WSI follows the OECD in maintaining a clear distinction between skill and occupation or job. To quote the OECD: Build the right skills and turn them into better jobs and lives.

***Source:*** https://glossary.worldskills.org

97 **Дэлхийн ур чадварын тэмцээний эксперт(Э)**

Мэргэжлийн салбарын болон техникийн өндөр туршлагатай хүнийг экспертээр томилох бөгөөд Гишүүнийг төлөөлж, өөрийн эзэмшсэн мэргэжлээр тэмцээнд оролцоно.

***Эх сурвалж:*** Дэлхийн ур чадварын тэмцээний тайлбар толь, 2013

**World Skills Competitions Expert (E)**

A person with experience in a skill, trade, or technology who is representing a Member in the skill competition related to their particular expertise.

***Source:*** https://glossary.worldskills.org

98 **Дэлхийн ур чадварын тэмцээний эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, хүрээлэн буй орчин (ЭМААХБО)**

Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, хүрээлэн буй орчин гэдэг нь үйл ажиллагаа, мэргэжлийн тэмцээнд тавигдах Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, хүрээлэн буй орчны шаардлагуудыг хэлнэ.

Тэмцээнийг зохион байгуулагчийн хэрэглэх нэр томьёо өөр байж болно, тухайлбал, Эрүүл мэнд аюулгүй ажиллагаа, Ажил мэргэжлийн эрүүл мэнд аюулгүй ажиллагаа, Ажлын байрны эрүүл мэнд аюулгүй ажиллагаа г.м.

***Эх сурвалж:*** Дэлхийн ур чадварын тэмцээний тайлбар толь, 2013

**World Skills Competitions Health, Safety, and Environment (HSE)**

Health, Safety, and Environment refers to the health, safety, and environment requirements as applied to the event and skill competitions.

The Competition Organizer's terminology may vary, for example: Health and Safety, Occupational Health and Safety, Workplace Health and Safety.

***Source:*** https://glossary.worldskills.org

99 **Дүйцэх/ Дүйцүүлэх (мэргэшил/ гэрчилгээ)**

Хувь хүний эзэмшсэн чадамжийг хүлээн зөвшөөрч, шинэ мэргэшилд шаардлагатай багц цагийг тооцон олгох үйл явц.
Сургалтын хөтөлбөрийг харьцуулах замаар нэг мэргэшлийг нөгөөтэй харьцуулж, мэргэшлүүдийн ижил төстэй байдлын түвшнийг тухайн чиглэлийн мэргэжилтэн тодорхойлдог.

***Тайлбар:***
Дүйцүүлэх боломжийг эрх бүхий мэргэжлийн байгууллага шийдвэрлэдэг.

***Эх сурвалж:*** ТМБС-ын тайлбар толь, ТБУЧХА, Филиппин, 2010; НҮБТМБСТ/ТМБС-ын толь бичиг

**Equivalency (of Qualifications/ Certifications)**

The process of recognizing present competencies and giving credit towards additional qualification.

The comparison of one qualification with another based on a curriculum comparison that enables the degree of similarity of the qualification to be established by a subject matter expert.

***Note***:
Equivalency is typically determined by competent recognition authorities).

***Source***: The TVET Glossary of Terms, TESDA, Philippines, 2010
UNESCO 2015 UNEVOC/TVETipedia Glossary

# Е

**100 Европын Мэргэшлийн түвшний хүрээ (ЕМХ)**

Европын Холбооны гишүүн орнуудын мэргэшлийн тогтолцоон дахь янз бүрийн мэргэшлийн түвшнүүдийг харьцуулах хэрэгсэл.

***Тайлбар***:
- ЕМТХ нь европын орнуудын мэргэшлийн түвшний хүрээ болон мэргэшлүүдийн хоорондын харилцан уялдааг зохицуулах тодорхойлолтуудыг агуулдаг,
- ЕМТХ нь үндэсний мэргэшлүүдийг бүлэглэн эрэмбэлэх механизм болдог,
- ЕМТХ нь 8 түвшинтэй, түвшин тус бүр нь эзэмшвэл зохих мэдлэг, чадвар, чадамж (нэг мэргэшлийн хүрээнд хариуцлагын түвшин, төвөгшлийн байдал, бие дааж ажиллах гэх мэт)-ийн тодорхойлолттой, тэр нь мэргэшлийн түвшингүүдийн хоорондын ялгааг тодорхойлно,
- ЕМТХ нь өөр өөр улс оронд эзэмшсэн мэргэшлүүдийг нэгтгэн уялдуулж, үндэстэн тус бүр мэргэшлийн түвшний хүрээгээ боловсруулах үндэс суурь болдог.

***Эх сурвалж:*** МБС мэргэшлийн түвшний тогтолцооны нэр томьёоны тайлбар толь, (МСС), УБ, 2011

**European Qualifications Framework (EQF)**

A reference tool oto compare different qualifications levels of different qualification systems in member countries of the European Union.

***Note***:
- The EQF includes descriptions allowing reference between qualifications and national qualifications frameworks of member countries
- EQF is as well a ranking mechanism for national qualifications
- EQF includes 8 levels, definition of each level reflects description of relevant knowledge, skills and competence (level of responsibility, complexity, independence of each qualification) to be acquired for that level. This distinguishes the difference between qualification levels
- EQF enables reference between qualifications acquired in different countries and serves as grounds for development of national qualifications framework.

***Source:*** Glossary of Terms for Vocational Education, Training and National Qualifications System, (MCA), UB, 2011

# З

**101 Заавал эзэмших боловсрол**

Хуулиар тогтоосон сургуульд хамрагдах шаардлагатай жил, эсвэл насны хязгаар.

***Тайлбар***:
Монгол Улсын иргэн суурь боловсрол заавал эзэмших үүрэгтэй. ”суурь боловсрол” гэж 9 жилийн сургалтын агуулгын түвшинг хэлнэ.

***Эх сурвалж:*** МУ-ын Боловсролын тухай хууль, МБС, мэргэшлийн түвшний тогтолцооны нэр томьёоны тайлбар толь, (МСС), УБ, 2011

**Compulsary Education**

The number of years or age span during which children are legally obliged to attend school.

***Note***:
All Mongolian citizens are obligated to acquire the compulsory education. ”Compulsory education” is a 9 year level of training content.

***Source***: Law on Education, Glossary of Terms for Vocational Education, Training and National Qualifications System, (MCA), UB, 2011

**102 Завсардалтын түвшин**

Сургалтаа эхэлсэн боловч ямар нэг шалтгаанаар дүүргэж чадаагүй суралцагчдын хувийг илэрхийлсэн үзүүлэлт.

Өөрөөр хэлбэл боловсрол, сургалтаа дүүргэлгүйгээр орхиж явах.

***Эх сурвалж:*** Мэргэжлийн боловсрол, сургалт, мэргэшлийн түвшний тогтолцооны нэр томьёоны тайлбар толь, (МСС), УБ, 2011

**Dropout rate**

The percentage (%) of students failing to complete a particular school or college course.

In other words, withdrawal from an education or training programme before its completion.

***Source***: Glossary of Terms for Vocational Education, Training and National Qualifications System, (MCA), UB, 2011

**103 Зайны сургалт**

Харилцаа холбооны хэрэгслүүд болох ном, радио, телевиз, утас, захидал, компьютер, эсвэл видео бичлэг ашиглан зайнаас олгох боловсрол, сургалт.

МБС-ын салбарын хувьд зайны боловсрол, сургалт нь МБСБ-д элсэгч/ суралцагч сургууль дээрээ очихгүйгээр сургалтад хамрагдаж, суралцах хэлбэр бөгөөд даалгавраа захидал, и-мэйлээр хүргүүлэх боломжтой байдаг.

***Эх сурвалж:*** Төв Европын МБС –ын толь бичиг, (Cedefop), 2008, НҮБТМБСТ/МБС, үнэлгээ баталгаажуулалтын тайлбар толь

**Distance learning**

Education and training imparted at a distance through communication media: books, radio, TV, telephone, correspondence, computer or video.

In the TVET context, distance education (also called *External Studies*) is a mode of education in which trainees / students enrolled in a course do not attend the TVET Institution, but study off-campus and may submit assignments by mail or email.

***Source***: Terminology of European Education and Training Policy, Cedefop, 2008

**104 Засан хүмүүжүүлэх боловсрол, сургалт**

Засан хүмүүжүүлэх байгууллагад ял эдэлж байгаа хүмүүст, ялангуяа засан хүмүүжүүлэх зорилгоор олгох боловсрол, сургалтын хөтөлбөр.

***Эх сурвалж:*** МБС-ын тайлбар толь, МБСҮТ Австрали, 2013

**Correctional education and training**

Education or training programs provided for persons in correctional institutions, especially as part of rehabilitation programs.

***Source:*** Glossary of VET, NCVER, Australia, 2013

# И

**105 Инноваци**

Шинэ мэдлэгийг баялаг болгон хувиргах цогц үйл явц.

"Шинэ мэдлэг" гэж Шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагааны үр дүнд бий болсон эдийн засаг, нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор ашиглаж болохуйц, эрхийн хамгаалалт хийгдсэн оюуны бүтээл. "Инновацийн үйл ажиллагаа" гэж шинэ санаа, шинэ мэдлэгийг эдийн засгийн эргэлтэд оруулах замаар өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүн, технологи, ажил, үйлчилгээг бий болгож зах зээлд нийлүүлэхэд чиглэсэн арга хэмжээг;

"Инновацийн бүтээгдэхүүн" гэж хуулиар тогтоосон шаардлага, нөхцөлийг хангасан, зах зээл дээрх ижил төстэй бүтээгдэхүүн, үйлчилгээнээс техник, эдийн засгийн үзүүлэлт, шинжлэх ухааны багтаамж, нэмүү өртөг бий болгох болон өрсөлдөх чадвараар илүү инновацийн үйл ажиллагааны үр дүнг.

Шинэ санааг ашиглан өртгийг бий болгох, эсвэл хэрэглэгчийн төлбөр төлөх бараа бүтээгдэхүүн, үйлчилгээ болгон хөрвүүлэх үйл явц.

***Эх сурвалж:*** Инновацийн тухай Монгол улсын хууль, 2012

**Innovation**

The process of translating an idea or invention into a good or service that creates value or for which customers will pay.

*New knowledge* means intellectual property protected by ownership rights that can be used to resolve social and economic issues resulting from scientific and technological operations.

*Innovation process*: Activity aiming to supply competitive products, technology, work and services to the market based on introduction of new idea and knowledge into economic cycle.

*Innovation product*: outcomes of innovation process more competitive and creating added value and scientific capacity, technical and economic index from similar products and services on the market that satisfies the terms and criteria established by the law.

***Source:*** Innovation Law, Mongolia, 2012

# К

**106 Компани/ аж ахуй нэгжийн сургагч багш**

Мэргэжлийн сургалтыг удирдан чиглүүлэх багш нь үйлдвэрлэл, технологийн туршлагатай, мэргэжлийн өндөр зэрэгтэй, багшлах эрхтэй байна.

Байгууллага дээрээ эсвэл байгууллагын зүгээс ажилтнуудаа сургалт зохион байгуулж, албан бус сургалтын орчинд насанд хүрэгчдийн сургалтад дэмжлэг үзүүлдэг байгууллагын дотоод сургагч багшийг компани, аж ахуй нэгжийн сургагч багш гэж тодорхойлдог.

***Эх сурвалж:*** Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай МУ- ын хууль, 2009
Төв Европын МБС –ын толь бичиг, (Cedefop), 2015

**In-Company trainer**

In-company trainers are defined as internal trainers (employed by the company) who provide internal training (training organised and carried out in and/or by the company for their staff) and support learning of adults (CVET) in non-formal and informal learning environments within the company.

In-company trainers should have industry and technological experience, high professional rank and teaching rights.

***Source***: Law of Mongolia on Vocational Education and Training, Mongolia, 2009
Terminology of European education and training policy, Cedefop, 2015

**107 Компани/ аж ахуй нэгжийн сургалт**

Аж ахуй нэгж дээрх сургалт нь 2 төрөл байж болно.
1-рт: Хосмог сургалтын тогтолцооны бүрэлдэхүүн бөгөөд үүнд аж ахуйн нэгж дээрх өдөр тутмын ажлын хуваарьт дадлагын сургалтыг нэгтгэж, суралцагчийг хамруулдаг.

Ажил мэргэжилтэй холбоотой ур чадвар, дадал, чадамжийг олгох зорилгоор тусгайлан боловсруулсан сургалтын агуулга, урьдчилан тогтсон төлөвлөгөө бүхий ажлын байран дээр зохион байгуулагдах сургалтын үйл ажиллагаа.

Үүнд аж ахуйн нэгж, суралцагч, МБС-ын байгууллага хоорондоо дадлагын сургалтыг хэрэгжүүлэх гурван талт гэрээг байгуулна.

2-рт: Аж ахуйн нэгжийн өөрийн ажилтнуудад зориулсан сургалт байж болно. Монгол улсын Хөдөлмөрийн хуулийн дагуу тавиас дээш ажилтантай аж ахуйн нэгж суралцагчийн онолын болон үйлдвэрлэлийн дадлагын ажлыг зохион байгуулж, удирдан чиглүүлэх үүрэг бүхий дадлагажуулагч багш ажиллуулах үүрэгтэй.

***Эх сурвалж:*** МБС-ын тухай МУ-ын хууль, 2009
ТМБС-ын тайлбар толь, ТБУЧХА, Филиппин, 2010

**In-company training**

In-company training is of two types.

In the first type, it can be, portion of the Dual Training System program where students/trainees receive practical learning by being integrated in the regular work system of an establishment/business enterprise.

This type of training acticity is conducted at workplace with a

predeifined plan and specially developed education content to provide with competency, skills and practice related to occupation.

For this, a Trilateral Agreement is signed between company, learner and TVET institution on conducting the practical training.

In the second type, in-company training is for the company staff themselves. As per the Mongolian Labour law, a company with more than 50 staff members is obliged to have a trainer responsible to manage and organize industry based theoretical and practical training for the staff.

***Source***: Law of Mongolia on Vocational Education and Training, Mongolia, 2009
The TVET Glossary of Terms, TESDA, Philippines, 2010

# M

**108 Магадлан итгэмжлэгдсэн хөтөлбөр**

Гэрчилгээжүүлэлтийн стандарт, шалгуурыг хангасны үндсэн дээр магадлан итгэмжлэх байгууллагаас баталгаажуулагдсан, эсвэл магадлан итгэмжлэгдсэн мэргэшил.

***Эх сурвалж:*** http://www.accreditedqualifications.org.uk

**Validated/ Accredited program**

Qualifications which have been granted approval by an accrediting agency or organization as having met specific requirements or certification standards.

***Source***: http://www.accreditedqualifications.org.uk

**109 Магадлан итгэмжлэх байгууллага/ агентлаг**

Улсын эрх зүйн зохицуулалтын дор ажилладаг байгууллага, хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийг удирддаг байгууллага.

Тухайлбал гүйцэтгэлийн стандартыг тогтоож, магадлан итгэмжлэл, мэргэшлийн зэрэг олгох эрх бүхий үндэсний мэргэшлийн агентлаг, албан ёсны хяналтын хороо эсвэл бусад эрх бүхий албан байгууллагууд.

Магадлан итгэмжлэх байгууллага бүр чанарын стандартуудын дагуу гүйцэтгэлийн явцыг хянадаг.

Монгол улсад Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөл нь их сургууль, МБС-ын байгууллагуудын магадлан итгэмжлэлийг хариуцдаг.

***Эх сурвалж:*** Мэргэжлийн боловсрол, сургалт, мэргэшлийн түвшний тогтолцооны нэр томьёоны тайлбар толь, (МСС), УБ, 2011

**Accrediting agency**

Accrediting agencies are those entities that manage program and organizational accreditation under national legislation such as, national qualifications agencies, official review boards or other nationally approved bodies or agencies with the remit to establish achievement standards and/or accredit qualifications.

All accrediting agencies are subject to ongoing monitoring and

periodic review of their performance against quality standards.

In Mongolia, Mongolia National Council for Educational Accreditation (MNCEA) is responsible for accreditation of Universities and VET centres.

***Source***: Glossary of Terms for Vocational Education, Training and National Qualifications System, (MCA), UB, 2011

**110 Модуль**

Дангаар нь эсвэл сургалтын хөтөлбөрийн нэг бүрэлдэхүүн хэсэг болгон суралцах буюу нэг болон хэд хэдэн чадамжийн нэгжийг эзэмших боломжтой сургалтын бүрэлдэхүүн.

Модуль нь зохих стандартад нийцэх үнэлгээний ажилтанд зориулсан удирдамжийг агуулна. Модуль нь дараах агуулгыг багтаасан байна. Үүнд:

- Ажлын хүрээнд гүйцэтгэх тодорхой үйл ажиллагаа
- Гүйцэтгэсэн ажил биш, харин хүлээгдэж буй үр дүн
- Ажил дээр үнэлж, бодитой гарах үр дүн
- Тодорхой шалгуур
- Стандартын хамрах хүрээ
- Тогтоосон стандартуудын дагуу үнэлгээ хийх удирдамж

***Эх сурвалж:*** МБС-ын тайлбар толь, МБСҮТ Австрали, 2013

**Module**

A self-contained block of learning which can be completed on its own or as part of a course and which may also result in the attainment of one or more units of competency.

The modules should include guidance for assessors pertinent to the related standards. A module should describe:

- Distinct work activity
- Work outputs expected, not what is put into the work
- Outputs that can be demonstrated and assessed at work
- Precise criteria
- Scope of the standard
- Guidelines for assessors on how to assess against the standard (level)

***Source:*** Glossary of VET, NCVER, Australia, 2013

**111 Модульчилсан сургалт**

Хувь хүний хэрэгцээ, техникийн хөгжил дэвшил, ажил мэргэжлийн бүтэц зэрэгт нийцүүлэн тогтмол сайжруулах шаардлагатай, бие даасан нэгж эсвэл модулиудаас бүрдсэн сургалтын хөтөлбөр.

***Эх сурвалж:*** ТМБС-ын тайлбар толь, ТБУЧХА, Филиппин, 2010

**Modular training**

A system where training content is divided into independent units or modules which can be combined to form a program suited to individual needs, technical developments, or occupational structure, etc., permitting continuous adaptation of the program.

***Source:*** The TVET Glossary of Terms, TESDA, Philippines, 2010

112 **Мөшгөх судалгаа**

*Мөшгөх судалгаа, төгсөгчдийн судалгаа*

Сургалтын төгсгөлд эсвэл сургууль төгссөнөөс хойш тодорхой хугацааны дараа хийгддэг сургалтын байгууллагын төгсөгчийн судалгаа (бичгэн эсвэл аман хэлбэрээр). Мөшгөх судалгааны агуулга олон янз байх боловч сурлагын амжилт, ажилд орсон байдал, ажил хоорондын шилжилт хөдөлгөөн, сурсан чадамжуудын хэрэглээ, одоогийн ажиллаж байгаа эсвэл суралцаж байгаа байгууллага (сургууль, төв, их сургууль)-тай харилцаа холбоотой байгаа эсэх г.м түгээмэл асуултууд орсон байна.

***Эх сурвалж:*** Мөшгөх судалгаа хийх, ур чадвар, ажил мэргэжлийг уялдуулах гарын авлага, Х. Шомбүрг, Европын сургалтын сан, 2016

**Tracer study**

*Also called Graduate survey*

Survey (in written or oral form) of graduates from education and training institutions, which takes place some time after graduation or at the end of the training. The subjects of a tracer study can be manifold, but common topics include questions on study progress, the transition to work, work entrance, job career, use of learned competencies, current occupation and bonds to the education institution (school, centre, university).

***Source:*** Carrying out tracer studies, Guide to Anticipating and Matching Skills and Jobs, Schomburg, H., European Training Foundation, 2016

113 **Мэнтор**

Мэнтор" залуучууд, суралцагчдад янз бүрийн хэлбэрээр зөвлөгөө, дэмжлэг үзүүлдэг туршлагатай хүн.

Ментор нь гол төлөв үлгэр дуурайл болж, чиглүүлэгч, зааварлагч, дадлагажуулагч, халамжлан зөвлөгчийн, үүрэг гүйцэтгэдэг.

***Эх сурвалж:*** IIEP Тайлбар толь, IIEP Сургалтын хүрээ

**Mentor**

An experienced person who provides guidance and support in a variety of ways to a young person or novice (i.e., someone joining a new learning community or organization).

The 'Mentor' often acts as a role model, guide, tutor, coach or confidante.

***Source:*** IIEP Glossary, IIEP Learning Portal, UNESCO https://learningportal.iiep.unesco.org/en/glossary

114 **Менторын үйлчилгээ (халамжлах, зөвлөх)**

Чиглүүлэгч, зааварлагч, сургагчийн үүрэг бүхий туршлагатай хүн залуучууд болон шинээр элсэгчдэд (сургалтад эсвэл байгууллагад шинээр орж буй хүн) удирдамж, чиглэл, дэмжлэг, туслалцаа үзүүлэх арга хэлбэр

***Эх сурвалж:*** Төв Европын МБС –ын толь бичиг, (Cedefop), 2008

**Mentoring** Guidance and support provided in a variety of ways to a young person or novice (i.e., someone joining a new learning community or organisation) by an experienced person who acts as a role model, guide, tutor, coach or confidante.

***Source:*** Terminology of European education and training policy, Cedefop, 2008

115 **Мэргэжил** Мэргэжил гэж үндсэн үүрэг, ажилбарууд нь хоорондоо ижил төстэй ажлуудын цогц.

***Эх сурвалж:*** ОУХБ, Глобал, 2007

**Occupation** An occupation is defined as a set of jobs whose main tasks and duties are characterised by a high degree of similarity.

***Source:*** ILO, Global, 2007

116 **Мэргэжилтэй ажилтан** Тодорхой ажил эрхлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар эзэмшсэн эсвэл сургалтаар олж авсан мэдлэг, ур чадвараа эрх бүхий байгууллагаар баталгаажуулсан мэргэжилтэй хүн.

***Тайлбар***:
Суурь ур чадвар, тусгай мэргэжил эзэмшсэн болон их, дээд сургууль төгссөн мэргэжилтэй ажилтныг хэлнэ.
Уг нэр томьёогоор тухайн мэргэжлийн ажил, үүргийг гүйцэтгэхэд ажилтанд шаардагдах мэдлэг, чадвар олгох боловсрол, сургалтын стандартуудыг тодорхойлно.

***Эх сурвалж:*** Мэргэжлийн боловсрол, сургалт, мэргэшлийн түвшний тогтолцооны нэр томьёоны тайлбар толь, (МСС), УБ, 2011
Тайлбар толь, АНУ-ын Хөдөлмөр эрхлэлтийн эрх тэгш байдлын хороо: Хувийн сектор дахь цөөнхийн бүлэг ба эмэгтэйчүүдийн ажил эрхлэлтийн ангилал

**Professional worker/ Professionals** Qualified person who's skills and knowledge necessary to conduct specific occupation and obtained through relative training was verified by an authorized entity.

***Note***:
Qualified worker who acquired the basic skills and specialized qualification, and graduated higher education institution.

The term describes the standards of education and training that prepare members of the profession with the particular knowledge and skills necessary to perform their specific role within that profession.

***Source***: Glossary of Terms for Vocational Education, Training and National Qualifications System, (MCA), UB, 2011
Glossary, U.S. Equal Employment Opportunity Commission: Job Patterns For Minorities And Women In Private Industry;

117 **Мэргэжлийг тасралтгүй** Хувь хүн анх сургалтад хамрагдсанаас хойш ажил хөдөлмөр эрхлэх явцдаа албан болон албан бус хэлбэрээр туршлага, мэдлэг,

**дээшлүүлэх** ур чадвараа дээшлүүлэх, баримтжуулах үйл явц.

Өөрөөр хэлбэл хувь хүний сурч мэдсэн зүйл, хуримтлуулсан туршлага болон түүнийг хэрхэн ашигласан талаарх бүртгэл. Боловсрол, сургалтын салбарт тасралтгүй мэргэжил дээшлүүлэхийг “насан туршийн боловсрол” гэж нэрлэдэг.

***Эх сурвалж:*** www.jobs.ac.uk/careers-advice/.../what-is-continuing-professional-development-cpd

**Continuing professional development**

It refers to the process of tracking and documenting the skills, knowledge and experience that one gains both formally and informally as he/she works, beyond any initial training.

In education and training continuous professional development is also termed as ‘life-long learning’.

***Source***: www.jobs.ac.uk/careers-advice/.../what-is-continuing-professional-development-cpd

**118 Мэргэжлийн боловсрол, сургалт (МБС)**

Хөдөлмөрийн зах зээл дээр тодорхой ажил, мэргэжил эрхлэхэд шаардлагатай мэдлэг, туршлага, ур чадвар, чадамжийг олгоход чиглэсэн сургалт.

Мэргэжлийн боловсролыг ерөнхий эсвэл мэргэжлийн боловсролын агуулгын хүрээнд боловсролын байгууллагад эсвэл ажлын байран дахь сургалттай хослуулсан ажлын байран дахь анхан шатны сургалтын бүрэлдэхүүн байдлаар олгох боломжтой.

***Эх сурвалж:*** Төв Европын МБС –ын толь бичиг, (Cedefop), 2008; ЕХ-ны хороо (Eurostat) , 2016

**Vocational education and training (VET)**

Education and training which aims to equip people with knowledge, know-how, skills and/or competences required in particular occupations or more broadly on the labour market.

Vocational education may be undertaken at an educational institution, as part of secondary or tertiary education, or may be part of initial training during employment, for example as an apprentice, or as a combination of formal education and workplace learning.

***Source***: Terminology of European Education and Training Policy, Cedefop, 2008
EU commission (Eurostat), 2016

**119 Мэргэшил дээшлүүлэх сургалт**

Тодорхой мэргэжил эзэмшсэн хүмүүсийн мэргэжлийг дээшлүүлэх, ахиулах, мэргэшүүлэх үүднээс зохион байгуулдаг сургалтын үйл ажиллагаа.

Мэргэжлийн гүйцэтгэлийг сайжруулах зорилго бүхий аливаа сургалт, үйл ажиллагаа.

- Тодорхой мэргэжлийн болон ерөнхий ур чадварыг дээшлүүлэхэд чиглэнэ. (багаар ажиллах, цагийн менежмент, хэлэлцээр хийх, зөрчлийг шийдвэрлэх, харилцааны чадвар г.м);

- Албан ёсны сургалт, бие даан суралцах, удирдлага, зөвлөмжөөр хангах, хурал, зөвлөгөөн хийх удирдан чиглүүлэх дадлагажуулах, олон нийт практик үйл ажиллагаа, мэдлэг туршлагаа хуваалцах зэрэг хэлбэртэй байж болно.

***Эх сурвалж:*** МБС, мэргэшлийн түвшний тогтолцооны нэр томьёоны тайлбар толь, (МСС), УБ, 2011

**Professional development course/training**

Training activity organized to specialise the occupied people with specific qualifications to a higher level.

Any action or training undertaken to improve professional performance:

- Encompasses specific skills and generic skills (team or time management, negotiation skills, conflict management, communication, etc.)
- May take the form of self-learning, formal training, consultation, conferences, coaching or mentoring, communities of practice and technical assistance.

***Source***: Glossary of Terms for Vocational Education, Training and National Qualifications System, (MCA), UB, 2011

**120 Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага**

“Сургалтын байгууллага“ гэж боловсролын нэг буюу хэд хэдэн түвшний боловсролын агуулгыг хэрэгжүүлдэг хуулийн этгээд.

Мэргэжлийн болон техникийн боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллага нь иргэний сонирхол, авьяас, чадварыг харгалзан хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн мэргэжил олгох, ур чадварыг нь дээшлүүлэх үүрэг бүхий байгуулага.

***Эх сурвалж:*** Боловсролын тухай МУ-ын хууль, 2007
МБС-ын тухай МУ-ны хууль, 2009

**Vocational Education and Training institution**

“Training institution” is a legal entity implementing one or more level of educational content.

Vocational and technical education and training institution is an organization responsible to provide with profession that meets the labour market demand depending on skills, talent and interest of a citizen and improve his/her skills.

***Source:*** Law of Mongolia on Education, 2007
Law of Mongolia on Vocational Education and Training, 2009

**121 Мэргэжлийн Боловсрол, Сургалтын Олон Улсын Холбоо (МБСОУХ)**

Мэргэжлийн ур чадвар олгодог сургалтын байгууллага, бизнесийн болон үйлдвэрийн байгууллага, мэргэжлийн боловсрол, сургалтад хамааралтай хувь хүн, нийгмийн бүлэг холбооны олон улсын сүлжээ. МБСОУХ нь дэлхий даяар мэргэжлийн боловсрол, сургалтыг хөгжүүлэх чанарыг нь дээшлүүлэх үйлсэд хүчин зүтгэдэг.

***Эх сурвалж:*** Мэргэжлийн боловсрол, сургалт, мэргэшлийн түвшний тогтолцооны нэр томьёоны тайлбар толь, (МСС), УБ, 2011

**International Vocational Education and Training Association (IVETA)**

IVETA (International Vocational Education and Training Association) is a network of vocational educators.

The network includes vocational skills training organizations, business and industrial firms, and other individuals and groups interested or involved in vocational education and training worldwide. IVETA is dedicated to the advancement and improvement of high-quality vocational education and training throughout the world.

***Source***: Glossary of Terms for Vocational Education, Training and National Qualifications System, (MCA), UB, 2011

**122 Мэргэжлийн Боловсрол, Сургалтын Үндэсний Зөвлөл**

Мэргэжлийн боловсрол, сургалтын үндэсний зөвлөл нь мэргэжлийн боловсрол, сургалтын талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэхэд төр, хувийн хэвшлийн тэнцүү оролцоог хангаж, тогтвортой ажиллах баталгааг бүрдүүлсэн орон тооны бус байгууллага.

***Эх сурвалж:*** Мэргэжлийн Боловсрол, Сургалтын тухай МУ-ын хууль, 2009

**National Council for Vocational Education and Training (NCVET)**

National Council for Vocational Education and Training (hereinafter called "the Council") is non-staff organization to ensure equal participation of governmental and private sectors in implementation of governmental policy in regard to vocational education and training, to ensure their stable operation.

***Source***: Law of Mongolia on Vocational Education and Training, 2009

**123 МБСБ-ын магадлан итгэмжлэл**

Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын хөтөлбөрийн магадлан итгэмжлэл нь мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын үйл ажиллагааны түвшин, сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн чанарт мэргэжлийн хөндлөнгийн үнэлгээ хийж дүгнэлт гаргах ажиллагаа.

Боловсролын магадлан итгэмжлэл нь боловсролын байгууллага чанарын урьдчилан тогтоосон шалгуур, үзүүлэлтүүдийг хангаж байгаа буюу давуулан биелүүлж буй эсэх эсвэл түүний тодорхой салбарын үйл ажиллагааг эрх бүхий мэргэжлийн, хөндлөнгийн этгээд уг байгууллагын өөрийн үнэлгээнд тулгуурлан, сонирхлын бүлгийнхэнтэй хамтран магадлан нотолж, чанартай эсэхийг хүлээн зөвшөөрөх үйл ажиллагаа.

***Эх сурвалж:*** Боловсролын тухай МУ-ын хууль, 2007
Боловсролын Магадлан Итгэмжлэл, УБ, 2009
НҮБТМБСТ/МБС, үнэлгээ баталгаажуулалтын тайлбар толь

**Accreditation of VET insitutions**

Accreditation of vocational education and training institution is a process to conduct professional and independent assessment and draw conclusions on quality of curricula implementation and operational level of vocational education and training institution.

Accreditation is carried out by an independent body or authorized professional entity jointly with interested parties, based on self

assessment of the educational institution or its branch and external assessment (also called ‘audit’) by the accreding body on pre-defined indicators and criteria of quality.

***Source***: Law of Mongolia on Education, 2007
Accreditation of Education, UB, 2009
UNEVOC/Glossary of Terms for TVET, Assessment and Verification

124 **Мэргэжлийн бүлэг**

Өөр хоорондоо хамааралтай, холбоотой мэргэжлүүдийн бүлэг.
Ажлын чиг үүрэг нь өөр өөр мэргэжилд хамаардаг ч гэсэн адил төрлийн чадвар, эв дүй, хөдөлмөрийн үүрэгтэй хүмүүсийн бүлэг юм. Жишээ нь: засварчин, жолооч, механикч, оёдолчин, барилгачин гэх мэт өөр өөр мэргэжилтэй хүмүүс ажлын нийтлэг чиг үүрэгтэй байдаг.

Мэргэжил хослох, ажил үүрэг хавсрах, кредит шилжүүлэх үйл ажиллагаанд мэргэжлийн бүлгийн саналыг харгалзана.
Мэргэжлийг ижил төстэй чадамж, ур чадвар, сургалт гэсэн үзүүлэлтүүдээр бүлэглэн ангилсан мэргэжлүүдийн цогц.

***Эх сурвалж:*** МБС, мэргэшлийн түвшний тогтолцооны нэр томьёоны тайлбар толь, (МСС), УБ, 2011

**Occupational group/family**

Group of people with labour role pertaining to different occupations but acquired similar skills, craft and labour role to perform their work, but. For example: repairman, drivers, mechanic, sewer, construction worker etc. different occupations may have similar labour roles.

***Source***: Glossary of Terms for Vocational Education, Training and National Qualifications System, (MCA), UB, 2011
http://www.businessdictionary.com/

125 **Мэргэжлийн бэлтгэл**

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээний хүрээнд залуучууд сургуулиа төгсөөд ажлын талбарт гарахад нь дэмжлэг үзүүлэх, хөдөлмөр эрхлэх боломжийг нь дээшлүүлэх, ажил хөдөлмөр эрхэлж эхлэхэд учрах саад бэрхшээлийг хэрхэн даван туулахыг зааж сургахад чиглэгдсэн хөтөлбөрүүд.

***Эх сурвалж:*** МБС, мэргэшлийн түвшний тогтолцооны нэр томьёоны тайлбар толь, (МСС), УБ, 2011
МБС-ын тайлбар толь, МБСҮТ Австрали, 2013

**Vocational preparation**

Programs designed to ease the transition from school-to-work, enhance the employability of young people and teach them how to cope with the world of work.

***Source***: Glossary of Terms for Vocational Education, Training and National Qualifications System, (MCA), UB, 2011
Glossary of VET, NCVER, Australia, 2013

126 **Мэргэшүүлэх ур чадвар**

Мэргэжлийн нарийн ур чадвар бөгөөд суралцагч суурь боловсролын дараа техник мэргэжлийн боловсрол сургалтад хамрагдах, эсвэл сургалтын нэмэлт хөтөлбөрт хамрагдах замаар өөрт тохирсон ажил мэргэжил эрхэлж, сэтгэл ханамжтай амьдрах боломжийг олгох “мэдлэг, туршлага” юм.

Эдгээр ур чадвар нь тодорхой ажил хөдөлмөр, ажил үүрэг, академийн сургалт (багш, газар зүйч, эмч эсвэл сэтгүүлч г.м), эсвэл тодорхой мэдлэг, ур чадварын хүрээг (хобби) хамаарч болно. Хүсэл сонирхол, цаашид үргэлжлүүлэн суралцах байдлаас хамааран хувь хүн нэг буюу хэд хэдэн ур чадвараар мэргэших боломжтой.

***Эх сурвалж:*** ЮНЕСКО, Бангкок, 2014

**Specialised skills**

Specialised skills include the specific "know-how" needed for a fulfilling and meaningful life and decent employment which learners acquire often as a result of their participation in post-basic education, including through technical and vocational education and training (TVET) or extra-school activities.

These skills may relate to a specific job, task, academic discipline (e.g. teacher, geographer, medical doctor or journalist) or area of particular knowledge and skills (e.g. hobby). Depending on their interest and further learning, individuals may possess one or several specialised skills.

***Source:*** UNESCO (Bangkok) 2014

**127 Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв (МСҮТ)**

Мэргэжлийн болон техникийн боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллага нь иргэний сонирхол, авьяас, чадварыг харгалзан хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн мэргэжил олгох, техникийн боловсрол эзэмшүүлэх, ур чадварыг нь дээшлүүлэх үүрэг бүхий байгууллага мөн.

Мэргэжлийн болон техникийн боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллага нь чиг үүргээсээ хамааран мэргэжлийн боловсролын, техникийн боловсролын болон мэргэжлийн сургалтын гэсэн ангилалтай байна.

Мэргэжлийн боловсролын сургалтын байгууллага нь мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв байна.

Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийг бие даасан, эсхүл сургалтын бусад байгууллагатай хамтран зохион байгуулж болно.

***Эх сурвалж:*** МБС-ын тухай МУ-ын хууль, 2009

**Vocational training and production center (VTPC)**

The training institution for vocational and technical education with a responsibility to provide with occupations and technical education which meet the labour market demand, and to enhance skills, considering citizens' interest, talent and skills.

Training institutions providing vocational and technical education shall have a classifications such as vocational education, technical education and vocational training depanding on their mission.

Vocational education and training institution shall be Vocational Training and Production Center.

The Vocational Training and Production Center may be organized

independently or jointly with other training organizations.

***Source:*** Law of Mongolia on Vocational Education and Training, 2009

**128 Мэргэжлийн сургалттай ерөнхий боловсролын сургууль**

Сурагчдад мэргэжлийн сургалтыг ерөнхий боловсролын хөтөлбөртэй хослуулан олгоход чиглэсэн сургалтын хөтөлбөрийн хэлбэр.
Ерөнхий боловсролын сургуулийн сурагчид ахлах түвшний боловсролын гэрчилгээ эзэмшихээр суралцаж байх үедээ сургалтын хөтөлбөрт багтсан МБС-ын агуулгыг эзэмшсэнээр үндэсний хэмжээнд хүлээн зөвшөөрсөн мэргэжил эзэмшихэд шаардлагатай багц цагийг хуримтлуулах боломж бүрдүүлнэ. ЕБС дээрх МБС-ын хөтөлбөрт ажлын байрны зуучлал багтаж болно. Суралцагчид ерөнхий боловсролын гэрчилгээ олгохын зэрэгцээ МБС-ын гэрчилгээ олгодог.

***Эх сурвалж:*** МБС-ын тайлбар толь, МБСҮТ Австрали, 2013

**Secondary schools with vocational training**

A program which allows students to combine vocational studies with their general education curriculum.

Students participating in VET in secondary schools continue to work towards their Senior Secondary School Certificate, while the VET component of their studies gives them credit towards a nationally recognised VET qualification. VET in secondary schools programs may involve also structured work placements.

***Source:*** Glossary of VET, NCVER, Australia, 2013

**129 Мэргэшлийн ур чадвар**

Тодорхой мэргэжлийн ажил, үүргүүдийг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай мэдлэг, туршлага, ур чадвар.

Жишээ нь: харилцааны чадвар, төслийн удирдлага гэх мэт.

***Эх сурвалж:*** МБС, мэргэшлийн түвшний тогтолцооны нэр томьёоны тайлбар толь, (МСС), УБ, 2011

**Professional skills**

Specific knowledge, experience and skills necessary to perform tasks within a profession; for e.g., communication skills, project management etc.

***Source***: Glossary of Terms for Vocational Education, Training and National Qualifications System, (MCA), UB, 2011

**130 Мэргэжлийн суурь чадамж**

Хувь хүн мэргэжлийн тодорхой түвшинд чадамжтай гэж хүлээн зөвшөөрөгдөхийн тулд заавал эзэмшсэн байх шаардлагатай аж үйлдвэрийн салбараас тогтоосон чадамжийн стандартын нэгж.
Мэргэжлийн суурь чадамжууд нь тодорхой салбар, мэргэжлийн ажил үүргийн гол үндсэн ажилбарыг хамарна.

***Эх сурвалж:*** МБС-ын тайлбар толь, МБСҮТ Австрали, 2013

**Core competence**

A unit of competency within a competency standard that an industry has agreed is essential to be achieved if a person is to be accepted as

competent at a particular level.

Core competencies are normally those central to the work of a particular industry or occupation.

***Source:*** Glossary of VET, NCVER, Australia, 2013

**131 Мэргэжлийн чиг баримжаа ба зөвлөгөө**

"Мэргэжлийн зөвлөгөө" гэж хүмүүст ажил, мэргэжлээ зөв сонгоход нь туслах зөвлөмж, зааварчилгаа өгөх үйл явц.

Ажил мэргэжлийн чиг баримжаа гэдэг нь аль ч насны хүмүүс амьдралынхаа туршид боловсрол, сургалт, ажил мэргэжлийн сонголтоо хийх, дэвшилт гаргахад нь туслах зорилгоор үзүүлэх үйлчилгээ, үйл ажиллагаанууд орно. Энэхүү үйлчилгээг сургууль, их сургууль, коллеж, сургалтын байгууллага, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, ажлын байр, сайн дурын олон нийтийн байгууллага хувийн хэвшлийн салбараас авах боломжтой.

***Эх сурвалж:*** ТМБС-ын тайлбар толь, ТБУЧХА, Филиппин, 2010

**Career guidance and counseling**

Career Counseling (also called *Guidance Counseling* or *Vocational Counseling)* is the process of assisting and guiding people (employees, trainees and students) in their career choices.

Career counsessling includes services and activities intended to assist individuals of any age and at any point throughout their lives, to make educational, training and occupational choices and to manage their careers. Such services may be found in schools, universities and colleges, in training institutions, in public employment services, in the workplace, in the voluntary or community sector in the private sector.

***Source:*** The TVET Glossary of Terms, TESDA, Philippines, 2010

**132 Мэргэшил**

Боловсролын хөтөлбөр, эсвэл хөтөлбөрийн тодорхой үе шатыг амжилттай дүүргэснийг баталгаажуулж олгох баримт бичиг буюу албан ёсны баталгаажуулалт.

Мэргэшлийг дараах байдлаар эзэмших боломжтой:
а) хөтөлбөрийг бүрэн амжилттай дүүргэх;
б) хөтөлбөрийн тодорхой үе шатыг амжилттай дүүргэх (дунд түвшний мэргэшил);
в) Сургалтын хөтөлбөрийг бие даан эзэмшсэн чадамж, чадвар, мэдлэгийг баталгаажуулах.
г) "Мэргэшлийг баталгаажуулалт" гэдэг нь гэрчилгээ олгох албан ёсны шаардлагыг хангах стандарт, нэгжийн багцыг хэлнэ.

***Эх сурвалж:*** ЮНЕСКО/ UIS, 2013

**Qualification**

The official confirmation usually in the form of a document certifying the successful completion of an educational programme or of a stage of a programme.

Qualifications can be obtained through:

- successful completion of a full programme;
- successful completion of a stage of a programme (intermediate qualifications); or
- validation of acquired knowledge, skills and competencies, independent of participation in such programmes.
- In the context of "Validation of Qualifications", it is a package of standards or units judged to be worthy of formal recognition in a certificate.

***Source:*** UNESCO UIS, 2013ILO (SED) 2007

**133 Мэргэшлийн ил тод байдал**

Салбарын, бүс нутгийн, үндэсний болон олон улсын түвшинд хөдөлмөрийн зах зээл ба боловсролын тогтолцоонд мэргэшлийн үнэлэмж, мөн чанар ил тод ойлгомжтой байхыг хэлнэ.

***Эх сурвалж:*** Төв Европын МБС –ын толь бичиг, (Cedefop) 2008

**Transparency of qualifications**

The degree of visibility and legibility of qualifications, of their content and value on the (sectoral, regional, national or international) labour market and in the education and training systems.

***Source:*** Terminology of European Education and Training Policy, Cedefop, 2008

**134 Мэргэшлийн түвшин**

Мэргэшил нь ажил олгогч, багш, суралцагчдад юу сурсан болон сургалтын үр дүнд юу хийж чаддаг болсныг харуулдаг.

Мэргэшлүүд янз бүр байх бөгөөд тэдгээрийг харьцуулах болон дараагийн шатанд өөр ямар мэргэшлүүдийг эзэмшиж болохыг харуулах үүднээс бүлэглэн ангилдаг.

Монголын мэргэшлийн тогтолцооны Үндэсний **хүрээ нь 10 түвшинтэй** байхаар зөвшилцсөн.

***Тайлбар***:
- Мэргэшлийн түвшин нь ихэвчлэн мэргэшлийн тогтолцоон дахь эсвэл мэргэшлийн хүрээний түвшний ойлголт тодорхойлолтоор илэрхийлэгддэг.
- Мөн ажил мэргэжлийн чиг, үүргийн хүрээгээр тодорхойлж болно. (тухайлбал, аливаа мэргэжлийн ажил үүргийн тодорхой нэг түвшинд хамаарах ажилбаруудыг гүйцэтгэхэд шаардлагатай сургалтын үр дүнгийн тодорхойлолт).

***Эх сурвалж:*** Төв Европын МБС –ын толь бичиг, (Cedefop), 2014

**Qualification level**

A qualification shows employers, teachers and learners what one has learnt and what s/he can do as a result of that learning.
There is a large variety of qualifications available so they are grouped together into levels to show how they compare and what other qualifications they can lead to.

The agreed Mongolian Qualifications Framework consist **of 10 levels**.

***Comments***:
- Level of qualifications is often determined by what is expected in qualification system or by level descriptors of qualifications framework;
- It can also be determined by an occupational profile (for example, description of the learning outcomes required to perform the tsk attached to a job at a specific level of responsibility).

***Source***: https://www.nidirect.gov.uk/articles/qualifications-what-different-levels-mean
European education and training policy, Cedefop, 2014

**135 Мэргэшлийн түвшний тодорхойлогч**

МТҮТ-ны тодорхой түвшинг хангахад шаардлагатай сургалтын агуулга үр дүн, үнэлгээний шалгуур үзүүлэлтийг өргөн утгаар илэрхийлсэн тодорхойлолт буюу лавлагаа.

***Тайлбар***:
Тодорхойлолт буюу лавлагаар ажилтны мэдлэг, чадамж хариуцлага, үйл ажиллагааны нарийн түвэгтэй байдал, эрх мэдлийн цар хүрээ, бие даасан байдал болон стандарт бус хөдөлмөрийн хэв шинж зэргийг тодорхой үзүүлэлтүүдээр ялган ангилж харуулдаг.

Тодорхой мэргэшлийн түвшин (зэрэг) олгох, чадамжийг үнэлэх, сургалтын модулийг нарийвчлан боловсруулахад хэрэглэгдэнэ.

***Эх сурвалж:*** Мэргэжлийн боловсрол, сургалт, мэргэшлийн түвшний тогтолцооны нэр томьёоны тайлбар толь, (МСС), УБ, 2011
НҮБТМБСТ/SAQA, Өмнөд Африк 2013

**Qualification level descriptor**

A statement describing learning achievement at a particular level of the National Qualifications Framework (NQF) that provides a broad indication of the types of learning outcomes and assessment criteria that are appropriate to a qualification at that level.

***Note***:
The descriptor or reference depicts employee’s knowledge, competence, complexity of action, scope of authority, independence and features of non-standard labor in distinct expressions of concrete parameters.

It is used in developing training modules in detail, assessing competencies and awarding particular level (degree) of qualification.

***Source***: Glossary of Terms for Vocational Education, Training and National Qualifications System, (MCA), UB, 2011
UNEVOC/SAQA, South Africa, 2013

**136 Мэргэшлийн үндэсний хүрээ**

Хүлээн зөвшөөрөгдсөн түвшингүүдэд нийцүүлэн ур чадвар, мэдлэг, чадамжийг боловсруулах, ангилах, баталгаажуулах арга хэрэгсэл.

Энэ нь урьд нь эзэмшсэн болон сургалтын үр дүнд шинээр эзэмших мэргэшлүүдийг шатлан ангилж, бүтэцжүүлэх арга зам

бөгөөд өөрөөр хэлбэл анги танхим, ажлын байранд, эсвэл албан бус хэлбэрээр сурснаас үл хамааран суралцагч юу мэдэх ёстой, юу хийж чадах ёстойг тодорхой заасан мэдээллийг агуулна.

Мэргэшлийн түвшний хүрээ нь янз бүрийн мэргэшлүүдийг хооронд нь харьцуулах, нэг мэргэжил, үйлдвэрлэлийн салбар дотор болон мэргэжил, салбаруудын хооронд нэг түвшнээс нөгөө түвшинд хэрхэн шилжиж, дэвшиж болохыг тодорхойлно. (хэрэв тухайн МТХ-нд мэргэжлийн болон академик мэргэшлүүд аль аль нь багтсан бол мэргэжлийн болон академик мэргэшлүүдийн хооронд шилжих боломж байдаг).

***Эх сурвалж:*** ОУХБ (SED), 2007, Женев

**National Qualifications Framework (NQF)**

An instrument for the development, classification and recognition of skills, knowledge and competencies along a continuum of agreed levels.

It is a way of structuring existing and new qualifications, which are defined by learning outcomes, i.e. clear statements of what the learner must know or be able to do whether learned in a classroom, on-the-job, or less formally.

The Qualifications Framework indicates the comparability of different qualifications and how one can progress from one level to another, within and across occupations or industrial sectors (and even across vocational and academic fields if the NQF is designed to include both vocational and academic qualifications in a single framework).

***Source:*** ILO (SED), 2007, Geneva

**137 МБС-ын мэргэшлийн түвшний тогтолцоо**

Боловсролын тогтолцооны талаас нийлүүлж буй ажилтны мэргэшлийг хөдөлмөрийн зах зээлд нийцүүлэх мэргэшлийн ур чадварыг зохицуулагч эрх зүй болон бүтэц, зохион байгуулалтын цогц механизм бүхий үндэсний систем юм.

***Тайлбар***:
- Мэргэжлүүдийг үйл ажиллагааны чиглэл, мэргэшлийн түвшингээр нь бүлэглэн, ангилсан мэргэжил, мэргэшлүүдийн жагсаалт;Мэргэжлийн үйл ажиллагааны чиглэлээр боловсруулж гаргасан мэргэжлийн стандартууд;
- Мэргэжлийн стандартуудыг хүлээн зөвшөөрөх /бүртгэх/ механизмууд;
- Мэргэжлийн түвшинг тогтоох, хяналт үнэлгээг тухайн салбарын хөгжил, бүс нутаг, үндэсний түвшинтэй нийцүүлэх үүрэг бүхий байгууллага, бүтэц, арга зүй бүхий механизм;
- Мэргэшлийн түвшин ба хүрээний лавлах/жагсаалт;
- Мэргэшлийн чанарыг хангах тогтолцоо (сургалт, үнэлгээ, баталгаажуулалт, гэрчилгээжүүлэлт).

Мэргэшлийн тогтолцооны тодорхойлолтын суурь ойлголтууд:
- Элсэх
- Шилжих
- Дэвших г.м.

***Эх сурвалж:*** Мэргэжлийн боловсрол, сургалт, мэргэшлийн түвшний тогтолцооны нэр томьёоны тайлбар толь, (МСС), УБ, 2011

**National Vocational Qualifications System**

The national system of qualifications is a combination of legal and institutional mechanisms regulating skills of vocational workers on the labor market side and vocational qualification supplied the education and training system.

***Note***:
- a list of types of work (occupations) and qualifications, in which professions are grouped by professional fields activities and qualifications levels;
- professional standards developed in accordance with the professional activities;
- mechanisms for recognition (registration) of professional standards;
- Institutional, organizational and methodological mechanisms (institution in charge of qualifications levels, monitoring and evaluation of sector development and outlook in regional and national levels) to develop, implement and organize national and/or regional policies in the field of qualifications;
- A catalog of qualifications framework and level ;
- Qualification quality assurance system (training, evaluation, verification and certification of qualifications);

Fundamental concepts of qualification system description:
- access;
- transition;
- promotion.

***Source***: Glossary of Terms for Vocational Education, Training and National Qualifications System, (MCA), UB, 2011

**138 Мэргэшлийн ур чадвар, чадамжийн баталгаажуулалт**

Ур чадвар, чадамж эзэмшсэн болохыг албан ёсоор хүлээн зөвшөөрөх үйл явц

- Мэргэшил (гэрчилгээ, диплом, цол хэргэм) олгох,
- Эзэмшсэн ур чадвар, чадамжийг баталгаажуулах, кредит олгох эсвэл хасах, дүйцүүлэх

Нийгэмд хүлээн зөвшөөрөгдөх гэдэг нь эдийн засгийн болон нийгмийн оролцогч талууд ур чадвар, чадамжийн үнэ цэнийг хүлээн зөвшөөрөхийг хэлнэ.

***Эх сурвалж:*** МБС-ын тайлбар толь, МБСҮТ Австрали, 2013

**Recognition of skills and competencies**

*Formal recognition* is the process of granting official status to skills and competences:

- Through the award of qualifications (Certificates, diploma or titles)
- Through the grant of equivalence, credit units or waivers, validation of gained skills and/or competences.

*Social recognition* is the acknowledgement of the value of skills and/or competences by economic and social stakeholders.

***Source:*** Glossary of VET, NCVER, Australia, 2013

**139 Мэргэшил хоорондын харьцуулалт**

Үндэсний, бүс нутгийн, салбарын түүнчлэн олон улсын түвшинд албан ёсны мэргэшлийн (гэрчилгээ, дипломын) агуулга болон түвшинг хооронд нь дүйцүүлэх (эквивалент) боломж бүхий хэм хэмжээ.

***Тайлбар***:
Харьцуулалт бол түгээмэл үнэлгээний аргачлал юм. Тухайлбал мэргэжлийн эксперт үнэлэх шаардлагагүй түвшинд үндэсний үнэлгээний төв үнэлгээ хийдэг. Мэргэшлийн харьцуулалтыг дараах зорилгоор хийдэг. Үүнд:

- Олон улсын түвшинд иргэдийн эзэмшсэн мэргэшлийг харьцуулах.
- Мэргэшлийн нэгж (кредит нэгж)- ийг тасралтгүй цуглуулах замаар мэргэшил эзэмших боломжийг нэмэгдүүлэх Европын хөдөлмөрийн зах зээлийн хөгжлийн суурь болох албан болон албан бус сургалтын үр дүнд болон ажил, амьдралын туршлагаас олж авсан мэргэшлийг хүлээн зөвшөөрөх;

***Эх сурвалж:*** Төв Европын МБС –ын толь бичиг, (Cedefop), 2008
МБС мэргэшлийн түвшний тогтолцооны нэр томьёоны тайлбар толь, (МСС), УБ, 2011

**Comparability of qualifications**

The extent to which it is possible to establish equivalence between the level and content of formal qualifications (certificates or diplomas) at sectoral, regional, national or international levels.

***Note***:
Comparability is a more generic form of evaluation, i.e., at a level that does not require subject matter experts, typically performed by a national information centre Comparability of qualifications has following purposes:

- Provide with possibility to compare qualifications acquired by citizens of different countries;
- Expand the opportunity to acquire qualification by collecting units of qualification (credit hours) on constant basis; Recognize qualifications in progress of prior labour activities, formal and non-formal training outcomes that are grounds of European labour market efficiency.

***Source***: Terminology of European education and training policy, Cedefop, 2008 Glossary of Terms for Vocational Education, Training and National Qualifications System, (MCA), UB, 2011

# Н

**140 Насан туршийн боловсрол**

Хувь хүний, нийгмийн болон мэргэжлийн шаардлагаас үүдэн мэдлэг, ур чадвар, чадавх, мэргэшлээ дээшлүүлэхэд чиглэгдсэн насан туршийн сургалтын үйл ажиллагаа.

***Эх сурвалж:*** Төв Европын МБС –ын толь бичиг, (Cedefop), 2008

**Lifelong learning**

All learning activity undertaken throughout life, which results in improving knowledge, know-how, skills, competences and/or qualifications for personal, social and/or professional reasons.

***Source***: Terminology of European education and training policy, Cedefop, 2008

141 **Насан туршийн мэргэжлийн боловсрол, сургалт**

Анх эзэмшсэн боловсролоосоо хойш дахин суралцах эсвэл хөдөлмөрийн зах зээл дээр гарахад бэлтгэх боловсрол, сургалт.

Энэ нь иргэнд дараах ач холбогдолтой.
Үүнд:

- Мэдлэг, чадвараа дээшлүүлэх, шинэчлэх;
- Ажил, мэргэжлээрээ ахиж дэвшихийн тулд шинэ мэдлэг эзэмших буюу давтан суралцах;
- Хувь хүний болон мэргэжлийн өсөлт, хөгжлийг үргэлжлүүлэн дэмжих.

***Тайлбар***:
Тасралтгүй боловсрол, сургалт нь насан туршийн сургалтын хэсэг болох бөгөөд тухайлбал (ерөнхий, мэргэжлийн, тусгай мэргэжлийн, албан, албан бус г.м.) боловсролын аль ч хэлбэрийг хамарч болох бөгөөд иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд зайлшгүй чухал үүрэгтэй.

***Эх сурвалж:*** МБС-ын тайлбар толь, МБСҮТ Австрали, 2013

**Continuing vocational education and training**

Education or training after initial education or entry into working life aimed at helping individuals to:

- improve or update their knowledge and/or skills;
- acquire new skills for a career move or retraining; and,
- continue their personal and professional development.

Note:
Continuing education and training is part of lifelong learning and may encompass any kind of education (general, specialised or vocational, formal or non-formal, etc.). It is crucial for the employability of individuals.

***Source***: Terminology of European education and training policy- a selection of 100 key terms CEDEFOP, Luxembourg, 2008

142 **Насанд хүрэгчдийн бичиг үсэг тайлагдалтын түвшин**

Монгол улсын нийт насанд хүрсэн иргэд буюу 15 ба түүнээс дээш насны иргэдийн дотор уншиж бичих чадвартай насанд хүрсэн иргэдийн эзлэх хувь хэмжээ.
2015 оны байдлаар Монгол улсад нийт насанд хүрэгчдийн дунд бичиг үсэг тайлагдсан хүн амын хувь хэмжээ 98% байсан.

***Эх сурвалж:*** Монгол Улсын Статистикийн Эмхэтгэл, 2016

**Adult literacy rate**

The proportion (in percent) of adult population (15 years old and above in Mongolia) who can read and write to total adult population. The adult literacy rate in Mongolia is 98% (2015).

***Source***: Mongolian National Statistical Yearbook, 2016

**143 Нийтлэг, суурь ур чадвар**

Тодорхой нэг ажил, мэргэжил эсвэл байгууллагын онцлогт хамааралгүй боловч ерөнхий ажил хөдөлмөр, амьдрал ахуй, боловсролд ач холбогдол бүхий харилцах, төлөвлөх, тооцох, зохион байгуулах, компьютер дээр ажиллах, дүгнэн шинжлэх зэрэг чадварууд хамаарна.

***Эх сурвалж:*** МБС-ын тайлбар толь, МБСҮТ Австрали, 2013

**Generic skills**

A skill which is not specific to work in a particular occupation or industry, but is important for work, education and life generally, including communication skills, mathematical skills, organizational skills, computer literacy, interpersonal competence and analytical skills.

***Source:*** Glossary of VET, NCVER, Australia, 2013

**144 Ногоон ур чадвар**

Хүний үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлж буй сөрөг нөлөөллийг бууруулахад чиглэсэн нийгэмд амьдрах, түүнийг хөгжүүлэх, дэмжин тэтгэхэд шаардлагатай чадварууд.

***Тайлбар***:
- ногоон ерөнхий ур чадварууд нь нөөцийг үр ашигтай зарцуулах, эко-иргэншлийг хэрэгжүүлэх, энэ талаарх ойлголтыг дээшлүүлэхэд тус болно.
- ногоон тусгай ур чадварууд нь экосистем, биологийн төрөл зүйлийг хамгаалах, эрчим хүч, материал, усны хэрэглээг багасгах үйл ажиллагаа, стандартыг хэрэгжүүлэхэд шаардлагатай болно.
- Нарийн мэргэшсэн ногоон ур чадварууд нь сэргээгдэх эрчим хүчийг ашиглах, бохир усыг цэвэршүүлэх, хог хаягдлыг дахин боловсруулах зэрэг ногоон технологиудыг хөгжүүлж, хэрэгжүүлэхэд шаардлагатай.

***Эх сурвалж:*** Төв Европын МБС –ын толь бичиг, (Cedefop), 2014

**Green skills**

Abilities needed to live in, develop and support a society which aims to reduce the negative impact of human activity on the environment.

***Comments***:
- generic green skills help develop awareness-raising or implementation of resource-efficient activities, ecocitizenship, etc.;
- specific green skills are required to implement standards and processes to protect ecosystems and biodiversity, and to reduce energy, materials and water consumption;
- Highly-specialised green skills are required to develop and implement green technologies such as renewable energies, sewage treatment or recycling.

***Source***: Terminology of European Education and Training Policy, Cedefop, 2014

**145 Нотолгоо**

Тоо баримт зэрэг аливаа баримт, мэдээллийн баталгаа.

МБС-ын чадамжийн үнэлгээ, баталгаажуулалтын хүрээнд

нотолгоо гэдэг нь чадамжийн нэгжид заасан чадамж эзэмшсэн болохыг баталж, цуглуулсан мэдээллийг хэлнэ.

Нотолгооны хамгийн түгээмэл гурван төрөл нь:
(1) ажиглалт,
(2) ажлын бүтээл,
(3) асуултад хариулсан байдал.

***Эх сурвалж:*** НҮБТМБСТ/ТМБС-ын толь бичиг; ТМБС-ын тайлбар толь, ТБУЧХА, Филиппин, 2010

**Evidence**

It is a proof of any fact or information including data.

In VET, evidence in the context of competence assessment and verification, is the information gathered and matched against a unit of competency to provide proof of competency.

The three most common types of evidence are:
- observation,
- work products
- replies to questions.

***Source:*** UNEVOC/TVETipedia Glossary; The TVET Glossary of Terms, TESDA, Philippines, 2010

146 **Ноу-хау**

Технологийн болон удирдлагын бүрэлдэхүүн бүхий практик мэдлэг, туршлага.

***Эх сурвалж:*** МБС-ын тайлбар толь, МБСҮТ Австрали, 2009

**Know-how**

*Know-how* means practical knowledge or expertise which includes technological and managerial components.

***Source:*** Glossary of VET, NCVER, Australia, 2009

147 **Нэгж**

Нэгж гэдэг нь мэргэжлийн сургалтын тодорхой бүрэлдэхүүн хэсэг бөгөөд сургалтын үр дүнгийн (мэдлэг, чадвар/чадамж) цогц юм.

Нэгж нь хэд хэдэн мэргэжил, эсвэл тодорхой нэг мэргэжилд хамааралтай байж болно.

***Эх сурвалж:*** Европын боловсрол, сургалтын бодлогын баримт бичиг, Cedefop, (Модульчилсан), 2015

**Unit**

A Unit can be set of learning outcomes (knowledge, skills and/or competences) which constitute a coherent part of a qualification.

A unit can be specific to a single qualification or common to several qualifications.

***Source:*** Terminology of European Education and Training Policy, Cedefop, (Modularisation), 2015

# O

148 **Одоогийн чадамж**

Аж үйлдвэрийн салбар эсвэл ажил, мэргэжилд хүчин төгөлдөр, хэрэгцээтэй байгаа чадамж.

***Тайлбар:***
Цаг хугацаа өнгөрөхийн хирээр хүмүүс чадамжаа алдах боломжтой ба иймд чадамжаа хүчин төгөлдөр байлгахын тулд давтан сургалт-дадлагажих сургалтад хамрагдах шаардлага үүсдэг.

***Эх сурвалж:*** МБС-ын тайлбар толь, МБСҮТ Австрали, 2013

**Current competencies**

A competency which continues to have currency in an industry or occupation.

***Note:***
People can lose competence over time and may need further training and practice to demonstrate current competency.

***Source:*** Glossary of VET, NCVER, Australia, 2013

**149 Олон талт ур чадвар**

Ажилтанд янз бүрийн ажил, үүргүүдийг гүйцэтгэхэд шаардлагатай ур чадваруудыг эзэмшүүлэхэд чиглэсэн сургалт.

Өөрийн ур чадварыг өргөжүүлэх, сайжруулах, эсвэл нэмэлт ур чадвар бүрдүүлэх зэрэг нь олон талт ур чадварын төрлүүд юм.

***Эх сурвалж:*** МБС-ын тайлбар толь, МБСҮТ Австрали, 2013

**Multi skilling**

Training of workers in a number of skills which enables them to perform a variety of tasks or functions across traditional boundaries. Multi skilling may be horizontal (broad skilling), vertical (upskilling) or diagonal (contributory skilling).

***Source:*** Glossary of VET, NCVER, Australia, 2013

**150 Олон улсын ажил мэргэжлийн стандарт ангилал (ISCO)**

ОУХБ-аас эрхлэн гаргадаг олон улсын ажил мэргэжлийн стандарт ангилал.

Энэ ангилал нь ажлын хүрээнд хийж гүйцэтгэх ажилбар, үүргийнх нь дагуу тухайн ажлыг тодорхой тогтоосон ажлын бүлгүүдэд ангилан, хамааруулах арга хэрэгсэл юм. Ангиллын үндсэн зорилго нь:

- Ажил, мэргэжлийн талаарх статистик болон захиргааны тоо баримтуудыг олон улсын төвшинд мэдээлэх, харьцуулах, харилцан солилцох үндэс суурийг бүрдүүлэх;
- Улс үндэсний болон бүс нутгийн ажил мэргэжлийн ангилал бий болгох загвар боловсруулах;
- Ажил, мэргэжлийн ангилал боловсруулаагүй байгаа улс орнуудад шууд авч хэрэглэх тогтолцоог бий болгох.

***Эх сурвалж:*** http://www.ilo.org/public/english/bureau/stat/isco

**International standards classification of Occupations (ISCO)**

One of the main international classifications for which ILO is responsible.

ISCO is a tool for organizing jobs into a clearly defined set of groups according to the tasks and duties undertaken in the job. Its main aims are to provide:

- a basis for the international reporting, comparison and exchange of statistical and administrative data about occupations;
- a model for the development of national and regional classifications of occupations;
- a system that can be used directly in countries that have not developed their own national classifications.

***Source:*** http://www.ilo.org/public/english/bureau/stat/isco/

151 **Орлого бий болгох төслүүд**

Суралцагчдын бизнес аж ахуй эрхлэх чадавхыг дээшлүүлэх болон сургалтын байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн орлого олох зорилгоор сургалтын байгууллагын хөрөнгийг түшиглэн багш зааварлагчийн удирдлаган дор сурагчдын янз бүрийн цар хүрээгээр эрхлэн явуулдаг бизнес, аж ахуй эрхлэх үйл ажиллагаа

***Эх сурвалж:*** ТМБС-ын тайлбар толь, ТБУЧХА, Филиппин, 2010

**Income generating projects**

Entrepreneurial business activities of whatever scale that takes place in or by the learning institutions managed by the students and supervised by technical instructors with revolving capital provided by the institution established for the purpose of providing the students the opportunity of learning business acumen and to generate income for the improvement of the institutions.

***Source:*** The TVET Glossary of Terms, TESDA, Philippines, 2010

152 **Орлого бүрдүүлэх**

Ажил үйлчилгээ, бараа бүтээгдэхүүн нийлүүлэх, хагас болон бүтэн цагаар эсвэл албан бусаар байгууллагын байр, өрөө танхмийг түрээслэх, эсвэл байгууллагын ажилтан олон нийтэд чиглэсэн үйл ажиллагаа явуулах замаар байгууллагад орлого оруулах үйл явц.

***Эх сурвалж:*** ТМБС-ын тайлбар толь, ТБУЧХА, Филиппин, 2010

**Revenue generation**

Generation of income for an institution from the delivery of products and services, rentals, part-time or full-time and/or non-formal delivery of training on institutional premises or by institutional personnel outreaching into community.

***Source:*** The TVET Glossary of Terms, TESDA, Philippines, 2010

153 **Оролцогч тал**

Тодорхой үйл ажиллагаанд хамааралтай оролцох сонирхолтой хувь хүн эсвэл байгууллага.
Мэргэжлийн боловсрол, сургалтын оролцогч талуудад Засгийн газар, сургалтын байгууллага, ажил олгогч/ үйлдвэр, мэргэжлийн холбоод, суралцагч, тэдний эцэг эхчүүд хамаарна.

***Эх сурвалж:*** ТМБС-ын тайлбар толь, ТБУЧХА, Филиппин, 2010

**Stakeholder(s)**

A person or organization with an interest or concern in something. In vocational education and training stakeholders include learners and their parents, government, training providers, employers/industry and professional associations.

***Source:*** The TVET Glossary of Terms, TESDA, Philippines, 2010

# Ө

**154 Өмнөх мэдлэг, ур чадварыг хүлээн зөвшөөрөх**

Хувь хүний өмнөх эзэмшсэн мэдлэг, чадвар дадал, ажил амьдралын туршлагыг тодорхой хичээл буюу модуль багц цагт тооцох буюу хүрсэн түвшинг тогтоож, үнэлж, батламжлах.

Хувь хүний албан бусаар эсвэл хувиараа сурч эзэмшсэн чадамж нь чадамжийн ямар төвшинд байгааг тодорхойлох үнэлгээний үйл явц. Үүнийг өмнө эзэмшсэн мэдлэг, чадварыг магадлан итгэмжлэх, албан бус/бие даан сурсан мэдлэг, чадварыг баталгаажуулах гэж нэрлэж болно.

-Мэргэшил олгох (диплом, гэрчилгээ, үнэмлэх г.м), эсвэл

-Дүйцүүлэх, багц цагийг тооцож чөлөөлөх, эзэмшсэн чадамж, ур чадварыг нь баталгаажуулах замаар шаардлагатай чадамж, чадварыг хувь хүн эзэмшсэн эсэхийг албан ёсоор хүлээн зөвшөөрөх явц.

***Эх сурвалж:*** МБС мэргэшлийн түвшний тогтолцооны нэр томьёоны тайлбар толь, (МСС), УБ, 2011 МБС-ын тайлбар толь, МБСҮТ Австрали, 2013

**Recognition of prior learning**

An assessment process that assesses the individual’s non-formal and informal learning to determine the extent to which that individual has achieved the required learning or competency outcomes.

May also be referred to as: Accreditation of prior learning; Validation of informal/non formal learning.
It is the formal process of granting official status to skills and competences either through:

- award of qualifications (certificates, diploma or titles); or
- grant of equivalence, credit units or waivers, validation of gained skills and/or competences.

***Source***: Glossary of Terms for Vocational Education, Training and National Qualifications System, (MCA), UB, 2011 Glossary of VET, NCVER, Australia, 2013

**155 Өмнөх сургалтын багц цаг**

Дагалдан сурагч буюу дадлагажигч өмнө нь суралцаж байсан сургалт болон эрхэлж байсан ажил, мэргэжилтэй холбоотойгоор хуримтлуулсан мэдлэг, туршлагаа үнэлүүлэн “кредит” цуглуулах боломжтой. Ийм тохиолдолд сурсан мэдлэг, ур чадвар, дадал, туршлагыг албан ёсоор хүлээн зөвшөөрсний үндсэн дээр дараагийн шатны сургалтын хугацааг тодорхойлох боломжтой.

***Эх сурвалж:*** МБС мэргэшлийн түвшний тогтолцооны нэр томьёоны тайлбар толь, (МСС), УБ, 2011

**Credit of prior learning**

Apprentice and learner conducting practical training may collect credit hours depending on accumulated experience and training related to prior occupation. In this case, this competence and experience should be officially recognized hence on this basis the term of training agreement can be modified.

***Source:*** Glossary of Terms for Vocational Education, Training and National Qualifications System, (MCA), UB, 2011

156 **Өөрийн үнэлгээ**

Өөрийн үнэлгээ 2 зорилготой байж болно:

1. Чадамжийн үнэлгээний хувьд: суралцагч, оюутнууд нотолгоо цуглуулах замаар өөрсдийн гүйцэтгэлээ тодорхой чадамжийн стандарт болон шалгуур үзүүлэлтийн дагуу шүүн үнэлдэг үйл явц.
2. Магадлан итгэмжлэлд орох чанарын баталгаажилтын хувьд: Аж ахуйн нэгж эсвэл сургалтын байгууллагууд боловсрол, сургалтын тогтолцооны чанарын баталгаажилтад тавигддаг шалгуур үзүүлэлтийг ямар түвшинд хангаж байгаагаа үнэлэх, сайжруулах боломжоо нээн илрүүлэх үйл явц.

***Эх сурвалж:*** Wahba, 2013, НҮБТМБСТ/ТМБС-ын толь бичиг

**Self assessment**

Self assessment can be in two contexts.

1. In the context of competency assessment it means: A process in which learners/ trainees / students collects evidences about themselves, judge and assess their own performance against particular competency standards and criteria
2. In the context of Quality Assurance leading to accreditation, it means: A process in which an enterprise or training provider assesses the extent to which it satisfies the criteria for quality endorsement of the training provider's learning, education and training system and identifies opportunities for improvement.

***Source***: UNEVOC/TVETipedia Glossary

# П

157 **Политехник**

Техникийн салбарт мэргэжлийн эсвэл дээд боловсрол олгодог дээд боловсролын байгууллага.

Техникийн боловсролын сургалтын байгууллагын хэв шинж нь политехник коллеж байна.

***Эх сурвалж:*** https://en.wikipedia.org/wiki/Polytechnic
МБС-ын тухай МУ-ын хууль, 2009

**Polytechnic**

Polytechnic is a higher education institution offering vocational or higher education courses in technical areas.

'Polytechnic college' is a type of education and training institution offering training in technical area.

***Source***: https://en.wikipedia.org/wiki/Polytechnic
Law of Mongolia on Vocational Education and Training, 2009

# С

158 **Суралцагч төвтэй хандлага**

Суралцагчийн зан төлөв, хэрэгцээ, сонирхолд нийцүүлэн сургалт, үнэлгээг зохион байгуулах арга хандлага.

***Эх сурвалж:*** IBE (2013), Сургалтын хөтөлбөрийн тайлбар толь, IBE-ЮНЕСКО

**Learner Centeredness**

An approach to organizing teaching, learning and assessment based on the learner's personal characteristics, needs and interests.

***Source***: IBE (2013), Glossary of Curriculum Terminology, IBE-UNESCO

**159 Сургалтын үйл ажиллагаа**

Сургалтын үйл ажиллагаа гэдэг нь хувь хүн мэдээлэл, шинэ санаа, үнэ цэнийг харьцуулж, ойлгох замаар мэдлэг, ноу-хау, ур чадвар, чадамж олж авах үйл явц.

***Эх сурвалж:*** Cedefop, 2004
Европын Холбооны Хороо, 2006

**Learning activity**

A process by which an individual assimilates information, ideas and values and thus acquires knowledge, know-how, skills and/or competences.

***Source***: Cedefop, 2004
European Commission, 2006

**160 Сургалтын багц**

Сургалтын багц гэдэг нь сурагчид багшийн туслалцаа тэр бүр авахгүйгээр суралцахад зориулан гаргасан материал/хэрэглэгдэхүүн.

***Эх сурвалж:*** IIEP тайлбар толь, IIEP Сургалтын портал, ЮНЕСКО

**Learning package**

Learning materials designed so that learners can learn from them without much help from a teacher.

***Source***: IIEP Glossary, IIEP Learning Portal, UNESCO

**161 Сургалт явуулах хэлбэр**

Энэ нь сургалт явуулах газарт хамаарах бөгөөд сургууль түшиглэсэн, сургалтын төв түшиглэсэн, үйлдвэр аж ахуйн газар түшиглэсэн, орон нутагт түшиглэсэн хэлбэрүүд байх ба хичээлийн жилээр явагдах уламжлалт цаг хугацааны хувьд уян хатан чадамжид суурилсан хэлбэр бүхий тогтолцоо, аргазүйг илэрхийлдэг.

Сургалт явуулах горимд зайны сургалт, онлайн (вэб-д суурилсан) сургалт орж болно.

***Эх сурвалж:*** ТМБС-ын тайлбар толь, ТБУЧХА, Филиппин, 2010

**Mode of delivery**

Refers to the venue of training such as: school-based, center-based, enterprise-based, and community-based or the system or the methodology itself such as the traditional or structured type conducted by semester and the competency-based which is self-paced and not time bound.

Mode of delivery may also inlcude distance learning and online learning (web based).

***Source***: The TVET Glossary of Terms, TESDA, Philippines, 2010

**162 Стандарт**

Аливаа зүйлийг хооронд нь харьцуулахад хэрэглэдэг үлгэр, загвар, жишиг гэсэн утгатай англи гаралтай үг бөгөөд бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний чанар, түвшний нэгдмэл байдлыг хангах зорилгоор тогтоож, албан ёсоор зөвшөөрөгдсөн хэм хэмжээ.

***Тайлбар***:
Стандарт (бүлэг стандарт) нь ямар нэг зүйлийн чанар, түвшинд үнэлэлт өгөх эсвэл дүн шинжилгээ хийхэд чиглэнэ. Хүлээгдэж буй ур чадвар, гүйцэтгэлийг илэрхийлсэн тодорхойлолт.

***Эх сурвалж:*** Мэргэжлийн боловсрол, сургалт, мэргэшлийн түвшний тогтолцооны нэр томьёоны тайлбар толь, (МСС), УБ, 2011

**Standard**

A concept meaning example, norm and reference to compare things and it's an officially recognized and established norm to ensure integrity and quality of services and goods.

***Note***:
Standard (group of standards) aims to analyze and evaluate the rank and quality of things. Definition that expresses the expected performance and skills.

***Source***: Glossary of Terms for Vocational Education, Training and National Qualifications System, UB, 2011

**163 Стандарт / боловсролын/**

Суралцагчдын зайлшгүй эзэмшсэн байвал зохих боловсролын агуулгын түвшин, түүний үнэлгээ, багшийн мэргэшлийн түвшин, сургалтын орчинд тавигдах үндсэн шаардлагыг тодорхойлно.

***Эх сурвалж:*** МУ-ын Боловсролын тухай хууль, 2007

**Education standard**

It defines the main criteria in the training environment, teachers' qualifications level, level of educational content that needs to be acquired by learners and its assessment.

***Source:*** Law of Mongolia on Education, 2007

**164 Стандарт / мэргэжлийн/**

Эдийн засгийн тодорхой салбарын ажилтнуудын эзэмшсэн байх чадамж, гүйцэтгэх ажил, үүргийн талаарх мэргэжлийн холбоод болон ажил олгогчдын зүгээс тавьдаг мэргэжлийн шаардлагыг тодорхойлсон баримт бичиг.

Ажилтны гүйцэтгэх шаардлагатай ажлын түвшин ба амжилттай гүйцэтгэхэд шаардлагатай мэдлэг, ур чадварын стандарт.

***Эх сурвалж:*** Мэргэжлийн боловсрол, сургалт, мэргэшлийн түвшний тогтолцооны нэр томьёоны тайлбар толь, (МСС), УБ, 2011

**Occupational standards**

Standards of performance that people are expected to achieve in their work, and the knowledge and skills they need to perform effectively.

It is a document defined requirements of vocational associations and employers for content of vocational activities and qualifications of employees within concrete economic fields.

***Source***: Glossary of Terms for Vocational Education, Training and National Qualifications System, (MCA), UB, 2011

**165 Стандарт /Мэргэжлийн боловсрол сургалтын/**

Мэргэжлийн мэдлэг, ур чадвар эзэмшүүлэх, төлөвшүүлэх сургалтын агуулга, түүний үнэлгээ, багшийн мэргэшил, сургалтын орчинд тавих үндсэн шаардлага.

Мэргэжлийн стандарт шаардлагад үндэслэн боловсрол, сургалтын стандартыг гаргах бөгөөд тэрээр уг мэргэжлийг эзэмшихэд шаардлагатай зайлшгүй нөхцөл, хөтөлбөрийн бүтэц, чанар, төгсөгчийн чадварыг тусгасан хэм хэмжээ юм.
Энэ стандарт нь мэргэжлийн тодорхой чиглэлээр ажиллах бүх хүний нийтлэг чадварын зохистой доод төвшин байна. Иймд аливаа мэргэжлийн сургалтын хөтөлбөрийн үндэс нь энэхүү стандартыг хангахад чиглэсэн мэдлэг, чадварын төвшин байдаг.

Үндэсний мэргэшлийн хүрээнд нийцтэй сургалтын хөтөлбөрүүдийг боловсруулах МБС-ын байгууллагуудад тавигдах шаардлага болон хэрэгцээт мэдээллийг олгох сургалтын салбарын асуудлыг хариуцсан төрийн байгууллагад хамаарна. Үүнд сургалтын хөтөлбөрийн бүтэц, сургалтын үр дүн, суралцагчид тавигдах элсэлтийн шаардлага, сургалтын багаж тоног төхөөрөмж, сургагч багшийн мэргэшлийн талаар мэдээлэл орно.

***Эх сурвалж:*** Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай МУ-ын хууль, 2009; Монгол улсын МБС-ын стандарт MNS 6541:2015

**Vocational Education and Training Standard**

Main criteria on learning environment, trainer qualification, training content, and its assessment, and providing with vocational skills and knowledge.

Education and training standards are developed based on professional standards, and reflect the quality and skills of graduates, curricula structure and compulsory terms to be fulfilled to acquire the occupation.

This standard is minimum level of common skills that all people working in this occupational profile have to acquire. Hence the grounds of all trade curricula are level of skills and knowledge aiming to fulfill these standards.

This refers to the sections of the Training Regulations that gives information and important requirements for TVET providers to consider when designing training programs corresponding to a national qualification (see definition of qualification); this includes information on curriculum design, training delivery, trainee entry requirements, training tools and equipment, and trainer qualifications. (Training Regulations Framework).

***Source***: Law of Mongolia onVocational Education and Training, 2009; Mongolian VET Standard MNS 6541:2015

**166 Стандарт / мэргэшлийн/**

Тодорхой мэргэшлийн шаардлагыг хангахын тулд ажилтны эзэмшсэн байх ур чадвар, чадамжийн хэм хэмжээг тодорхойлно.

Мэргэжлийн стандарт нь гүйцэтгэх ажлын бүтцийг хамардаг бол мэргэшлийн стандарт нь тодорхой ажил, үүргийг гүйцэтгэх ур чадвар, чадамжийн түвшнийг илэрхийлнэ. Мэргэшлийн

стандарт нь түвшин бүрээр боловсруулагдах ба тухайн түвшний ажилтны эзэмшвэл зохих мэдлэг, чадвар, хандлага, хариуцлагын шаардлагыг тусгана.

***Эх сурвалж:*** Мэргэжлийн боловсрол, сургалт, мэргэшлийн түвшний тогтолцооны нэр томьёоны тайлбар толь, (МСС), УБ, 2011

**Qualifications standard** A concept expressing norms to which the employee's skill is expected to meet the requirements of the particular qualification.

Vocational standards are related to performance structure while qualification standards express deepness of skillful performance of particular task. Qualification standards are developed in each level and the levels clearly reflect requirements for knowledge, skills, attitudes and responsibilities that employees need to have.

***Source***: Glossary of Terms for Vocational Education, Training and National Qualifications System, (MCA), UB, 2011

167 **Стандарт /чадамжийн/** Ажил хөдөлмөрийг үр дүнтэй эрхлэхэд шаардагдах мэдлэг, ур чадвар, хандлагыг илэрхийлэх үйлдвэр, аж ахуйн нэгжээс тогтоосон гүйцэтгэлийн тодорхойлолт.

Мэргэжлийн боловсрол, сургалтын чадамжийн стандарт нь чадамжийн нэгжүүдээс бүрдэх ба нэгжүүд нь чадамжийн элемент, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтүүд, нотолгоо цуглуулах зааварчилга зэргээс бүрдэнэ.

Чадамжийн стандарт нь сургалтын багцын баталгаажсан бүрэлдэхүүн хэсэг юм.

***Эх сурвалж***: МБС-ын тайлбар толь, МБСҮТ Австрали, 2013

**Competency standard** An industry-determined specification of performance, which sets out the skills, knowledge and attitudes required to operate effectively in employment.

In vocational education and training, competency standards are made up of units of competency, which are themselves made up of elements of competency, together with performance criteria, a range of variables, and an evidence guide.

Competency standards are an endorsed component of a training package.

***Source:*** Glossary of VET, NCVER, Australia, 2013

168 **Стандартын хамрах хүрээ** Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтүүдэд хамаарах нөхцөл байдал, цар хүрээг тодорхойлдог чадамжийн нэгжийн бүрэлдэхүүн хэсэг.

***Эх сурвалж:*** МБС-ын тайлбар толь, МБСҮТ Австрали, 2013

**Range statement** The part of a unit of competency which specifies the range of contexts and conditions to which the performance criteria apply.

***Source:*** Glossary of VET, NCVER, Australia, 2013

**169 Судалгааны арга**

Ажил хэргийн шийдвэр гаргах зорилгоор мэдээлэл, too баримт цуглуулахад ашигладаг арга.
Үүнд судалгаа, шинжилгээ, баримт бичгийн судалгаа, ярилцлага, мөн бусад аргууд хамаарах бөгөөд одоогийн болон өнгөрсөн үеийн мэдээллийг хамран судалдаг .

***Эх сурвалж:***http://www.businessdictionary.com/definition/researchmethodology.html

**Research methods**

The process used to collect information and data for the purpose of making business or policy decisions.

The methodology may include publication research, interviews, surveys and other research techniques, and could include both present and historical information.

***Source***: http://www.businessdictionary.com/definition/researchmethodology.html

**170 Суралцагч**

Суралцаж буй хэн бүхэн, тухайлбал дунд сургуулийн сурагч, коллеж, их, дээд сургуулийн оюутан, дагалдан суралцагч, дадлагажигч, аливаа сургалтад хамрагдаж буй болон, албан бус, хувиараа суралцаж буй хүмүүс, тодорхой нэг мэргэшил эсвэл мэргэшлийн зарим нэг хэсгийг эзэмшихээр элсэн орсон хүмүүсийг багтаасан ухагдахуун юм.

***Эх сурвалж:*** НҮБТМБСТ/SAQA, Өмнөд Африк, 2013

**Learner**

An inclusive term referring to anyone learning, including pupils at school, students at colleges, traditional universities and universities of technology; apprentices, interns such as people undergoing training, and people learning non-formally and informally as well as people enrolled for particular qualifications or part qualifications.

***Source:*** UNEVOC/SAQA, South Africa, 2013

**171 Сургагч**

Боловсрол, сургалтын байгууллагад эсвэл ажлын байранд онол, дадлагын сургалттай холбогдсон нэг буюу хэд хэдэн үйл ажиллагаа явуулдаг хүн.

***Тайлбар***:
Сургагч багш нь хоёр янз байж болно. Үүнд:
- Багшлах эрхийн сургалтад хамрагдаж мэргэжлийн сургалтад багшлах эрх авсан сургалтын мэргэжилтнийг сургагч багш гэнэ;
- Аж үйлдвэрийн салбарт мэргэжлийн ажлаа хийхийн зэрэгцээ компани дээр удирдан чиглүүлэгч, зөвлөгч, эсвэл сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэхэд оролцдог хүнийг сургагч багш гэнэ.

Тэд дараах үүрэгтэй байна. Үүнд:
- Сургалтын үйл ажиллагаа зохион байгуулах;
- Сургалт зохион байгуулж хэрэгжүүлэх;
- Сургалтын туршид суралцагчдад зөвлөгөө, зааварчилга, тайлбар мэдээллээр хангах.

***Эх сурвалж:*** Төв Европын МБС –ын толь бичиг, (Cedefop), 2008

**Trainer**

Anyone who fulfills one or more activities linked to the (theoretical or practical) training function, either in an institution for education or training, or at the workplace.

***Note***:
- There two types of trainers: A training expert who was awarded with teaching license for vocational training after being covered in pedagogy training;
- Trainers those working as a tutor, advisor or those participate in training programs in a company while perform their vocational works in various fields of industry.

Trainers have following duties:
- organize training activities;
- organize, implement training;
- provide the learners with advises, instructions and explanations during whole period of the training.

***Source***: Terminology of European Education and Training Policy, Cedefop, 2008

172 **Сургалтын стратеги**

Ажлын байр болон сургалтын байгууллагууд дээр сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотой мэдээллээр хангах зорилго бүхий баримт бичиг.
Сургалтад хамрагдах арга зам, загвар сургалтын хөтөлбөр, материалууд багтсан байж болно.

***Эх сурвалж:*** МБС-ын тайлбар толь, МБСҮТ Австрали, 2013

**Learning strategy**

A non-endorsed component of a training package which provides information on how training programmes may be organised in workplaces and training institutions. This may include information on learning pathways, model training programmes, and training materials.

***Source:*** Glossary of VET, NCVER, Australia, 2013

173 **Сургалтын үр дүн**

Албан ба албан бус сургалтыг дүүргэсний дараа эзэмшсэн байвал зохих мэдлэг, чадвар, чадамжтай холбоотойгоор тухайн хүн юу мэдэж, ойлгож, хийж чаддаг болсныг тодорхойлно.

Сургалтын үр дүн бол сургалтад хамрагдсаны дараа суралцагчийн эзэмшсэн чадамж, чадвар, мэдлэгийн тодорхойлолт юм.

***Тайлбар***:
- Сургалтын /суралцахын/ үр дүн бол мэргэжлийн боловсрол, сургалтын тогтолцооны ил тод байдлыг хангах үндсэн хэрэгслийн нэг;
- Сургалтын модуль болон боловсролын хөтөлбөрийг бүхлээр нь эсвэл хэсэгчлэн дүүргэсний дараа хувь хүний эзэмшсэн, ололт амжилт, мэдлэг, практик чадвар;
- Сургалтын үр дүн нь мэргэшлийн гэрчилгээ/диплом/ олгох нөхцөлийг хангах наад захын шаардлагыг тусгасан, үнэлгээний шалгууруудыг агуулна;
- Сургалтын үр дүнг зорилго, зорилтоос ялгаж үздэг. Сургалтын үр дүн нь багшийн зорилт гэхээс илүү суралцагчдын ололт

амжилттай холбоотой;
- Үр дүнд чиглэсэн хандлага нь мэргэшлийг тодорхойлох, сургалтын төлөвлөгөө боловсруулах, сургалтын явц, үнэлгээний үйл явцыг зохион байгуулах, нийт боловсролын чанарыг хангахад оршино;
- Мэргэшлийн ерөнхий тодорхойлолт, өөрөөр хэлбэл сургалтын үр дүнг мэргэшлийн түвшний тодорхойлогчоор илэрхийлдэг;
- Хууль тогтоомж болон мэргэжлийн байгууллагуудын тогтоосон шалгуур, дүрэм журмын дагуу явуулсан сургалтын үнэлгээгээр сургалтын үр дүнг тогтоож, баталгаажуулснаар албан ёсоор хүлээн зөвшөөрөгддөг.

***Эх сурвалж:*** Төв Европын МБС –ын толь бичиг, (Cedefop), 2008

**Learning outcomes**

Learning outcomes are statements of what a learner knows, understands and is able to do on completion of a learning process, which are defined in terms of knowledge, skills and competence.

The learning process may be formal, non-formal or informal.

***Note***:
- Training (learning) outcome is one of basic means to express transparency of VET system
- This is an achievement, knowledge and practical ability that each learner obtained after full and/or part completion of training modules and/or educational program
- Learning outcome should contain minimum assessment criteria necessarily required to grant qualification (certificate or diploma);
- Learning outcome is different from training goal and objectives. Learning outcome is connected to learner's achievement rather than teacher's goal
- Total outcome oriented approach is to identify qualification, to develop training plans, to facilitate training processes and evaluation systems and to provide education quality in whole
- General description of qualification, in other words, the training outcome is developed by "qualification descriptor" or "qualification level description"
- Learning outcome is officially acknowledged after it is determined and verified in accordance with training assessment conducted under procedures and criteria approved by legislation and regulatory authorities.

***Source:*** Terminology of European Education and Training Policy, Cedefop, 2008

**174 Сургалтын/ дамжаа/ агуулга**

Ихэнхдээ хэд хэдэн модуль (хичээл) эсвэл богино хөтөлбөрүүдээс бүрддэг зохион байгуулалттай, нэгдмэл боловсрол, сургалтын хөтөлбөр бөгөөд амжилттай дүүргэснээр мэргэшил олгоно.

***Тайлбар***:
Сургалтын агуулгын бүтэц:
- Сургалтын зорилго
- Үнэлгээ
- Заах арга зүй

***Эх сурвалж:*** НҮБТМБСТ/ТМБС-ын толь бичиг

**Course content**

A structured and integrated programme of education or training, usually consisting of a number of modules (subjects) or shorter programmes, and leading to the award of a qualification.

*Note*:
The primary components of a course are:
- Learning objectives
- Assessment
- Instructional methodologies.

***Source:*** UNEVOC/TVETipedia Glossary

175 **Сургалтын багц**

Аж үйлдвэрийн салбарын эрэлт хэрэгцээг хангах зорилгоор аж үйлдвэрийн төлөөлөл боловсруулж, үндэсний хэмжээнд баталгаажсан, суралцагчийн эзэмшвэл зохих чадварыг хүлээн зөвшөөрөх сургалтын удирдамж, стандарт, үнэлгээг хамарсан баримт бичиг.

***Эх сурвалж:*** НҮБТМБСТ/ТМБС-ын толь бичиг

**Training package**

Training guideline, standard and assessment to recognize the skills that should be acquired by learners and is recognized in the national level, developed by industry to meet the needs of the industry sector.

***Source:*** UNEVOC/TVETipedia Glossary

176 **Сургалтын хөтөлбөр**

Тодорхой нэг чиглэлээр суралцан төгсөж, гэрчилгээ авах системтэй, дэс дараалал бүхий бүлэг хичээл.

Ажил, мэргэжлийн салбарт хөл тавихад шаардлагатай мэргэшил эзэмшүүлж, төгсөлтийн гэрчилгээ олгох замаар сургуулийн зүгээс суралцагчид санал болгох тодорхой зааварчилгааны материал болон сургалтын агуулгын ерөнхий төлөвлөгөө.

*Сургалтын хөтөлбөр* гэдэг нь сургалтын агуулга, хэлбэр, бэлтгэл, төлөвлөлт, зохион байгуулалтыг хамрах ба харин сургалт нь эдгээр үйл ажиллагааны хэрэгжилтийг тодорхойлно.

***Эх сурвалж:*** ТМБС-ын тайлбар толь, ТБУЧХА, Филиппин, 2010; Төв Европын МБС –ын толь бичиг, (Cedefop), 2015

**Curriculum**

Systematic group of courses or sequences of subjects required for a graduation or certification in a major field of study.
It is a general overall plan of the content or specific materials of instruction that the school should offer the student by way of qualifying him for graduation or certification of entrance into a professional or vocational field.

***Note:***
That the term ***curriculum*** refers to the design, organisation and planning of learning activities, while the term *programme* refers to the implementation of these activities.

***Source***: The TVET Glossary of Terms, TESDA, Philippines, 2010; Terminology of European Education and Training Policy, Cedefop, (Modularisation), 2015

**177 Сургалтын байгууллагын үнэлгээ**

Тодорхой чадамжийн нэгж болон бүлэг чадамжийн нэгжийн хүрээнд суралцагчдын сурлагын үр дүн, амжилтыг тодорхойлох зорилгоор сургалтын байгууллагаас зохион байгуулах үнэлгээ.

***Эх сурвалж:*** ТМБС-ын тайлбар толь, ТБУЧХА, Филиппин, 2010

**Institutional assessment**

An assessment undertaken by the (training) institution for its students to determine their achievement of the learning outcomes in the module of instructions in given unit of competency or clusters of competencies.

***Source:*** The TVET Glossary of Terms, TESDA, Philippines, 2010

**178 Сургууль, үйлдвэрийн хамтарсан хөтөлбөр**

Сургууль-үйлдвэрийн хамтарсан хөтөлбөр нь сургууль дээрх болон ажлын байран дээр сургалтыг хослуулан олгодог хөтөлбөр бөгөөд ихэнх хөтөлбөрүүд суралцагчдад дагалдах, дадлагажих сургалтад хамрагдах боломжоор хангадаг буюу мэргэжлийн боловсрол, сургалтын хөтөлбөрт хамрагдахад дүйцэх оноо олгодог.

***Эх сурвалж:*** МБС-ын тайлбар толь, МБСҮТ Австрали, 2013

**School and industry cooperation program**

School–industry cooperation programme is for learners which combines school learning with workplace learning.

Many such programmes lead to advanced standing in an apprenticeship or traineeship or credit towards a vocational education and training course.

***Source:*** Glossary of VET, NCVER, Australia, 2013

# Т

**179 Тасралтгүй боловсрол**

Насанд хүрэгчдэд зориулсан ихэвчлэн дунд сургуулийн дараах түвшинд хувь хүний боловсрол, шинжлэх ухааны эсвэл ажил мэргэжлийн чиглэлээр, богино хугацаат дамжаа буюу цагт суурилан зохион байгуулагдах боловсрол, сургалтын хөтөлбөр.

***Эх сурвалж:*** МБС-ын тайлбар толь, МБСҮТ Австрали, 2013

**Continuing education**

Educational programs for adults, usually at the post-secondary level and offered as part-time or short courses in personal, academic or occupational subject areas.

***Source:*** Glossary of VET, NCVER, Australia, 2013

**180 Тасралтгүй сайжруулалт /МБС-ын/**

Тасралтгүй сайжруулалт гэдэг нь ТМБС-ын байгууллага өөрийн бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний чанар, тэдгээрт холбогдох үйл ажиллагаагаа системтэйгээр хянаж шалган, сайжруулахад чиглэсэн төлөвлөгөөт үйл явц юм.

***Эх сурвалж:*** НҮБТМБСТ/МБС, Үнэлгээ баталгаажуулалтын тайлбар толь

**Continuous improvement**

A planned process which allows a TVET Institution to systematically review and improve the quality of its products, services and associated processes.

***Source:*** UNEVOC/Glossary of Terms for TVET, Assessment and Verification

181 **Техникийн боловсрол**

Техник, технологийн үйл ажиллагаа гүйцэтгэх, удирдах хэрэгцээнд нийцүүлж зохион байгуулалттай сургалтаар эзэмшүүлсэн үйлдвэрлэл, техник, технологийн мэргэжлийн мэдлэг, ур чадвар, хөдөлмөрийн болон харилцааны соёлыг төлөвшүүлэх үйл ажиллагаа.

***Эх сурвалж:*** МБС-ын тухай МУ-ын хууль, 2009

**Technical Education**

Activities to form industrial, technical, technological knowledge and skills and communication culture obtained through organized training in accordance with demand to perform and manage technical and technological activities.

***Source:*** Law of Mongolia on Vocational Education and Training, 2009

182 **Техник мэргэжлийн боловсрол сургалт**

"Техник мэргэжлийн боловсрол, сургалт"–ыг төрөл бүрийн ажил, мэргэжил, бүтээгдэхүүн, үйлчилгээ, ахуйтай холбоотойгоор боловсрол, сургалт, ур чадварыг хөгжүүлэх үйл явц гэж ойлгоно.

ТМБС нь насан туршийн сургалтын бүрэлдэхүүн хэсэг болохын хувьд дунд, дунд боловсролын дараах болон дээд боловсролын түвшинд зохион байгуулагдаж, мэргэшил олгох бөгөөд үүнд ажлын байран дээрх сургалт, үргэлжлүүлэн суралцах, мэргэжил дээшлүүлэх арга хэлбэрүүд орно.

***Эх сурвалж:*** ЮНЕСКО (GC), 2015

**Technical-Vocational Education and Training**

'Technical and vocational education and training' (TVET) is understood as comprising education, training and skills development relating to a wide range of occupational fields, production, services and livelihoods.

TVET, as part of lifelong learning, can take place at secondary, post-secondary and tertiary levels and includes work-based learning and continuing training and professional development which may lead to qualifications.

***Source:*** UNESCO (GC), 2015

183 **Техникч**

Инженер, эрдэмтэдтэй харьцуулбал практик талдаа илүү, ур чадвартай ажилтан харин гар хөдөлмөр эрхлэгчидтэй харьцуулбал онолын мэдлэг, ур чадвар илүү эзэмшсэн хүн.

Техникчийн боловсрол, сургалт нь ерөнхий боловсролын эсвэл техникийн дунд боловсролыг эзэмшиж дүүргэсэн төвшинтэй дүйцэхүйц байдаг боловч ерөнхийдөө дунд сургуулийн дараах шатны боловсролын түвшинд олгож, холбогдох зэрэг эсвэл диплом олгодог.

***Тайлбар***:
Техникч нь ур чадвартай ажилчин болон инженер, эрдэмтдийн хоорондын холбоос юм.

***Эх сурвалж:*** ТМБС-ын тайлбар толь, ТБУЧХА, Филиппин, 2010

**Technician**

A person who has acquired knowledge and skills of a more practical nature than those required of the qualified scientist, engineer on one hand, and more theoretical nature than those required of the skilled worker or craftsman, on the other.

A technician's education and training are likely to have taken him/her up at least up to a level equivalent to the end of secondary education in a general or technical stream, but usually to a post-secondary with a corresponding degree or diploma.

***Note***:
A technician is the link between the skilled workers and the scientists or engineers.

***Source:*** The TVET Glossary of Terms, TESDA, Philippines, 2010

184 **Технологи**

Сургалт, технологийн бүхий л явцыг төлөвлөх, ашиглах, үнэлэх системтэй аргачлал бөгөөд үүндээ техникийн болон хүний нөөц, тэдгээрийн харилцан уялдаа холбоог харгалзан үзсэнээр боловсрол, сургалт илүү үр дүнтэй болно.

***Эх сурвалж:*** ТМБС-ын тайлбар толь, ТБУЧХА, Филиппин, 2010

**Technology**

A systematic method of devising, applying and assessing the whole process of technology and learning by taking into account, both technical and human resources, inter-actions between these, so as to obtain a more effective form of education and training.

***Source:*** The TVET Glossary of Terms, TESDA, Philippines, 2010

185 **Тестийн даалгаврын сан**

Тестийн сангийн даалгавар эсвэл асуултын сан гэдэг нь даалгаврууд болон асуултуудын хадгалах хэрэгсэл юм. Энэ нь тест боловсруулах зорилгын хүрээнд тэдгээрийг хадгалах, удирдах, засварлах болон ашиглах боломжийг олгодог.

***Эх сурвалж:*** Үнэлгээ, баталгаажуулалтын баримт бичгийн төсөл, ХНХЯ, УБ, 2017

**Test item bank**

The test item or question bank is a storage facility for items or questions that allows them to be stored, managed, maintained and used for test generation purposes.

***Source***: (Draft) Policy on Verification of Assessment, MoLSP, UB, 2017

186 **ТМБС-ын удирдлага**

Эрх мэдэл, хүлээх хариуцлага болон хариуцлагын тогтолцоог хэрэгжүүлэх тусгай бүтэц.

Засаглалын баримт бичгүүд нь ТМБС-ын салбарын түншүүд болон оролцогчдын үйл ажиллагааг зохицуулах, шийдвэр гаргах нөхцөлийг бүрдүүлнэ.

***Тайлбар***:
Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам нь Монгол улсад МБС-ын салбарын асуудлыг эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага бөгөөд салбарын үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлэхэд засаглалын бүтэц, эрх зүйн шаардлагуудыг боловсруулан гаргадаг.

***Эх сурвалж:*** ТМБС-ын тайлбар толь,ТБУЧХА, Филиппин, 2010; МБС-ын тухай МУ-ын хууль, 2009

**Governance in TVET**

Explicit designation of authority and powers as well as responsibilities and accountabilities.

Governance statements regulate and enable decision-making and actions for the partners and participants who work within the TVET sector.

***Note***:
In Mongolia, as of today, the Ministry of Labour and Social Protection is the state authority responsible for VET and develops the governance structures and legal requirements for an effective TVET sector.

***Source:*** The TVET Glossary of Terms, TESDA, Philippines, 2010
Law of Mongolia on Vocational Education and Training, 2009

**187 Төгсөгч (МБС)**

Тодорхой нэг сургалт, дамжаанд элсэн суралцаж, тухайн сургалт, дамжааны хөтөлбөрийн шаардлагуудыг хангасан оюутан эсвэл суралцагчийг хэлнэ.

***Эх сурвалж:*** ТМБС-ын тайлбар толь, ТБУЧХА, Филиппин,2010

**Graduate (VET)**

A student or trainee who was enrolled in a particular course and has completed the requirements set for that course/program including successful assessment.

***Source:*** The TVET Glossary of Terms, TESDA, Philippines, 2010

**188 Төлөвшил/ Зан үйл**

Суралцагчийн хүмүүжил, итгэл үнэмшлийн цогц.

***Эх сурвалж:*** МУ-ын Боловсролын тухай хууль, 2007

**Behavior (as competency attitude at workplace)**

Set of learner's belief and manner.

***Source:*** Law of Mongolia on Education, 2007

**189 Техникийн бус ур чадвар**

Хэд хэдэн салбар болон ажил, мэргэжлүүдэд хамааралтай ур чадварууд ба хувийн чадамж (итгэлтэй байдал, сахилга бат, хувийн зохион байгуулалт) болон нийгмийн чадамж (багаар ажиллах, харилцаа, сэтгэл хөдлөлөө барих).

***Эх сурвалж:*** Ур чадварын тойм, Cedefop, Европын Холбоо, 2015

**Non-technical /soft/ skills**

Skills that are cross-cutting across jobs and sectors and relate to *personal competences* (confidence, discipline, self-management) and *social competences* (teamwork, communication, emotional intelligence).

***Source:*** Skills Panorama Glossary, Cedefop, European Union, 2015

190 **Төр хувийн хэвшлийн түншлэл (ТХХТ)**

Төр, хувийн хэвшлийн түншлэл бол 2 ба түүнээс дээш төрийн болон хувийн хэвшлийн байгууллагын урт хугацаат хамтын ажиллагаа юм.

ТМБС-ын салбар дахь төр-хувийн хэвшлийн албан болон албан бус хамтын ажиллагаа нь нөөцийг үр бүтээлтэй ашиглах, хөдөлмөрийн зах зээл дээрх ажиллах хүчний эрэлт хэрэгцээг хангах үүднээс ур чадварын сургалт явуулдаг МБС-ын байгууллагын төгсөгчдийг чадавхжуулж, ажилд авах чиглэлээр үйлдвэр, аж ахуйн газруудтай нягт хамтран боломжийг бүрдүүлдэг.

***Эх сурвалж:*** НҮБТМБСТ/МБС, Үнэлгээ баталгаажуулалтын тайлбар толь

**Public-Private Partnerships (PPPs)**

A public–private partnership (PPP) is a cooperative arrangement between two or more public and private sectors, typically of a long-term nature.

PPPs in the form of formal or informal cooperative arrangements in the field of TVET assist the TVET institutions engaged in skills training to be in close connection with the entities which absorb their graduates with a view to successfully mobilize resources and provide the workforce needs of the labor market.

It is also known as *Social Partnership*. The social partners are primarily the employers and trade unions.

***Source:*** UNEVOC/Glossary of Terms for TVET, Assessment and Verification

191 **Төрөөс санхүүждэг сургалт**

Улс, бүс, аймаг орон нутгийн түвшинд төрийн санхүүжилтээр зохион байгуулагдах мэргэжлийн боловсрол, сургалтын үйл ажиллагаа.

***Тайлбар***:
Улсын төсвөөс тухайн жилд МБС-ыг дэмжих санд олгох хөрөнгийн хэмжээг УИХ тухайн жилийн төсөвт тусган батлах заалтыг Монгол улсын МБС-ын тухай хуульд (21-р бүлэгт) тусгажээ.

***Эх сурвалж:*** Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай МУ-ын хууль, 2009

**State-funded training profile**

Vocational education and training streams planned to be delivered at national, regional, provincial and local levels and funded by the state.

*Note*:
Law on VET stipulates that Parliament of Mongolia (State Great Khural) approves annual state funds to be allocated in VET sector (Chapter 21).

***Source:*** Law of Mongolia on Vocational Education and Training, 2009

**192 Төсөлд суурилсан зааварчилгаа / сургалт**

Амьдрал дээр хэрэгжих боломжтой төслүүдийг боловсруулан төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлж дүгнэхтэй холбоотой суралцагчдад зориулсан үнэн, бодит зааварчилгааны загвар, стратеги.

***Эх сурвалж:*** ТМБС-ын тайлбар толь, ТБУЧХА, Филиппин, 2010

**Project-based instruction**

An authentic instructional model or strategy in which students plan, implement and evaluate projects that have real world applications.

***Source:*** The TVET Glossary of Terms, TESDA, Philippines, 2010

**193 Төсөлд суурилсан үнэлгээ**

Суралцагчийн төслийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх. Суралцагчид өөр өөр төсөл дээр янз бүрийн хугацаагаар ажилладаг учраас уламжлалт ангийн ажлыг үнэлэх үнэлгээнээс ялгаатай.

Энэ нөхцөлд суралцагчийг үнэлэх багшийн үүрэг нь хүн бүрийг хамтад нь үнэлдэг ангийн ажлын нийтлэг зааварчилгаанаас илүү нарийн, өргөн хүрээтэй байдаг.

***Эх сурвалж:*** ТМБС-ын тайлбар толь, ТБУЧХА, Филиппин, 2010

**Project-based assessment**

Assessing student performance on a given project work. This is different from assessing traditional class work, because students are working in different projects with different timelines. The teacher's task of assessing students is more complex than for typical classroom teacher's instruction where everyone is evaluated together.

***Source:*** The TVET Glossary of Terms, TESDA, Philippines, 2010

**194 Тусгай зөвшөөрөл**

Эрх бүхий байгууллагаас (а) шинээр боловсрол сургалтын үйл ажиллагаа эрхлэх, (б) сургалтын шинэ хөтөлбөр эхлүүлэх, (в) мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх, (г) боловсролын хэрэглэгдэхүүн (хэвлэмэл, онлайн), програм хангамжийг ашиглах эрхийг албан ёсоор олгосон зөвшөөрөл.

***Эх сурвалж:*** Үнэлгээ, баталгаажуулалтын бодлогын төсөл, ХНХЯ, УБ, 2017

**Licensing**

Formal granting of permission to (a) operate a new institution (b) a new program of study (c) practice a profession (d) use an educational product (paper or online) or computer application.

***Source***: (Draft) Policy on Qualitiy Assurance, MoLSP, UB, 2017

**195** **Тэгш боломж**

Тэгш боломжийн гол зарчим нь үндэс угсаа, арьс өнгөөр ялгаварлан гадуурхахыг хориглох, хүйсийн тэгш байдлыг эрхэмлэх гэсэн хоёр үндсэн элементийг агуулдаг.

Энэ нь бүх салбарт, ялангуяа эдийн засаг, нийгэм, соёл болон гэр бүлийн амьдралын хүрээнд үйлчлэх ёстой.
Тэгш боломж гэдэг нь оюутан, суралцагч бүрд боловсрол, сургалтад хамрагдах ижил боломж олгохыг хэлнэ.

***Эх сурвалж:*** Европын Холбооны Хороо LLP, 2007-2013, Европ

**Equal opportunity**

The general principle of equal opportunities contains two key elements: one is the ban on discrimination on grounds of nationality or race, and the other is equality for men and women (gender equity).

It is intended to apply to all fields, particularly economic, social, cultural and family life.

Equal opportunities apply when every student or trainee with the necessary skills, experience and qualifications to undertake education or training is given an equal chance of doing so.

***Source:*** EU Commission LLP, 2007-2013, Europe

# У

**196** **Урвуу шатлалт сургалт (дээд сургуулиас мэргэжлийн боловсролын сургуульд шилжих)**

Оюутнууд их, дээд сургуулиас мэргэжлийн боловсрол, сургалтад шилжих үйл явц.

Зах зээл дээрх тодорхой мэргэжлийн эрэлт хэрэгцээ, орлого олох боломж, хувь хүний авьяас, чадвар зэргээс шалтгаалан их дээд сургуулийн оюутан мэргэжлийн боловсролын сургуульд шилжин суралцвал сурсан багц цагийг нь дүйцүүлэн шилжүүлэх журам мөрдөгддөг. Зөвхөн дээд сургуулийн оюутан төдийгүй, дээд боловсролтой хүн өөр ажил эрхлэх эсвэл өмнө эзэмшсэн боловсрол, мэргэшлээ уялдуулах зорилгоор мэргэжлийн боловсрол, сургалтад шилжин суралцах үед ийм урвуу шатлалтай сургалт байж болно.

***Эх сурвалж:*** МБС-ын тайлбар толь, МБСҮТ Австрали, 2013

**Reverse articulation**

Movement of students from higher education into vocational education and training (VET).

The procedure ruling transfer of learnt credit hours in equivalence is followed, if a higher education institution student moves to vocational education training because of demand of a given occupation and opportunity to earn income in the labor market and individual's own talent and abilities. This kind of reverse articulation can be created when not only the higher education student but also a person who already acquired high education move to vocational education training and then to deal with another employment and/or to combine previously learnt high education and qualification.

***Source:*** Glossary of VET, NCVER, Australia, 2013

**197** **Ур чадвар**

Ажил, үүрэг гүйцэтгэх болон асуудал шийдвэрлэхэд мэдлэгээ хэрэглэх, ноу-хауг ашиглах, мөн тодорхой нэг ажлын ажилбаруудыг гүйцэтгэх чадварыг хэлнэ.

***Эх сурвалж:*** Европын Холбооны Хороо (Ур чадварын тойм), Европ, 2015

**Skills**

Refers to the ability to apply knowledge, use know-how to complete tasks and solve problems and carry out the tasks that comprise a particular job.

***Source:*** EU commission (Skills panorama), Europe, 2015

**198** **Ур чадвартай ажилтан**

Батлагдсан мэргэжил, гар урлал эсвэл бусад ажил мэргэжлийг гүйцэтгэхэд шаардлагатай мэргэшлийг бүрэн дүүрэн эзэмшсэн хүнийг хэлнэ.

***Эх сурвалж:*** ТМБС-ын тайлбар толь, ТБУЧХА, Филиппин, 2010

**Skilled worker**

A person who has acquired the full qualifications required in performing a recognized trade, craft or other occupation.

***Source:*** The TVET Glossary of Terms, TESDA, Philippines, 2010

**199** **Ур чадварыг хөгжүүлэх**

Ажил мэргэжилд хамааралтай ур чадвар, чадамжийг мэргэжлийн боловсрол, сургалтаар дамжуулан хөгжүүлэх тухай ойлголт юм.

Ур чадварыг хөгжүүлснээр зэрэг дэв, цол хэргэм ахиулахыг хэлнэ.

***Эх сурвалж:*** МБС-ын тайлбар толь, МБСҮТ Австрали, 2013

**Skill development**

The development of work-related skills or competencies through vocational education and training.

Skill development is also called as *skill formation*.

***Source:*** Glossary of VET, NCVER, Australia, 2013

**200** **Ур чадварыг хүлээн зөвшөөрөх**

Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага, мэргэжлийн холбоод, ажил олгогч, бүртгэл мэдээллийн газар болон бусад байгууллагаас ур чадвар, мэргэшлийг хүлээн зөвшөөрч баталгаажуулах үйл явц.

***Тайлбар***:
Монгол улсад мэргэжлийн ур чадварыг хүлээн зөвшөөрч баталгаа гаргах журам нь "Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай" хуульд үндэслэн хэрэгжинэ. Энэхүү хуулийн 9,10,16-р зүйлд ур чадварын стандарт, ур чадварт тавигдах шаардлага, мэргэжлийг баталгаажуулах баримт бичгийн талаар тодорхой заасан байна.

***Эх сурвалж:*** МБС-ын тайлбар толь, МБСҮТ Австрали, 2013
Мэргэжлийн Боловсрол, Сургалтын тухай МУ-ын хууль, 2011

**Skill recognition**

The recognition, acknowledgement or verification of skills and qualifications by vocational educational institutions, professional

bodies, employers, registration authorities and other organisations.

***Note***:
The procedure to recognize and verify vocational skills in Mongolia is implemented on the basis of Law of VET. Articles 9, 10 and 16 clearly indicate skill standards and requirements and documents verifying the occupations.

***Source:*** Glossary of VET, NCVER, Australia, 2013
Law of Mongolia on Vocational Education and Training, 2011

**201 Ур чадварын багц**

Аливаа хүний хэр ажилтан болох болон хөдөлмөр эрхлэлтийн шаардлагыг хэр хангаж байгааг харуулах ажил, мэргэжлийн амжилт, ахиц дэвшлийг нотлох баримт, материалын цуглуулга болон ур чадварын бүртгэл.

***Эх сурвалж:*** МБС-ын тайлбар толь, МБСҮТ Австрали, 2013

**Skills portfolio**

A collection of materials that provide samples of work-related achievements and a record of skills that show what kind of worker a person is and how s/he meets the employment criteria.

***Source:*** Glossary of VET, NCVER, Australia, 2013

**202 Ур чадварын гэрчилгээ**

Хэрхэн, яаж ур чадвар эзэмшсэнээс нь үл хамааран, ажилтны ур чадварыг албан ёсоор хүлээн зөвшөөрөн олгох баримт бичиг.

***Эх сурвалж:*** ТМБС-ын тайлбар толь,ТБУЧХА, Филиппин, 2010

**Skills certification**

Formal recognition of workers' skill qualifications, independent of the manner in which they were acquired.

***Source:*** The TVET Glossary of Terms, TESDA, Philippines, 2010

**203 Ур чадварын шинжилгээ**

Аливаа ажил, хөдөлмөр эрхлэхэд шаардагдах бүх төрлийн чадвар, дадал, чадамжуудыг тодорхойлох үйл явц. Тодорхой нэг ажлын үүрэг гүйцэтгэхэд шаардагдах мэдлэг, чадвар, төвөгшлийн түвшин, стандарт бус хөдөлмөрийн агуулга, хариуцлага, бие даасан байдал зэргийг мэргэшлийн түвшингээр ялган, ангилж байгаа хэмжүүр шалгуурыг судална.

Мөн ур чадварын хэрэгцээ, шаардлага, ирээдүйн чиг хандлага, хомсдол, ур чадвар дээшлүүлэхэд дутагдаж буй орчин нөхцөл, хангамж нөөц, зах зээлийн эрэлт хэрэгцээг үүнтэй холбоотойгоор судлах шаардлага гарна.

***Эх сурвалж:*** МБС-ын тайлбар толь, МБСҮТ Австрали, 2011

**Skills analysis**

Process to identify different type of skills and practice. Study criteria that classifies the independency, responsibility, non-standard labour content, complexity level, skills, knowledge necessary to preform specific tasks by the qualifications level.

Related to this it's necessary to study the market needs, supplies and environment needed to improve skills, deficiency, trend, need

and demand of skills. An identification of the skills or competencies needed for each job.

***Source:*** Glossary of VET, NCVER, Australia, 2011

**204** **Ур чадварын түвшинг дээшлүүлэх**

Нэг мэргэжлийн хүрээнд мэргэшлийн түвшинг дээшлүүлэх замаар ажилтны ажлын нөхцөл сайжрах, албан тушаал ахих, цалин өсөх боломжийг олгодог мэргэшлийн сургалт юм.

Техник, технологи хурдацтай хөгжиж буй өнөө үед ажиллах хүчний ур чадвар, мэргэшлийг байнга дээшлүүлэх зайлшгүй шаардлагатай учир мэргэжлийн боловсрол, сургалтын үндэсний тогтолцоонд гол байр эзэлнэ.

***Эх сурвалж:*** МБС-ын тайлбар толь, МБСҮТ Австрали, 2011

**Skill upgrading**

Vocational training to upgrade the qualifications level and knowledge within the same trade (occupation) to enable the trainee to better perform his/her work condition and eventually to become eligible for promotion.

In today's accelerated progress of technique and technologies, continuous upgrading of skills and qualifications of employees is a vital process as it plays the key role in VET development.

***Source:*** Glossary of VET, NCVER, Australia, 2011

**205** **Ур чадварын аудит**

Цаашдын ажил, мэргэжлээ сонгох, мэргэжлийн баримжаатай болох, эсвэл суралцах сургалтаа төлөвлөх зорилгоор хувь хүний идэвх санаачилга, авьяас чадвар, чадамж, ур чадвар, мэдлэгт дүн шинжилгээ хийх.

***Тайлбар***:
- ур чадварын аудит нь хувь хүнд туслалцаа үзүүлнэ;
- хувь хүний албан тушаал ахих боломжид дүн шинжилгээ хийнэ;
- хувь хүн ажлын орчиндоо өөрөө үнэлнэ;
- албан ба албан бус сургалтын үр дүнгээ баталгаажуулахад бэлтгэнэ;
- албан тушаал дэвших үе шатаа төлөвлөнө.

***Эх сурвалж:*** Төв Европын МБС –ын толь бичиг,(Cedefop), 2008

**Skills audit**

Analysis of knowledge, skills and competences of an individual, including his or her aptitudes and motivations to define a career project and/or plan professional reorientation or training project.

***Note***:
A skills audit aims to help individuals to:
- analyse their career backgrounds
- self-assess their position in the labour environment
- prepare themselves for validation of non-formal or informal learning outcomes
- plan career pathways.

***Source:*** Terminology of European Education and Training Policy, Cedefop, 2008

**206 Ур чадварын хомсдол**

Тодорхой ажил мэргэжлээр ажиллах хүмүүсийн эрэлт нь тухайн ажлыг эрхлэхэд шаардлагатай мэргэжил эзэмшсэн болон тэрхүү мэргэжлээр ажиллах боломжтой, сонирхолтой хүмүүсийн тооноос давж гарсан байх нөхцөл.

***Эх сурвалж:*** МБС-ын тайлбар толь, МБСҮТ Австрали, 2013

**Skill shortage**

Where the demand for employees in specific occupations is greater than the supply of those who are qualified, available and willing to work under existing industry conditions.

***Source:*** Glossary of VET, NCVER, Australia, 2013

**207 Ур чадварын хөрвөлт**

Чадвар, дадал, чадамжуудыг нэг ажил мэргэшлээс нөгөөд шилжүүлэн ашиглах боломж.
Хөрвөх ур чадварт асуудлыг шийдвэрлэх чадвар, шинэ санаа мэдээллийг үр өгөөжтэй солилцох, бүтээлч, манлайлагч, шударга үнэнч байдал, аж ахуй эрхлэх чадварыг оруулна. Эдгээр ур чадварын тусламжтайгаар хувь хүн илүү үр дүнтэй ажил хөдөлмөр эрхлэх боломж, янз бүрийн ажлын орчинд дасан зохицох чадвараа дээшлүүлдэг.

***Эх сурвалж:*** МБС-ын тайлбар толь, МБСҮТ Австрали, 2013
Нийтэд зориулсан боловсрол (GMR) 2012

**Skills transfer**

The transfer of skills or competencies from one work context to another.

Transferable skills include the ability to solve problems, communicate ideas and information effectively, be creative, show leadership and conscientiousness, and demonstrate entrepreneurial capabilities. People need these skills to be able to adapt to different work environments and so improve their chances of staying in gainful employment.

***Source:*** Glossary of VET, NCVER, Australia, 2013; EFA (GMR) 2012

**208 Уян хатан сургалт**

Хэзээ, хаана, хэрхэн суралцахаа сонгох өргөн хүрээний боломж олгож сургалтын төрөл бүрийн хэлбэр, аргуудыг суралцагчдад санал болгох.

Суралцагчдад хэзээ, хаана, хэрхэн суралцаж болох талаар илүү өргөн сонголт олгож буй боломж бөгөөд үүнд онлайнаар, ажлын байраа түшиглэсэн, зайны, ганцаарчилсан , хурдавчилсан эсвэл хойшлуулж сунгасан сургалт гэсэн олон төрлийн сургалт хамаардаг.

***Эх сурвалж:*** НҮБТМБСТ/Нээлттэй зайны сургалт-үндсэн нэр томьёо, тодорхойлолт, COL, 2015

**Flexible learning**

Opportunities that provide more choices to the learners in terms of training types and means and when, where and how they learn.

Flexible learning may include use of online learning, work place-based learning, part-time learning, distance learning, and many forms

of face-to-face teaching and learning with options to fast track and defer courses.

***Source:*** UNEVOC/Open and Distance Learning – Key Terms & Definitions, COL, 2015

# Ү

**209** **Үнэлүүлэгч**

Өмнөх мэдлэг ур чадваруудаа хүлээн зөвшөөрүүлэхийн тулд бүртгүүлсэн суралцагч эсвэл иргэнийг хэлнэ.

***Эх сурвалж:*** Үнэлгээ, баталгаажуулалтын бодлогын төсөл, ХНХЯ, УБ, 2017

**Candidate**

A candidate is a registered training participant or a registered person applying for Recognition of Prior Learning.

***Source***: (Draft) Policy on Verification of Assessment, MoLSP, UB, 2017

**210** **Үнэлгээ**

Үнэлгээ гэсэн нэр томьёог МБС-ын салбарт 2 агуулгаар хэрэглэнэ. Суралцагчийн сургалтын үр дүн (мэдлэг, туршлага, чадвар, чадамж)-г үнэлэн ихэнх тохиолдолд гэрчилгээ олгодог арга зүй, үйл явцын цогц.

Мэргэшил, гэрчилгээ олгох зорилгоор суралцагч, сургагч багш, сургалтын арга зүй, хөтөлбөр, сургалтын байгууллагад тавигддаг стандартад хүрсэн эсэхийг нотолгоонд суурилан үнэлж, тогтоох үйл явц.

***Эх сурвалж:*** ОУХБ, 2007
МБС-ын тайлбар толь, МБСҮТ Австрали, 2013

**Assessment**

The term Assessment is used in two specific contexts in VET.
In the context of *assessing a learner:*
The sum of methods and processes used to evaluate the attainments (knowledge, know-how, skills and competences) of an individual, and typically leading to certification.

In the context of *quality assurance* of the institution/programme:
All methods used to appraise performance by gathering evidence to determine whether learners, trainers, training methodologies, programmes and institutions have achieved the required standards.

***Source:*** ILO, 2009; Glossary of VET, NCVER, Australia, 2013

**211** **Үнэлгээний арга (ууд)**

Мэдлэгийн тест, дадлагын гүйцэтгэлийг шалгах хуудас гэх мэт үнэлгээний нотолгоо цуглуулах стратеги, арга техник.

***Эх сурвалж:*** НҮБТМБСТ/ТМБС-ын толь бичиг

**Assessment method(s)**

A strategy or technique for the gathering of evidence for (competency) assessment, such as a knowledge test or a checklist of practical performance.

***Source:*** UNEVOC/TVETipedia Glossary

**212 Үнэлгээний баталгаажилт**

МБС-ын магадлан итгэмжлэгдсэн хөтөлбөр болон сургалтын багцууд нь тавигдсан шаардлагыг хангаж байгаа эсэхийг үнэн зөв тодорхойлох зорилгоор үнэлгээнд ашигласан арга, хэрэгсэл үнэн зөв, баталгаатай, хангалттай, холбогдох нотолгоо бүрдүүлж чадсан эсэхийг шалгаж, батлах үйл явц.

***Эх сурвалж:*** Үнэлгээ баталгаажуулалтын бодлогын баримт бичгийн төсөл, ХНХЯ,УБ, 2017

**Assessment verification**

Assesment verification involves checking that the assessment tools produce valid, reliable, sufficient, current and authentic evidence to enable reasonable judgments to be made as to whether the requirements of the training package qualification or VET accredited course are met.

***Source:*** (Draft) Policy on Assessment Verification, MoLSP, UB,2017

**213 Үнэлгээний удирдамж**

Үндэслэл сайтай, үнэн зөв, уян хатан, шударга үнэлгээнд чиглэсэн үйлдвэрлэлийн хандлагыг илэрхийлэхийн зэрэгцээ үнэлгээг бататгадаг сургалтын багцын баталгаажуулалт бүхий бүрэлдэхүүн хэсэг.

Зааварчилгаанд үнэлгээний ерөнхий тогтолцоо, үнэлгээний ажилтанд тавигдах шаардлага, үнэлгээний хэрэглэгдэхүүний загвар гаргах, үнэлгээг явуулах, үнэлгээтэй холбоотой мэдээллийн эх сурвалж зэрэг бүх талын мэдээллийг хамруулна.

***Эх сурвалж:*** НҮБТМБСТ/МБС, үнэлгээ баталгаажуулалтын тайлбар толь

**Assessment guidelines**

An endorsed component of a training package or accredited course which underpins assessment and which sets out the industry approach to valid, reliable, flexible and fair assessment.

It includes broad information such as an overview of the assessment system and information on assessor requirements, designing assessment resources and conducting assessment, information source related to assessment.

***Source:*** UNEVOC/Glossary of Terms for TVET, Assessment and Verification

**214 Үнэлгээний хяналт**

Үнэлгээний хүчин төгөлдөр, найдвартай, шударга байдлыг хангахын тулд янз бүрийн үнэлгээчин, үнэлгээний төв, үнэлгээ хийсэн байгууллагаас үнэлүүлэгчийн гүйцэтгэлд өгсөн үнэлгээг харьцуулах боломжийг бий болгох үйл явц

***Эх сурвалж:*** ТМБС-ын тайлбар толь,ТБУЧХА, Филиппин, 2010

**Assessment moderation**

The process of establishing comparability of judgments of standards of candidate's performance across different assessors, assessment center and venues, in order to ensure that assessment is valid, reliable and fair.

***Source:*** The TVET Glossary of Terms, TESDA, Philippines, 2010

**215 Үнэлгээний материал**

Сургалтын багцын чухал бүрэлдэхүүн хэсэг болох үйлдвэр дээр үнэлгээ хийх батлагдсан удирдамж бүхий үнэлгээний загвар, үнэлгээний тусгай даалгавар, зааварчилгаа гэх мэт.

***Эх сурвалж:*** НҮБТМБСТ/МБС, үнэлгээ баталгаажуулалтын тайлбар толь

**Assessment materials**

Optional component of a training package that complements endorsed industry assessment guidelines and could take the form of assessment exemplars or specific assessment tasks and instructions.

***Source:*** UNEVOC/Glossary of Terms for TVET, Assessment and Verification

**216 Үнэлгээний тогтолцоо**

Янз бүрийн нөхцөл байдалд олон үнэлгээчний олон хүнд өгсөн үнэлгээний дүнг шударга, хүчин төгөлдөр, нийцтэй, найдвартай байлгах хараа хяналттай, зохион байгуулалтай үйл явц бөгөөд энд санал гомдол гаргах, давж заалдах журам, баталгаажуулалтын болон тайлан/бүртгэлийн систем, хүн хүчний оролцоо, захиргааны дүрэм журам, үүрэг хариуцлага, түншлэл, чанарын баталгаажилтын механизм, эрсдэлийн менежментийн стратеги, үнэлгээний баримтжуулалт зэрэг хамаарна.

***Эх сурвалж:*** НҮБТМБСТ/МБС, үнэлгээ баталгаажуулалтын тайлбар толь

**Assessment system**

A controlled and ordered process designed to ensure that decisions made in relation to many individuals, by many assessors, in many situations are consistent, fair, valid and reliable, and may include grievances and appeals process, verification systems and processes, reporting/recording arrangements, acquisition of physical and human resources, administrative procedures, roles and responsibilities, partnership arrangements, quality assurance mechanisms, risk management strategies and documented assessment processes.

***Source:*** UNEVOC/Glossary of Terms for TVET, Assessment and Verification;

**217 Үнэлгээний хэрэгсэл**

Нотолгоо цуглуулах, батлан тайлбарлахад зориулсан зааварчилгаа, аргачлалын аль алиныг агуулсан хэрэгсэл юм:

- аргачлал – үнэлгээнд ашиглахаар сонгож авсан үнэлгээний аргын дагуу боловсруулсан тусгай асуултууд эсвэл ажлын даалгавар (хүлээн зөвшөөрөгдсөн гүйцэтгэлийн шалгах хуудас, үнэлгээчний шийдвэр гаргах журам багтаж болно)
- журам – үнэлгээ явуулах болон бүртгэж тэмдэглэхтэй холбоотойгоор оюутан болон үнэлгээчинд өгөх мэдээлэл/зааварчилгаа.

***Эх сурвалж:*** НҮБТМБСТ/МБС, үнэлгээ баталгаажуулалтын тайлбар толь

**Assessment tool**

A tool which contains both the instrument and the instructions for gathering and interpreting evidence:

- instrument(s)– the specific questions or activities developed from the selected assessment method(s) to be used for the assessment (a profile of acceptable performance and the decision-making

rules for the assessor may also be included); and,
- procedures– the information/instructions given to the student and/ or the assessor regarding conditions under which the assessment should be conducted and recorded.

***Source:*** UNEVOC/Glossary of Terms for TVET, Assessment and Verification

218 **Үнэлгээний ажилтан**

Үнэлгээ зохион байгуулах, цуглуулсан нотолгоонуудыг тухайн ажил үүргийн гүйцэтгэлийн стандарт/шалгуурuudтай харьцуулахүүрэг бүхий туршлагатай, мэргэшсэн мэргэжилтэнийг хэлнэ. Тэрээр мөн тухайн хувь хүний чадамжийн талаар албан ёсны үнэлгээ хийдэг.

***Эх сурвалж:*** МБС-ын тайлбар толь, МБСҮТ Австрали, 2013;НҮБТМБСТ/SAQA, Өмнөд Африк, 2013

**Assessor**

Is an experienced and qualified professional who carries out the assessment, compares collected evidences with the performance standards / criteria of the job and then makes a formal assessment of the individual's competence.

***Source:*** Glossary of VET, NCVER, Australia, 2013 UNEVOC/SAQA, South Africa, 2013

219 **Үр ашиг**

Үр ашиг нь 2 төрлийнх байна. Үүнд: гадаад, дотоод үр ашиг.

*Гадаад үр ашиг*
Оруулсан хөрөнгө оруулалт (жишээ нь, ажилтны цалин хөлс, тоног төхөөрөмж, засвар үйлчилгээ болон ашиглалтын зардлууд) ба суралцагч болон нийгэмд үзүүлсэн үр өгөөжийн (жишээ нь, ажил хөдөлмөр хийх, цалин хөлс авах, бүтээмж болон эдийн засгийн өсөлтөд оруулах хувь нэмэр) хоорондын харьцаа хамаарал.

*Дотоод үр ашиг*
Боловсролын нөөцийн ашиглалт болон үр дүнгийн хоорондын харьцаа хамаарал. Үүнийг байгаа нөөц бололцоогоо ашиглан хамгийн сайн үр дүнд хүрэх "шилдэг" хэрэглээ гэж үзнэ.

***Эх сурвалж:*** НҮБТМБСТ/ТМБС-ын толь бичиг

**Efficiency**

Effienciency can be of two types: External efficiency and internal efficiency.

*External efficiency*
The relationship between the resources invested (e.g., personnel salary, equipment, maintenance and other operating expenses) and the resulting benefits accruing later to the learners and the society (e.g. employment, earnings, productivity and contribution to economic growth).

*Internal efficiency*
The relationship between utilization of educational resources and results. This is explained as optimal (best) use of the available resources for maximum results.

***Source:*** UNEVOC/TVETipedia Glossary

**220 Үр дүнд суурилсан боловсрол**

Суралцагч төгсөхдөө эзэмшсэн байх ур чадварыг нарийвчлан тодорхойлсон сургалтын үр дүнд чиглэн зохион байгуулагдах боловсрол.

***Эх сурвалж:*** МБС-ын тайлбар толь, МБСҮТ Австрали, 2013

**Outcomes-based education**

An educational system focussed and organised around clearly defined (learning) outcomes which learners are expected to demonstrate upon completion.

***Source:*** Glossary of VET, NCVER, Australia, 2013

**221 Үе тэнгийн хнээсээ суралцах**

Үе тэнгийнхнээсээ суралцах үйл явцын хүрээнд оюутнууд боловсролын зорилгоо биелүүлэхийн тулд бие биетэйгээ харилцан суралцдаг.

Үүнийг хамтран суралцах үйл явцтай харьцуулж болно. Энэ аргыг сурган хүмүүжүүлэх үндсэн загварт бараг байдаггүй хувийн зохион байгуулалтын асуудлыг дээгүүрт тавьдаг албан болон албан бус, бичил багаар эсвэл онлайн сургалтад алинд нь ч ашиглаж болно.

***Эх сурвалж:*** Үе тэнгийн суралцагсдын танин мэдэхүйн хандлага О'Доннел А. М., А. Кинг, 1999
Хүн бүрт зориулсан сургалт, Бүх зүйлийг суралцах. Лауренс Эрлбаум, 2011

**Peer learning**

Peer learning is an educational practice in which students interact with other students to attain educational goals.

It can be compared to the practices that go by the name cooperative learning.

Whether it takes place in a formal or informal learning context, in small groups or online, peer learning manifests aspects of self-organization that are mostly absent from pedagogical models of teaching and learning.

***Source:*** Cognitive perspectives on peer learning, O'Donnell, A. M., A. King 1999 Learning for Everyone, By Everyone, about almost Anything, Lawrence Erlbaum, 2011

**222 Үндсэн чадамж**

Ажилтан үр бүтээлтэй ажиллахад амин чухал нийтлэг чадамж, ур чадварууд.
Үндсэн чадамжууд нь тодорхой нэг ажил эсвэл үйлдвэрт ажиллахад шаардлагатай гэхээс илүүтэйгээр хөдөлмөр эрхлэлтэд нийтлэг хэрэглэгддэг. 1992 оны Майерын Илтгэлд 7 дараах түлхүүр чадамжийг тодорхойлсон байна. Үүнд:

- мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх, зохион байгуулах;
- шинэ санаа, мэдээлэл дамжуулах;
- үйл ажиллагааг төлөвлөж, зохион байгуулах;
- бусадтай болон багаар ажиллах;
- тооны арга техник ашиглах;
- асуудал шийдвэрлэх;
- технологи ашиглах.

***Эх сурвалж***: МБС-ын тайлбар толь, МБСҮТ Австрали, 2013

**Key competency**

Any of several generic skills or competencies considered essential for people to participate effectively in the workforce.

Key competencies apply to work generally, rather than being specific to work in a particular occupation or industry.

The Mayer Report (1992) identified the following seven key competencies:
- collecting, analysing and organising information;
- communicating ideas and information;
- planning and organising activities;
- working with others and in teams;
- using mathematical ideas and techniques;
- solving problems;
- using technology.

***Source:*** Glossary of VET, NCVER, Australia, 2013

# Х

**223 Хандлага**

Хандлага гэдэг нь аливаа зүйлд хариу үйлдэл үзүүлэх тогтвортой, удаан үргэлжлэх байдал бөгөөд хандлага нь итгэл үнэмшил (танин мэдэхүйн нөлөө), мэдрэмж (нөлөөлөх шинж), санаа зорилго (когнатив)-ын үндсэн дээр бүрэлдэн тогтдог.

Суралцах чин хүсэл, эрмэлзэлтэй, суралцахыг зорилгоо болгосон, суралцахад өөртөө итгэлтэй, дуртай байх хандлагыг МБС-д эрхэмлэдэг.

***Эх сурвалж:*** Европын Холбооны комисс (Прогресс), Европ 2011

**Attitude**

Attitude is a stable, long-lasting, learnt predisposition to respond to certain things in a certain way, and attitudes are formed on the basis of beliefs (cognitive aspect), feelings (affective aspect) and intentions (cognative aspect).

In the VET context, desired ‘attitude to learning’ is motivation to learn, learning preferences, self-confidence in learning, enjoyment of learning.

***Source:*** EU Commission (Progress), Europe, 2011

**224 Хосмог сургалтын тогтолцоо**

Магадлан итгэмжлэгдсэн хосмог сургалтын тогтолцооны хүрээнд хөдөө аж ахуй, анагаах ухаан, аж үйлдвэр, бизнесийн салбаруудад хамтран боловсруулсан сургалтын төлөвлөгөөнд суурилан үйлдвэр болон сургууль дээр сургалтыг хослуулан явуулах техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалтын зааварчилгааны систем.

***Тайлбар***:
Герман улсад хосмог сургалтын тогтолцоо хамгийн амжилттай хэрэгждэг.

***Эх сурвалж:*** ТМБС-ын тайлбар толь, ТБУЧХА, Филиппин, 2010

**Dual training system**

An instructional delivery system of technical and vocational education and training that combines in plant and in-school training

based on a training plan collaboratively designed and implemented by an accredited dual system in sectors such as agricultural, medical, industrial and business establishments.

***Note***:
Most successful dual training system is practised in Germany.

***Source:*** The TVET Glossary of Terms, TESDA, Philippines, 2010

225 **Хөгжлийн бэрхшээлтэй суралцагч**

Төрөлхийн болон удамшлын эмгэг өөрчлөлт, эсхүл осол, гэмтлийн улмаас сэтгэц, оюун ухаан, мэдрэхүйн чадавх нь алдагдсан, түүнчлэн бие эрхтэн нь гэмтсэнээс суралцах боломж нь хязгаарлагдсан суралцагчийг хэлнэ.

***Эх сурвалж:*** МБС, мэргэшлийн түвшний тогтолцооны нэр томьёоны тайлбар толь, (МСС), УБ, 2011

**Student with disabilities**

A student whose learning opportunities are limited due to damages in physical limbs, loss of mental and feeling capacities because of accidents and/or natural and/or inherited phatogenic changes.

***Source:*** Glossary of Terms for Vocational Education, Training and National Qualifications System, (MCA), UB, 2011

226 **Хөдөлмөр эрхлэлт**

Хувь хүний ажил эсвэл аж ахуй эрхлэлт.

***Эх сурвалж:*** НҮБТМБСТ/ТМБС-ын толь бичиг

**Employment**

A person's work, occupation, job or business.

***Source:*** UNEVOC/TVETipedia Glossary;

227 **Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр**

Ажил эрхэлдэггүй хүмүүсийг ажил хөдөлмөртэй болгох зорилготой дэмжлэг үзүүлэх хөтөлбөр.

***Тайлбар***:
Ажил хөдөлмөр олгох хөтөлбөр нь гол төлөв мэргэжил дээшлүүлэх, ажил мэргэжлийн чиг баримжаа, дахин сургах буюу ажил хөдөлмөр эрэх, хайх, эзэмших чадвар дадал олгоход нь туслах замаар хэрэгжинэ.

***Эх сурвалж:*** МБС, мэргэшлийн түвшний тогтолцооны нэр томьёоны тайлбар толь, (МСС), УБ, 2011

**Employment support program**

Program aimed at providing opportunities to unemployed people to find jobs.

***Note***:
Employment support program mainly focuses on professional development, career guidance and re-training helping people acquire the skills to seek jobs and obtain qualification.

***Source:*** Glossary of Terms for Vocational Education, Training and National Qualifications System, (MCA), UB, 2011

**228 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан**

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааг улсын болон орон нутгийн төсвөөс хуваарилагдсан хөрөнгө ба бусад эх үүсвэрээр санхүүжүүлэх сан.

***Эх сурвалж:*** Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай МУ-ын хууль, 2011

**Employment support fund**

Employment support fund is established to support employment measures. This fund is compiled from different sources such as state budget, local budget and others.

***Source:*** Law of Mongolia on Employment Promotion, 2011

**229 Хөдөлмөр эрхлэлтийн түвшин**

Ажиллагчдын тоог эдийн засгийн идэвхтэй буюу хөдөлмөрийн насны хүн ам (15 ба түүнээс дээш насны)-ын тоонд харьцуулсан харьцаа.

***Эх сурвалж:*** Монгол – Англи хөдөлмөрийн нэр томьёоны тайлбар, товч толь, УБ, 2015

**Employment rate**

The number of persons in employment as a percentage of the population of working age (above 15 years of age).

***Source:*** Mongolian – English Glossary of Labour Terminology, UB, 2015

**230 Хөдөлмөрийн зах зээл**

Хөдөлмөр эрхлэхэд бэлэн байгаа хүмүүсийн нийлүүлэлт болон нээлттэй ажлын байрны хоорондын харьцааг тодорхойлсон тогтолцоо.

Хөдөлмөрийн зах зээл нь хөдөлмөрийн эрэлт, нийлүүлэлт бүхий эдийн засгийн тогтолцоо юм.

***Эх сурвалж:*** МБС-ын тайлбар толь, МБСҮТ Австрали, 2013

**Labour market**

The system of relationships between the supply of people available for employment and available jobs;

A labour market in an economy functions with demand and supply of labour.

***Source:*** Glossary of VET, NCVER 2013, Australia

**231 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн мэргэжил, ур чадвар**

Тусгай хэрэгцээт (янз бүрийн хөгжлийн бэрхшээлтэй) иргэдийг нийгэмшүүлэх зорилгоор тохирох хөдөлмөр эрхлэх, ажлын байраа хадгалж үлдэх, ажил, мэргэжлээ ахиулахад чиглэсэн үйл ажиллагаа.

***Эх сурвалж:*** МБС-ын тайлбар толь, МБСҮТ Австрали, 2013

**Vocational rehabilitation**

Measures aimed at enabling person with disabilites (differently abled) to secure, retain and advance in suitable employment and thereby to further that person’s integration into society.

***Source:*** Glossary of VET, NCVER, Australia, 2013

**232** **Хөрвөх ур чадвар**

Хувь хүний шинэ ажил, мэргэжил эсвэл боловсрол, сургалтын орчинд дасан зохицох чадвар.

***Тайлбар***:
- газарзүйн эсвэл ажил, үүргийн хүрээнд хөрвөж болдог (шинэ газар, пүүс компанид шинэ албан тушаал эсвэл шинэ ажил мэргэжил, эсвэл ажил хөдөлмөрийн салбараас боловсрол сургалтын салбарт шилжих)
- хөрвөх чадвар нь хувь хүмүүст шинэ ур чадвар эзэмшихэд нь тус дэм болсноор тэдний хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлдэг

***Эх сурвалж:*** Европын боловсрол, сургалтын бодлогын баримт бичиг, (Cedefop), 2011

**Mobility**

Ability of an individual to move and adapt to a new occupational or educational environment.

***Note***:
- mobility can be “geographical” or ‘functional’ (a move to a new place, a new position in a company or to a new occupation, a move between employment and education);
- mobility enables individuals to acquire new skills and thus increase their employability.

***Source:*** Terminology of European Education and Training Policy, Cedefop, 2011

**233** **Хөтөлбөр**

Урьдчилан тодорхойлсон суралцах зорилтыг хангах эсвэл тогтсон хугацаанд боловсролын багц агуулгыг эзэмшүүлэх зорилгоор бэлтгэн зохион байгуулах дэс дараатай цогц үйл ажиллагаа.

Боловсролын хөтөлбөрт боловсролын үйл ажиллагааг улс үндэсний хэмжээнд “дамжаа”, “модуль”, “нэгж”, “хичээл” зэрэг дэд бүрэлдэхүүн хэсгүүдэд хуваан ангилсан байдаг.

Хөтөлбөр нь томоохон бүрдэл хэсэгтэй байж болох ч гүйцэтгэлд суурилсан үйл ажиллагаа, дадлага ажил, судалгааны төсөл, эрдмийн зэрэг горилох бүтээл зэргийг агуулсан дамжаа, нэгж, модуль хэлбэртэй байж болно.

***Эх сурвалж:*** ЮНЕСКО, 2011

**Programme (education programme)**

A coherent set or sequence of educational activities designed and organized to achieve pre-determined learning objectives or accomplish a specific set of educational tasks over a sustained period.

Within an education programme, educational activities may also be grouped into sub-components variously described in national contexts as ‘courses’, ‘modules’, ‘units’ and/or ‘subjects’.

A programme may have major components nor normally characterised as courses, units or modules -for example, play-based activities, periods of work experience, research projects and the preparation of dissertations.

***Source:*** UNESCO, 2011

**234 Хөтөлбөрт шилжин орох**

Боловсролын нэг түвшнээс нөгөөд эсвэл боловсролын салбараас ажиллах хүчний эгнээнд шилжихэд бэлдэх хөтөлбөр, сургалт, дамжаа.

***Эх сурвалж:*** НҮБТМБСТ/ТМБС-ын толь бичиг

**Transition programme**

A programme, class or course designed to prepare people for the transfer from one level of education to the next, or from education to the workforce.

***Source:*** UNEVOC/TVETipedia Glossary

**235 Хувиараа хөдөлмөр эрхлэгч**

Хувиараа хөдөлмөр эрхлэгч гэж дангаараа болон бусадтай хамтран аж ахуй эрхэлж, татварын албанд бүртгүүлэн бизнесийнхээ үйл ажиллагаанд нөлөөлөх шийдвэрээ хараат бусаар бие даан гаргадаг иргэн.

***Эх сурвалж:*** Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, Монгол, 2011

**Self-employed**

Self- employed is an individual who runs business which is registered to the tax office independently or with others by making a business activity related decisions individually.

***Source:*** Law of Mongolia on Employment Promotion, 2011

**236 Хувиараа бизнес эрхлэх сургалт**

Аж ахуй эрхлэх арга ухаанд сургах, бизнес, аж ахуй эхлүүлэх, хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх төсөл, үйл ажиллагаагаар дамжуулан нийгэм, эдийн засгийн хөгжилд оролцох хүсэл сонирхолтой хүн бүрт мэдээлэх, зааж сургах, боловсрол олгох “албан ёсны сургалтын бүрдэл” гэж тодорхойлдог.

*Хувиараа бизнес эрхлэх сургалт* гэдэг нь суралцах хэтийн төлөв болон цаашдын бусад боломжоо өргөжүүлэн баяжуулахад суралцагчдад шаардлагатай үнэ цэнэ, чадваруудыг олгох замаар хувь хүний бүтээлч санаа, авьяас чадварт нийцүүлэн өөртөө итгэх итгэлийг хөгжүүлэх зорилго бүхий өргөн хүрээний үйл ажиллагаа.

***Эх сурвалж:*** ЮНЕСКО, ОУХБ, 2007

**Entrepreneurship education/training**

Entrepreneurship education/training has been defined as “a collection of formalized teachings that informs, trains, and educates anyone interested in participating in socioeconomic development through a project to promote entrepreneurship awareness, business creation, or small business development”.

Enterprise education (also called *entrepreneurial education*/training on the other hand) is usually conceived more broadly, seeking to foster self-esteem and confidence by drawing on the individual’s talents and creativity, while building the relevant skills and values that will assist students in expanding their perspectives on schooling and opportunities beyond. Methodologies are based on the use of personal, behavioural, motivational, attitudinal and career planning activities.

***Source:*** UNESCO/ILO, 2006

**237 Хувийн өмчийн МБС-ын байгууллага**

Төрийн өмчийн бус сургалтын байгууллага, үүнд арилжааны сургалтын байгууллагууд (ашиг олох зорилгоор хувь хүн, пүүс компанийн ажилчдад курс, дамжаа явуулах), олон нийтийн сургалтын байгууллагууд (Засгийн Газар эсвэл олон нийтийн зүгээс санхүүждэг ашгийн бус байгууллагууд), үйлдвэр аж ахуйн нэгжийн сургалтын байгууллагууд (пүүс компани эсвэл бусад байгууллагууд голчлон өөрсдийнхөө ажилчдад сургалт явуулах), аж үйлдвэрийн салбарын сургалтын байгууллагууд (тухайн аж үйлдвэрийн салбарын хүрээнд бүхэлд нь сургалт явуулдаг байгууллагууд) хамаарна.

***Эх сурвалж:*** МБС-ын тайлбар толь, МБСҮТ Австрали, 2013

**Private TVET provider**

A non-governmental training organisation, including commercial providers (providing courses to industry and individuals for profit), community providers (non-profit organisations, funded by government or community sponsors), enterprise providers (companies or other organisations providing training mainly for their own employees), and industry providers (organisations providing training to enterprises across an industry).

***Source:*** Glossary of VET, NCVER, Australia, 2013

**238 Хүн амын бичиг үсэг тайлагдалтын түвшин**

Бичиг үсэг мэддэг 15 ба түүнээс дээш насны хүн амын тоог тухайн насны бүх хүн амын тоонд харьцуулж, бичиг үсэг тайлагдалтын хувийг тодорхойлно.

***Эх сурвалж:*** Боловсролын статистикийн үзүүлэлт тооцох аргачлал, ҮСХ, УБ, 2013

**Literacy rate**

The proportion (in percent) of adult population (15 years old and above) who can read and write to total adult population.

***Source:*** Methods to Calculate Educational Statistics, NSO, UB, 2013

**239 Хүлээн зөвшөөрөх, баталгаажуулах**

Мэргэжлийн боловсрол, сургалтын салбарын сургалтын байгууллагын бүтээгдэхүүн, үйлчилгээг үндэсний, бүс, орон нутгийн хүрээнд албан ёсоор баталгаажуулах.

МБС-ын салбарын хүрээнд (улсын болон орон нутгийн хууль тогтоомжийн дагуу) үйл ажиллагаа явуулж байгаа сургалтын байгууллага, бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээг албан ёсоор баталгаажуулах.

Албан ёсоор баталгаажуулах: мэргэжил, мэргэшил олгох (сертификат, диплом, цол зэрэг олгох), тэдгээртэй тэнцэх бичиг баримт, кредит олгох эсвэл дүйцүүлэх, эзэмшсэн ур чадвар, чадамжийг баталгаажуулах замаар ур чадвар, чадамжид албан ёсны статус олгох үйл явц.
Нийгмийн хүрээнд баталгаажуулах: эдийн засаг, нийгмийн оролцогч талуудаас хувь хүний ур чадвар, чадамжийн үнэ цэнийг хүлээн зөвшөөрөх.

***Эх сурвалж:*** МБС мэргэшлийн түвшний тогтолцооны нэр томьёоны тайлбар толь, (МСС), УБ, 2011

**Recognition, validation**

Official validation (national, regional level in accordance with relative legislation) of products and services of training institutions of vocational education and training sector.

The formal approval of training organisations, products and services operating within the vocational education and training (VET) sector (as defined by state and territory legislation).

*Formal recognition*: the process of granting official status to skills and competences: through the award of qualifications (Certificates, diploma or titles); through the grant of equivalence, credit units or waivers, validation of gained skills and/or competences.

*Social recognition*: the acknowledgement of the value of skills and/or competences by economic and social stakeholders.

***Source:*** Glossary of Terms for Vocational Education, Training and National Qualifications System, (MCA), UB, 2011

240 **Хүний хөгжлийн индекс (ХХИ)**

Хүний хөгжлийн түвшнийг илэрхийлэгч, хүний хөгжлийн урт хугацааны төлөв байдлын ерөнхий дүр зургийг харуулах, хүний хөгжлийг хэмжих нийлмэл үзүүлэлт.

Хүний чадавхын хөгжлийг харуулах бөгөөд эрүүл саруул байж, урт удаан наслах; эрдэм мэдлэг эзэмших; амьжиргааны зохистой нөхцөлд аж төрөх гэсэн хүний амьдралын үндсэн гурван хэмжигдэхүүнээр илэрхийлэгдэнэ.

Бодит орлогын өсөлтөөс гадна хүмүүсийн урт удаан, эрүүл саруул амьдрах, мэдлэг ур чадвар эзэмших, амьдралын стандартыг хангах материаллаг нөөц хүртэж эдлэх чадварыг харуулах нийгмийн үзүүлэлтүүдээр тухайн улс орныг хэмжих хэмжүүр.

***Эх сурвалж:*** ТМБС-ын тайлбар толь, ТБУЧХА, Филиппин, 2010

**Human Development Index (HDI)**

Comprehensive indicator to measure, express level of human development and outline the overall long term tendency thereof.

It expresses the human capacity development through 3 main measurement of life such as proper living conditions, acquire knowledge and education and live a long healthy life. Measure of how well a country has performed, not only in terms of real income growths, but also interms of social indicators of people’s ability to lead a long and healthy life, to acquire knowledge and skills and to have access to the resources needed to afford a decent standard of living.

***Source:*** The TVET Glossary of Terms, TESDA, Philippines, 2010

241 **Хүний нөөцийн хөгжил (ХНХ)**

Хувь хүний хувийн болон зохион байгуулалтын ур чадвар, мэдлэг, чадварыг хөгжүүлэх тогтолцоо.

Хүний нөөцийн хөгжил гэдэгт ажилчдыг сургах, албан тушаал дэвшүүлэх, гүйцэтгэлийг сайжруулж, хөгжүүлэх, дадлагажуулах,

зөвлөн чиглүүлэх, ажилчдын залгамж холбоог төлөвлөх, гол үүрэг бүхий ажилчдыг илрүүлэх, сургалтын төлбөрт туслалцаа үзүүлэх, байгууллагын хөгжил зэрэг асуудлууд хамаарна.

***Эх сурвалж:*** Хүний нөөцийн хөгжил гэж юу вэ?, Сюзан М. Хэффилд , 2016

**Human Resource Development (HRD)**

The framework for helping individuals develop their personal and organizational skills, knowledge, and abilities.

Human Resource Development includes such opportunities as employee training, employee career development, performance management and development, coaching, mentoring, succession planning, key employee identification, tuition assistance, and organization development.

***Source:*** What is Human Resource Development Heathfield, S. 2016

242 **Хүртээмж**

Сургалтад элсэхэд суралцагчийн мэдлэг, чадвар, чадамжийн түвшинд тавигдах шаардлага.

МБС байгууллагын хөтөлбөрт хамрагдахад тавигдах шаардлага, нөхцөлүүд (мэдлэг, ур чадвар, мэргэшил, боловсролын түвшин, чадамж, ажлын туршлага г.м).

***Эх сурвалж:*** Мэргэжлийн боловсрол, сургалт, мэргэшлийн түвшний тогтолцооны нэр томьёоны тайлбар толь, (МСС), УБ, 2011

**Access**

Conditions, circumstances or requirements (such as qualifications, education level, competences or work experience) governing admittance to and participation in VET institutions or programmes.

***Source:*** Glossary of Terms for Vocational Education, Training and National Qualifications System, (MCA), UB, 2011

# Ц

243 **Цаашдын сургалт**

Анхан шатны дараах буюу нэмэлт сургалт.

***Тайлбар***:
- Өмнөх сургалтаар олж авсан мэдлэг, чадвар дадал, чадамжийг бататгаж, дээшлүүлэхэд чиглэгдсэн анхан шатны мэргэжлийн сургалтын дараах тодорхой зорилго бүхий богино-хугацааны сургалт.
- Голчлон анхан шатны мэргэжлийн сургалтын дараа явагдах богино хугацаат, зорилтот сургалт бөгөөд өмнөх сургалтаар олж авсан мэдлэг, ур чадвар, чадамжийг баяжуулж, сайжруулж, дээшлүүлэх зорилготой байдаг.

***Эх сурвалж:*** МБС-ын тайлбар толь, МБСҮТ Австрали, 2013

**Further training**

Training taken in addition to after initial training.

***Note***:
- Short term training with specific objective, taken after initial

vocational training aiming to upgrade and or fulfill the competency, skills and knowledge obtained from previous training. Training subsequent and complementary to initial training.
- A short-term targeted training typically provided following initial vocational training, and aimed at supplementing, improving or updating knowledge, skills and/or competences acquired during previous training.

***Source:*** Glossary of VET, NCVER, Australia, 2013

**244** **Цахим сургалт**

Аливаа агуулгыг дамжуулах, олж авахад зориулагдсан сургалтын дижитал хэрэгслийг ашиглах тухай ухагдахуун.

Өөрөөр хэлбэл цахим сургалт нь мэдээлэл, холбооны технологийн тусламжтайгаар зохион байгуулагдах сургалт юм.

***Эх сурвалж:*** НҮБТМБСТ/Нээлттэй зайны сургалт-үндсэн нэр томьёо, тодорхойлолт, COL, 2015
Төв Европын МБС–ын толь бичиг, (Cedefop), 2015

**E-Learning**

E-Learning is an umbrella term that refers to the use of any digital device for teaching and learning, especially for delivery or accessing of content.

In other words, e-learning is Learning supported by Information and Communication Technologies (ICT).

***Source:*** UNEVOC/Open and Distance Learning – Key Terms & Definitions, COL, 2015 Terminology of European education and training policy, Cedefop, 2015

# Ч

**245** **Чадамж**

Чадамж нь мэдлэг, чадвар, хандлагын хангалттай түвшин, төрөл бүрийн нөхцөлд эдгээрийг зохистой хэрэглэх чадварыг илэрхийлнэ.

